

ДЭЛГЭРИЙН БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОЛОН
УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТОЙМ

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

Зохиогч:	Д.Баярсайхан
Эх бэлтгэсэн:	Б.Бүжидмаа
Цаасны хэмжээ:	210x297
Хэвлэлийн хуудас:	28.0

ГАРЧИГ

УДИРТГАЛ	5
A. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОЛОН УЛСЫН ОЛОН ТАЛТ ГЭРЭЭ	7
I БҮЛЭГ. ДЭЛХИЙН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД	9
1. Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (Дэлхийн гаалийн байгууллага байгуулах тухай Конвенц).....	10
2. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенц (БТКУС-ийн Конвенц).....	25
3. Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц (Киотогийн Конвенц)	27
4. Түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц).....	30
5. ТИР карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай Конвенц (ТИР Конвенц).....	37
6. Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох зорилгоор байгууллага хооронд харилцан туслах тухай олон улсын Конвенц (Найробийн Конвенц)	42
7. Гаалийн асуудлаар байгууллагын хүрээнд харилцан туслах тухай Конвенц (Йоханнесбургийн Конвенц).....	44
8. Гаалийн байгууллага дахь сайн засаглал, ариун шударга ёсны тухай тунхаглал (Арушагийн тунхаглал).....	48
9. Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх тухай багц стандарт (Аюулгүй байдлын багц стандарт)	53
II БҮЛЭГ. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД	59
10. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (ДХБ-ын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр)	60
11. 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Демпингийн эсрэг татварын тухай Хэлэлцээр).....	80
12. 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (ДХБ-ын Үнэлгээний Хэлэлцээр).....	84
13. Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр.....	87
14. Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр.....	92
15. Татаас болон нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр.....	98
16. Худалдааг хөнгөвчлөх тухай Хэлэлцээр	103
III БҮЛЭГ. НҮБ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨРӨӨС ХЯНАЛТ ТАВИН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД	107
17. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (Вашингтоны Конвенц).....	108
18. Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенц (Венийн Конвенц)	109
19. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол (Монреалийн протокол).....	114
20. Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенц (Базелийн Конвенц).....	119
21. Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенц (Роттердамын Конвенц)	131
22. Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц.....	137
23. Био аюулгүй байдлын тухай Картагены протокол (Картагены протокол)	139

24. Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенц (Стокгольмын Конвенц)	142
IV БҮЛЭГ. НҮБ-ЫН БУСАД БАРИМТ БИЧГҮҮД	147
25. Мансууруулах эмийн тухай нэгдсэн Конвенц	148
26. Сэтгэцэд нөлөөт бодисын тухай Конвенц	151
27. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Конвенц (Венийн Конвенц)	152
28. Дипломат харилцааны тухай Венийн Конвенц	155
29. Консулын харилцааны тухай Венийн Конвенц	160
30. Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай НҮБ-ын Конвенц	165
31. Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (Женевийн Конвенц)	168
32. Соёлын үнэт зүйлсийн (соёлын өвийн) хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-гийн Конвенц	169
33. Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр (АНДЭЗНК-ын хэлэлцээр)	172
34. Ази, Номхон далайн (бүс нутгийн орнуудын) хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр (АНДЭЗНК-ын хэлэлцээр)	174
V БҮЛЭГ. ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД	177
35. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын Конвенц (Парисын Конвенц)	178
36. Утга зохиол болон уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц (Бернийн Конвенц)	182
37. Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (ТРИПС-ийн Хэлэлцээр)	186
38. Зохиогчийн эрхийн тухай ДОӨБ-ын гэрээ	189
VI БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ШУУДАН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН АГААРЫН ЗАМЫН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН АВТО ЗАМЫН ТЭЭВЭР, ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД	191
Олон улсын тээврийн холбогдох байгууллага, тэдгээрийн хүрээнд мөрддөг баримт бичгүүд	192
Б. ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ (ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХУДАЛДААНЫ, ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН) ХЭЛЭЛЦЭЭР	197
VII БҮЛЭГ. ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ОЛОН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР	199
39. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр	200
VIII БҮЛЭГ. ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХОЁР ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР	203
40. Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улс хоорондын хэлэлцээр	204
В. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ БУСАД ГЭРЭЭ	215
IX БҮЛЭГ. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХОЁР ТАЛТ ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ	217
IX БҮЛЭГ. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ	221
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	224

УДИРТГАЛ

“Монгол Улсын олон улсын гэрээ” гэдэг нь Олон улсын гэрээний тухай Монгол Улсын 2016 оны хуульд зааснаар Монгол Улс, Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг болон хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, эсхүл олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах, түүний төрөл, нэрнээс үл хамааран хоёр болон олон талын бичгээр үйлдсэн нэг, эсхүл өөр хоорондоо холбоотой хоёр болон хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа олон улсын тохиролцоо (ОУГТХ, 3.1.1) болно. Өөрөөр хэлбэл, тухайн тохиролцоонд “бүрэн эрхийн итгэмжлэл” (Монгол Улсыг төлөөлж олон улсын гэрээнд гарын үсэг зурах зэрэг Монгол Улс олон улсын гэрээг заавал биелүүлэх зөвшөөрлийг илэрхийлэх болон гэрээтэй холбоотой бусад үйлдлийг гүйцэтгэх эрхийг эрх бүхий байгууллагаас тодорхой албан тушаалтанд олгосныг нотолж байгаа баримт бичиг - ОУГТХ, 3.1.2) бүхий этгээд гарын үсэг зурсан байх ёстой. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас гадаад улсын адил байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай байгуулах байгууллага хоорондын гэрээ (ОУГТХ, 4.2), мөн Монгол Улсын Засгийн газраас гадаадын хуулийн этгээд, иргэнтэй байгуулах, олон улсын хувийн эрх зүйгээр зохицуулагдах бизнесийн хэлцэл, гэрээ (ОУГТХ, 4.5) энэ нэр томъёонд хамаарахгүй. Гэвч төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлаар энэ хуульд заасны дагуу Засгийн газраас олон улсын гэрээ байгуулах эрх авсны үндсэн дээр Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын олон улсын гэрээ байгуулж болно (ОУГТХ, 6.4).

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн 1969 оны Конвенц болон дээрх хуульд зааснаар, олон улсын гэрээний нэр, төрөл ямар ч байж болно. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд дараах нэртэй байдаг:

- конвенц (convention - конвенция): түгээмэл нэр;

- хэлэлцээр (agreement - соглашение): түгээмэл нэр;
- протокол (protocol - протокол): Тухайлбал, Мансууруулах эмийн тухай 1961 оны Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1971 оны Протокол (the 1971 Protocol Amending the Single Convention on Narcotic Drugs, 1961);
- гэрээ (treaty - договор): Тухайлбал, Версалийн гэрээ (The Treaty of Versailles, 1919);
- тунхаглал (declaration - декларация): Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл Тунхаглал (the Universal Declaration of Human Rights, 1948);
- меморандум (memorandum - меморандум): Тухайлбал, Африк, Карибийн тэнгис, Номхон далайн улсуудын бүлэг болон Дэлхийн гаалийн байгууллага хоорондын Итгэлцлийн меморандум (2011 оны 2 дугаар сарын 4, Брюссель хот) (the Memorandum of Understanding between The African, Caribbean and Pacific (ACP) Group and the WCO);
- пакт (covenant - пакт): Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (the International Covenant on Economic, Social and Cultural Rights (ICESCR), 1966);
- харти (charter - хартия): Тухайлбал, Олимпийн Харти (the Olympic Charter, сүүлийн удаа 2010-2-11-нд шинэчилсэн);
- дүрэм (charter - устав): Тухайлбал, НҮБ-ын Дүрэм (the UNO Charter, 1945);
- дүрэм (statute - устав): Тухайлбал, Олон улсын шударга ёсны шүүхийн Дүрэм (The Statute of the International Court of Justice, 1945);
- кодекс (code - кодекс): Тухайлбал, ТХЕХ-ийн Гаалийн үнэлгээний кодекс (the GATT Customs Valuation Code, 1979);
- үндсэн хууль (constitution - конституция): Дэлхийн шуудангийн холбооны Үндсэн хууль (the Constitution of the UPU, 1964), г.м.;

Монгол Улс болон Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээг гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичгийг солилцох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох, эсхүл эдгээртэй адилтгах бусад аргаар байгуулна (ОУГТХ, 3.1.1).

Олон улсын гэрээ нь түүний Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд заавал дагаж мөрдөх баримт бичиг байна. Монгол Улсын хувьд, олон улсын гэрээний заалт манай хууль тогтоомжийн заалттай зөрчилдвөл Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

“Монгол Улсын гаалийн холбогдолтой олон гэрээний тойм” хэмээх энэ номонд Монгол Улсын гаалийн холбогдолтой олон улсын гэрээг дараах 3 хэсэгт хуваан, тоймлон танилцуулж байна:

- A. Гаалийн холбогдолтой олон улсын олон талт гэрээ
- B. Чөлөөт худалдааны (хөнгөлөлттэй худалдааны эдийн засгийн түншлэлийн) хэлэлцээр
- B. Гаалийн холбогдолтой бусад гэрээ

“Олон улсын олон талт гэрээ”-ний хэсэгт гаалийн хяналт, бүрдүүлэлтэд шууд хамааралтай Дэлхийн гаалийн байгууллагын баримт бичгүүд (I бүлэг), Дэлхийн худалдааны байгууллагын баримт бичгүүд (II бүлэг), НҮБ-ын Байгаль орчныг хамгаалах хөтөлбөрөөс хяналт тавин хэрэгжүүлж буй баримт бичгүүд (III бүлэг), НҮБ-ын бусад баримт бичгүүд (IV бүлэг), Дэлхийн оюуны өмчийн байгууллагын баримт бичгүүд (V бүлэг), мөн тэдгээртэй холбоотой бусад мэдээллийг оруулав. Эдгээр гэрээний монгол орчуулга нь төрийн албан ёсны хэвлэлүүдэд нийтлэгдсэн байгаа. Тухайлбал, “Монгол Улсын нэгдсэн орсон гаалийн эрх зүйн салбарын олон конвенц, протокол” гэсэн хууль тогтоомжийн эмхэтгэл “Төрийн мэдээлэл”-ийн 2017 оны тусгай дугаар №12-т гаалийн холбогдолтой 7 конвенц нийтлэгдсэн байгаа. Бас Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийг “Төрийн мэдээлэл”-ийн 2016 оны тусгай дугаар №10-т нийтэлсэн байгаа.

Олон улсын гэрээ биш хэдий ч ДГБ-аас 2003 онд гаргасан Гаалийн байгууллага дахь сайн засаглал, ариун шударга ёсны тухай тунхаглал (Арушагийн тунхаглал), Аюулгүй байдлын багц стандартын 2015 оны хувилбарын талаар I бүлэгт оруулав.

“Олон улсын олон талт гэрээ”-ний хэсгийн VI бүлэгт олон улсын шуудангийн тээвэр, олон улсын усан замын тээвэр, олон улсын агаарын замын тээвэр, олон улсын авто замын тээвэр, олон

улсын төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн олон улсын байгууллагын товч танилцуулгыг оруулж, тэдгээрээс боловсруулан батлуулж, хяналт тавин хэрэгжүүлж буй 30 орчим баримт бичгийн жагсаалтыг гаргав.

Энэхүү номын “Б. Чөлөөт худалдааны (хөнгөлөлттэй худалдааны эдийн засгийн түншлэлийн) хэлэлцээр” хэсэгт шинээр VII, VIII бүлэг нэмж (хуучин VII бүлгийг IX бүлэг болгов), Ази, номхон далайн худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийн талаар орууллаа. “B. Гаалийн холбогдолтой бусад гэрээ” хэсэгт “Олон улсын хоёр талт гэрээ”-ний IX бүлэг, “Гаалийн холбогдолтой гурван талт гэрээ”-ний X бүлгийг оруулав. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээрийн талаар “Дэлхийн худалдааны байгууллага” гэсэн II бүлэгт оруулсан байгаа.

НҮБ-ын Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг “Нэгдсэн Үндэстний Байгууллагын баримт бичгүүд” гэсэн III бүлэгт нэмж оруулав.

“Монгол улсын гаалийн холбогдолтой олон улсын гэрээний тойм” номны энэхүү хоёр дахь хэвлэлтийн өөр нэг онцлох зүйл нь гэвэл 2011 оны нэг дэх хэвлэлтийн I бүлгийн конвенц, хэлэлцээрийн зарим үг үсэг, нэр томъёог 2016-2017 онд дахин хянаж, дээр дурдсан “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2017 оны тусгай дугаар №12-т нийтэлсэн 7 конвенц, хэлэлцээрийн орчуулгатай нийцүүлэн өөрчилсөн явдал болно (нэг дэх хэвлэлтийн тэдгээр үг үсэг, нэр томъёо нь тухайн үед УИХ-д өргөн барьсан орчуулгаар байсан юм). Түүнчлэн энэхүү хоёр дахь хэвлэлтэд ДГБ, түүний Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын бүтцийн өөрчлөлтийг тусгаж, гэрээний Хэлэлцэн тохирогч Талуудын тоог шинэчилж, ДГБ-ын ажлын нэгжүүд (working bodies)-ийн чуулга, уулзалтын талаарх мэдээллийг нөхөн гүйцээж, тэдгээрт 2011 оноос хойш Монгол Улсаас оролцсон хүмүүсийн нэрсийг нэмж оруулав. Бас өөр бусад бага сага өөрчлөлт оруулсны зэрэгцээ ДГБ-ын Гаалийн үнэлгээний компендиум 2015 онд, Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх Аюулгүй байдлын багц стандартын 2015 оны хувилбар 2018 онд тус тус монгол хэлээр хэвлэгдсэн, мөн Гаалийн албадаас оюуны өмчийн эрхийн зөрчилтэй тэмцэх төр цагийн глобал стандарт батлагдаагүй өнгөрсөнтэй холбогдуулан эдгээр баримт бичгийн текстийг хассан байгаа.

**А. ГААЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ
ОЛОН УЛСЫН ОЛОН ТАЛТ ГЭРЭЭ**

CUSTOMS RELATED
INTERNATIONAL MULTILATERAL TREATIES

МЕЖДУНАРОДНЫЕ
МНОГОСТОРОННИЕ ДОГОВОРЫ,
ОТНОСЯЩИЕСЯ К ТАМОЖЕННЫМ ДЕЛАМ



Дэлхийн гаалийн байгууллага

The World Customs Organization

Всемирная Таможенная Организация (ВТамО, ВТАО)

(Бельги Улсын Брессель хот, 1952)

I БҮЛЭГ

ДЭЛХИЙН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД

- Олон улсын авто тээврийн байгууллагын хүрээнд баталж, ДГБ-аас хяналт тавин хэрэгжүүлж буй ТИР Конвенцийг энд оруулав.
- Гаалийн үнэлгээний хэлэлцээр болон Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн талаарх мэдээлэл ДХБ-ын баримт бичгийн бүлэгт байгаа.



1. Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (Дэлхийн гаалийн байгууллага байгуулах тухай Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	Convention Establishing a Customs Co-operation Council (The WCO Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о создании Совета таможенного сотрудничества
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1950-12-15. Бельги Улсын Брюссель хот (Brussels, Belgium)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1952-11-04
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2019 оны 9 дүгээр сарын байдлаар: 183 Гишүүнтэй. Үүнээс тусгаар тогтносон улс - 178, нутаг дэвсгэр - 4 (Нидерланд Улсын Антиллын арлууд, Бермуда, Гонконг, Макао), гаалийн буюу эдийн засгийн холбоо - 1 (Европын холбоо)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1991-05-31
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1991-09-17
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1991-09-17
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	Конвенцийн VIII(а)-д Гаалийн, эсхүл Эдийн засгийн холбооны саналын эрхийг ДГБ-аас тусгайлан заах тухай, мөн XVIII зүйлд уг холбоог тодорхойлж, Конвенцид хэрхэн нэгдэн орох тухай нэмэлт оруулах зөвлөмжийг ДГБ-аас 2007 оны 6 дугаар сарын 30-нд баталсан. Тэр нь хүчин төгөлдөр болоогүй байна. ДГБ-ын бүх гишүүд хүлээн зөвшөөрсөн баримт бичгээ гэрээ хадгалагчид гардуулсны дараа хүчин төгөлдөр болно. Гэвч ДГБ-ын 2007 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэрээр Европын холбоо 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн түр хугацаагаар (ДГБ-ын бүрэн эрхт Гишүүн болох хүртэл) ДГБ-ын Гишүүдийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх болсон байгаа.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- "Олон улсын зарим конвенцид нэгдэн орох тухай" Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 163 дугаар тогтоол

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

ДГБ нь гаалийн асуудлаар дагнасан, засгийн газар хоорондын олон улсын цорын ганц байгууллага (the only intergovernmental organization) юм. Албан ёсны нэр (official name) нь “Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл” (Customs Co-operation Council - CCC)(Конвенцийн I зүйл). 1994 оноос “Дэлхийн гаалийн байгууллага” (the World Customs Organization - WCO)(ДГБ) гэсэн ажлын албан бус нэр (informal working name)-тэй болсон. Үүнтэй холбогдуулан уг Конвенцид өөрчлөлт оруулаагүй.

ДГБ нь гаалийн олон улсын стандартыг хөгжүүлэх (the development of global standards), гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах (the simplification and harmonisation of Customs procedures), бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хангах (trade supply chain security), олон улсын худалдааг хөнгөвчлөх (the facilitation of international trade), гаалийн хууль дүрмийг сайн дураараа дагаж мөрдөх, эсхүл албадан сахиулах ажиллагааг боловсронгуй болгох (the enhancement of Customs enforcement and compliance activities), хуурамч бараа, оюуны өмчийн хулгайтай тэмцэх (anti-counterfeiting and piracy initiatives), төрийн байгууллага, хувийн секторын түншлэлийг хөгжүүлэх (public-private partnerships), шударга ёсыг сахиулах (integrity promotion), гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх тогтвортой хөтөлбөрүүд хэрэгжүүлэх (sustainable global Customs capacity building programmes) зэрэг чиглэлээр

ажилладаг. Түүнчлэн ДГБ нь барааны олон улсын ангилалд хөдөлгөөн хийх (maintains the international Harmonized System goods nomenclature), Дэлхийн худалдааны байгууллагын үнэлгээ болон гарал үүслийн тухай Хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх техник ажлыг хийдэг (administers the technical aspects of the WTO Agreements on Customs Valuation and Rules of Origin).

ДГБ нь жилд 2-оос доошгүй удаа чуулна (Конвенцийн VII(c)). ДГБ нэг хэсэг 2 жил дараалан төв байрандаа, завсарт нь нэг жил өөр нэг гишүүн оронд чуулдаг байсан (Конвенцийн VII(b)). Чуулганы хуралдааныг Дэлхийн гаалийн байгууллагын дарга (a WCO Chairman) тэргүүлнэ. ДГБ нь жил бүр дарга (a Chairman), хоёроос доошгүй орлогч дарга (not less than two Vice-Chairman)-ыг сонгоно (Конвенцийн VI(a)). Гишүүн орон бүр нэг төлөөлөгч (one delegate), нэг буюу түүнээс дээш тооны орлогч (one or more alternates)-ийг чуулганд өөрийн төлөөлөгчөөр томилон оролцуулна. Тэдгээр нь зөвлөхүүдтэй байж болно (may be assisted by advisers) (Конвенцийн II(c)). ДГБ-ын гишүүн орон бүр хүчин төгөлдөр болсон боловч өөрөө нэгдэн ороогүй Конвенцийг тайлбарлах, хэрэглэх, тийм Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулахаас бусад бүх асуудлаар саналын нэг эрхтэй байна (Конвенцийн VIII(a)).

ГХАЗ (өөрөө 1952 онд байгуулагдсан гэж үздэг) нь дараах ажлын нэгжүүд (Working Bodies)-ийг байгуулан ажиллаж байна. Дараах зурагт ажлын нэгжүүдийн товч мэдээллийг үзүүлээ.

Хүснэгт 1. ДГБ-ын ажлын нэгжүүд

<ul style="list-style-type: none"> • Бодлогын комисс (Policy Commission - 1978)
<ul style="list-style-type: none"> • Аудитын хороо (Audit Committee) • Хувийн хэвшилтэй зөвлөлдөх баг (Private Sector Consultative Group - 2005) • Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх ажлын хэсэг (SAFE Working Group - 2007)
<ul style="list-style-type: none"> • Чадавхийг бэхжүүлэх хороо (Capacity Building Committee - 2010)
<ul style="list-style-type: none"> • Ёс зүйн дэд хороо (Integrity Sub-Committee - 2001)
<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хороо (Finance Committee - 1953)
<p><i>Тариф, худалдааны асуудлаар (Tariff and Trade Affairs):</i></p>
<ul style="list-style-type: none"> • Уялдуулсан системийн хороо (The Harmonized System Committee - 1988) <ul style="list-style-type: none"> • Уялдуулсан системийг хянах дэд хороо (The Harmonized System Review Sub-Committee (RSC) - 1988) • Уялдуулсан системийн ажлын хэсэг (The Harmonized System Working Party - 1988) • Гарал үүслийн техникийн хороо (The Technical Committee on Rules of Origin (TCRO) - 1995) • Гаалийн үнэлгээний техникийн хороо (The Technical Committee on Customs Valuation (TCCV) - 1995) • Шилжих үнэ судлах бүлэг (Focus Group on Transfer Pricing - 2007) • Эрдэм шинжилгээний дэд хороо (The Scientific Sub-Committee - 1987)


Горим журам болон худалдааг хөнгөвчлөх асуудлаар (Procedures and Facilitation):

- Техникийн байнгын хороо (The Permanent Technical Committee - 1950) (Конвенцийн V зүйл) (Гишүүн орон бүр нэг төлөөлөгч (one delegate), нэг буюу түүнээс дээш тооны орлогч (one or more alternates)-ийг ТБХ-нд өөрийн төлөөлөгчөөр томилон оролцуулж болно. Тэдгээр нь зөвлөхүүдтэй байж болно (may be assisted by advisers) (Конвенцийн X(a)) - жилд 4-өөс доошгүй удаа хуралдана.
- Мэдээллийн удирдлагын дэд хороо (Information Management Sub-Committee - 1996)
- Шинэчлэн найруулсан Киотогийн Конвенцийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах хороо (Revised Kyoto Convention Management Committee - 1999)
- Стамбулын Конвенцийн гүйцэтгэх хороо (Istanbul Convention Administrative Committee - 1994)
- АТА карнейн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талуудын гүйцэтгэх хороо (Administrative Committee of Contracting Parties to the ATA Convention - 1963)
- Агаарын ачааны аюулгүй байдлыг хангах техник ажиллагааны шинжээчдийн бүлэг (Air Cargo Security (ACS) Technical Experts Group - 2011)
- Зорчигчийн мэдээллийг урьдчилан дамжуулах тухай болон Зорчигчийн нэрсийн бүртгэл мэдээллийн тухай ДГБ, Агаарын тээврийн олон улсын агентлаг, Олон улсын иргэний нислэгийн байгууллагын хамтарсан зөвлөмжийн асуудлаар холбоо барих хороо (The Contact Committee for the WCO/IATA/ICAO Guidelines on Advance Passenger Information (API) & Passenger Name Record (PNR) Data - 2004)
- Олон улсын шуудангийн холбоо, ДГБ-ыг холбоо барих хороо (UPU/WCO Contact Committee - 1965)
- Чингэлгийн тухай 1972 оны гаалийн Конвенцийн гүйцэтгэх хороо (Administrative Committee for the Customs Convention on Containers, 1972 - 1976)
- Гаалийн байгууллагын глобал сүлжээ бүтээн байгуулах тусгай бүлэг (Ad Hoc Group on Globally Networked Customs (GNC) - 2008)

Хууль журам мөрдөн сахиулах болон албадан сахиулах асуудлаар (Compliance and Enforcement):

- Хууль журам сахиулах хороо (The Enforcement Committee - 1983)
 - Худалдааны луйврын асуудал эрхэлсэн ажлын хэсэг (Working Group on Commercial Fraud - 2005)
 - Хууль журам сахиулах гаалийн сүлжээг удирдан зохион байгуулах бар (Customs Enforcement Network Management Team (CENMat) - 2001)
 - ДГБ-ын Худалдааны луйвар болон оюуны өмчийн зөрчлийн асуудал эрхэлсэн ажлын хэсэг (WCO Counterfeiting and Piracy (CAP) Group - 2009)
 - Цахим гэмт хэрэг мөрдөн шалгах шинжээчдийн бар (Electronic Crime Expert Group (ECEG) - 2001)
 - Мэдээлэл, дүн шинжилгээний глобал стратеги боловсруулах төслийн бүлэг (Global Information and Intelligence Strategy Project Group (The GIS Project Group) - 2002)

Зураг 1. ГЗАХ буюу ДГБ-ын бүтэц




Хүснэгт 2. ДГБ-ын дарга нар (Chairmen of the Council)

№	Алба хашсан жил	Нэр	Улс
1	26 Jan 1953 - 14 Jun 1954	Georges DeGois	France
2	14 Jun 1954 - 25 Nov 1957	Arthur David Kemp Owen	UK
3	25 Nov 1957 - 30 Nov 1959	Willem Hendrik van den Berge	The Netherlands
4	30 Nov 1959 - 5 Dec 1961	Knud Korst	Denmark
5	5 Dec 1961 - 4 Dec 1962	Josef Stangelberger	Austria
6	4 Dec 1962 - 1 Dec 1964	Philippe Waldruche de Montremy	France
7	1 Dec 1964 - 1 Jun 1965	Sir John Anderson	UK
8	1 Jun 1965 - 30 Nov 1965	Ayodele Diyan (acting)	Nigeria
9	30 Nov 1965 - 30 Jun 1967	Charles Lenz	Switzerland
10	1 Jul 1967 - 30 Jun 1969	Bartholomew Culligan	Ireland
11	1 Jul 1969 - 30 Jun 1970	Vнктор Castro Sanmartнн	Spain
12	1 Jul 1970 - 30 Jun 1972	Lennart Eriksson	Sweden
13	1 Jul 1972 - 30 Jun 1974	Hans Hutter	West Germany
14	1 Jul 1974 - 30 Jun 1976	Shri Jasjit Singh	India
15	1 Jul 1976 - 30 Jun 1978	Jiћн Broћ	Czechoslovakia
16	1 Jul 1978 - 30 Jun 1980	Jack Alexander McLeod Kean	New Zealand
17	1 Jul 1980 - 30 Jun 1982	James Peter Connell	Canada
18	1 Jul 1982 - 30 Jun 1984	Jacques Campet	France
19	1 Jul 1984 - 30 Jun 1986	Jorma Uitto	Finland
20	1 Jul 1986 - 30 Jun 1987	Hubert Ndzomo Ndzana	Cameroon
21	1 Jul 1987 - 30 Jun 1988	Abubakar Musa	Nigeria
22	1 Jul 1988 - 30 Jun 1989	Bјцрн Gustaf Eriksson	Sweden
23	1 Jul 1989 - 30 Jun 1991	Humberto Rнос Rodriguez	Spain
24	1 Jul 1991 - 30 Jun 1992	Sir Brian Unwin	UK
25	1 Jul 1992 - 30 Jun 1994	Jean-Dominique Comolli	France
26	1 Jul 1994 - 30 Jun 1996	Dame Valerie Strachan	UK
27	1 Jul 1996 - 30 Jun 1998	Graeme W. Ludlow	New Zealand
28	1 Jul 1998 - 30 Jun 2000	Enrique Guillermo Fanta Ivanovic	Chile
29	1 Jul 2000 - Feb 2001	Obaid Saqr bin Busit	United Arab Emirates
30	Feb 2001 - 30 Jun 2001	John C. Tsang (interim)	Hong Kong
31	1 Jul 2001 - 30 Jun 2006	Pravin Gordhan	South Africa
32	1 Jul 2006 - 30 Jun 2008	Tapani Erling	Finland
33	1 Jul 2008 - 30 Jun 2011	Martyn J. Dunne	New Zealand
34	1 Jul 2011 - 30 Jun 2014	Josephine Feehily (f)	Ireland
35	1 Jul 2014 - 16 Jul 2016	Zouhair Chorfi	Morocco
36	16 Jul 2016 - 8 Jul 2017	Ruslan Valentinovich Davydov	Russia
37	Jul 2017 -	Enrique Canon Pedragosa	Uruguay

ДГБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын газар (the WCO General Secretariat) (Конвенцийн V зүйл) нь Бельгийн Вант Улсын нийслэл Брюссель хотноо байрладаг (Конвенцийн VI(a)). Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь дараах директоратуудаас бүрдэнэ:

- Тариф, худалдааны асуудал эрхэлсэн директорат (Tariff and Trade Affairs Directorate): Ангилал, үнэлгээ, гарал үүсэл (Nomenclature, Valuation and Origin)
- Хууль дүрэм мөрдөх, сахиулах асуудал эрхэлсэн директорат (Compliance and Facilitation Directorate): Горим журам болон худалдааг хөнгөвчлөх (Procedures and Facilitation); Хууль дүрэм сахиулах, мөрдөх (Enforcement and Compliance)
- Чадавхийг бэхжүүлэх асуудал эрхэлсэн директорат (Capacity Building Directorate): Колумбус хөтөлбөр, сургалт (Columbus Programme and Training) Ерөнхий нарийн бичгийн дарга (Secretary General), түүний орлогч (Deputy Secretary General)- ийг ДГБ томилно (Конвенцийн XI(a)).



Зураг 2. ДГБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын бүтэц

Хүснэгт 3. ДГБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нар

№	Алба хашсан жил	Нэр	Улс
1	2 Feb 1953 - 1 Aug 1953	Baron Franzois de Silyls Longchamps	Belgium
2	2 Aug 1953 - 31 Aug 1978	Chevalier Georges Annez de Taboada	Belgium
3	1 Sep 1978 - 31 Dec 1983	Sir Ronald Walter Radford	UK
4	1 Jan 1984 - 31 Dec 1988	Glenn R. Dickerson	US
5	1 Jan 1989 - 31 Dec 1993	Thomas P. Hayes	Australia
6	1 Jan 1994 - 31 Dec 1998	James W. Shaver	US
7	1 Jan 1999 - 31 Dec 2008	Michel Danet	France
8	1 Jan 2009 -	Kunio Mikuriya	Japan

ГХАЗ-ын анхны чуулган (Inaugural Session) 1953 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Бельгийн Вант Улсын нийслэл Брюссель хотноо чуулсан. 1983 оноос, ГХАЗ-ийн 30 жилийн ойгоор 1 дүгээр сарын 26-ны өдрийг “Олон улсын гаалийн өдөр” (International Customs Day) болгосон.

ГАЗ/ДГБ-ын эхний 74 чуулган (1990 он хүртэл)-д Монгол Улс оролцоогүй. Эдгээр чуулганаар дараах баримт бичгүүд батлагдсан байна:

1. Худалдааны дээж, загвар болон сурталчилгааны материалын импортыг хөнгөвчлөх тухай олон улсын конвенц (the International Convention to facilitate the importation of commercial samples and advertising material - Международная Конвенция об упрощении импорта коммерческих образцов и рекламного материала)(Женев, 1952-11-7)
2. Аялал жуулчлалын гаалийн гаалийн хөнгөлөлтийн тухай конвенц (the Convention concerning Customs facilities for touring - Конвенция о таможенных льготах для туристов)(Нью-Йорк, 1954-6-4)
3. Хувийн автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of private road vehicles - Таможенная Конвенция о временном ввозе частных дорожных перевозочных средств) (Нью-Йорк, 1954-6-4)
4. Үйлдвэрлэлийн дээж, загварт хэрэглэх ECS карнейн тухай гаалийн конвенц (Customs Convention on ECS Carnets for Commercial Samples - Таможенная Конвенция о карнетах ECS для промышленных образцов) (Брюссель, 1956-3-1)
5. Худалдааны (үйл ажиллагаанд ашиглах зориулалттай) автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of commercial road vehicles - Таможенная Конвенция, касающаяся временного ввоза дорожных перевозочных средств, служащих для коммерческих целей) (Женев, 1956-5-18)
6. Хувийн хэрэглээний агаарын хөлөг, аяллын завийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation for private use of aircraft and pleasure boats - Таможенная Конвенция о временном ввозе для частного использования летательных аппаратов и прогулочных судов) (Женев, 1956-5-18)
7. Баглаа боодлыг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (Customs Convention on the temporary importation of packings - Таможенная Конвенция о временном ввозе упаковок)(Брюссель, 1960-10-6)
8. Олон улсын тээвэрт ашигладаг тавиурын гаалийн бүрдүүлэлтийн тухай Европын конвенц (European Convention on Customs treatment of pallets used in international transport - Европейская Конвенция о таможенном режиме, применяемом к поддонам, используемым в международных перевозках/Европейская Конвенция о таможенной обработке поддонов, используемых в международных перевозках) (Женев, 1960-12-9)
9. Үзэсгэлэн, яармаг худалдаа, хурал чуулган болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үеэр үзүүлэх буюу хэрэглэх барааг оруулах хөнгөлөлтэй журмын тухай гаалийн конвенц (the Customs Convention concerning facilities for the importation of goods for display or use at exhibitions, fairs, meetings or similar events - Таможенная Конвенция, касающаяся льгот, предоставляемых при ввозе товаров, демонстрируемых или используемых на выставках, ярмарках, конференциях или подобных мероприятиях)(Брюссель, 1961-6-8)
10. Мэргэжлийн тоног төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of professional equipment - Таможенная Конвенция о временном ввозе профессионального оборудования) (Брюссель, 1961-6-8)
11. Барааг түр хугацаагаар оруулах зориулалттай АТА карнейн тухай гаалийн конвенц (ATA Convention: the Customs Convention on the ATA carnet for the temporary admission of goods - Таможенная Конвенция о Карнете А.Т.А. для временного ввоза товаров (Конвенция А.Т.А.)) (Брюссель, 1961-12-6)
12. Далайчдын халамжийн материалын тухай гаалийн конвенц (the Customs Convention on welfare material for seafarers - Таможенная Конвенция об оборудовании для улучшения досуга моряков)(Брюссель, 1964-12-1)
13. Шинжлэх ухааны багаж төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of scientific equipment - Таможенная Конвенция о временном ввозе научного оборудования)(Брюссель, 1968-6-11)
14. Сурган хүмүүжүүлэх материалыг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of pedagogic material - Таможенная Конвенция о временном ввозе педагогического материала) (Брюссель, 1970-6-8)
15. Барааг олон улсын хэмжээнд дамжуулан өнгөрүүлэх тухай гаалийн конвенц (ITI Convention: Customs Convention on the

International Transit of Goods - Таможенная Конвенция о Международной транзитной перевозке грузов (Конвенция ТМТ)) (Вена, 1971-6-7)

16. Чингэлгийн тухай гаалийн конвенц (the Customs Convention on Containers - Таможенная Конвенция, касающаяся контейнеров/ Таможенной Конвенции о контейнерах) (Женев, 1972-12-2)
17. Киотогийн конвенц (Kyoto Convention -

Киотская Конвенция)(1973-5-18)

18. Наиробийн конвенц (Nairobi Convention - Наиробская Конвенция)(1977-6-9)

19. БТКУС-ийн конвенц (HS Convention - Конвенция о гармонизированной системе)(1983-6-14)

ДГБ-ын хүрээнд жил бүр ДГБ-ын чуулган, Бодлогын комиссын чуулган, Хороод, дэд хороодын чуулганаас гадна бүс нутгийн хэмжээний хуралдаанууд болдог. ДГБ Гишүүн орнуудаа дараах 6 бүсэд хуваан үйл ажиллагаагаа явуулдаг.



Зураг 3. ДГБ Гишүүн орнуудын бүсчлэл

Эдгээр бүс нутгийг төлөөлсөн ДГБ-ын дэд дарга нар ажиллана. Ази, Номхон далайн бүсийг төлөөлсөн дэд дарга (Vice-chairs for the WCO Asia-Pacific Region)-аар 1990 оноос эхлэн дараах улсын гаалийн байгууллагаас ажилласан байна.

Хүснэгт 4. Ази, Номхон далайн бүсийг төлөөлсөн дэд дарга нарын мэдээлэл

Алба хашсан жил (Tenure)	Улс (Country)
1990-1992	Korea
1992-1994	Japan
1994-1996	Malaysia
1996-1998	India
1998-2000	Australia
2000-2002	Hong Kong, China
2002-2004	New Zealand
2004-2006	China
2006-2008	India
2008-2010	Republic of Korea
2010-2012	Thailand
2012-2014	Australia
2014-2016	Malaysia
2016-2018	Fiji
2018-2020	India

Ази, Номхон далайн бүсийн хувьд дараах хуралдаанууд явагддаг:

- Бүс нутгийн гаалийн байгууллагын дарга нарын Бага хурал (Regional Customs Heads Conferences);
- ДГБ-ын Бүс нутгийн холбоо баригч нарын уулзалт (WCO Regional Contact Points Meeting);
- ДГБ-ын Гаалийн зөрчлийн талаар холбоо баригч нарын бүсийн нутгийн уулзалт (WCO Regional Intelligence Liaison Office Meeting) - Гаалийн зөрчлийн талаар холбоо барих бүс нутгийн байгууллага анх глобал сүлжээ бий болгох зорилгоор Ази, Номхон далайн бүсийн хүрээнд Гонконгод 1987 онд байгуулагдаж бол эдүгээ RILC бас бусад нутагт байгуулагдаж, дэлхий нийтийн хэмжээнд 11 болсон байна.

Монгол Улс Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл (ГХАЗ)-ийн 1990 онд Турк Улсын Стамбул хотноо чуулсан 75/76 дугаар чуулган, 1991 онд Бельги Улсын Брюссель хотноо чуулсан 77/78 дугаар чуулганд ажиглагчаар оролцсон. Монгол Улс ГХАЗ-ийн 79 дүгээр чуулганы хуралдаанаас

эхлэн бүрэн эрхт гишүүний статустай оролцож ирсэн бөгөөд ГХАЗ-ийн 111 дэх гишүүн улс билээ (ОХУ 110 дахь гишүүн болсон). Монголын гаалийн байгууллагын төлөөлөгчид 1991 оноос хойш эдүгээ хүртэл ДГБ-ын чуулган, түүний ажлын нэгжүүд (working bodies)-ийн хурал чуулганд, тухайлбал, Техникийн байнгын хорооны, Аудитын хорооны,

Чадавхийг бэхжүүлэх хорооны чуулганд, мөн бүс нутгийн хуралдаануудад үндсэндээ санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар алдаг оног оролцож ирсэн байдаг. Монгол Улс ДГБ-ын Санхүүгийн хорооны гишүүнээр 2010-2012 онд сонгогдон ажиллаж байсан.

ДГБ-ЫН ЧУУЛГАН, БУСАД ХУРАЛДААНД МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ОРОЛЦСОН БАЙДАЛ

Хүснэгт 5. ГХАЗ/ДГБ-ын чуулган

(CCC/WCO SESSIONS)

ГХАЗ/ ДГБ-ын чуулган	Зохион байгуулсан улс, хот, огноо	Төлөөлөгч (delegate), Орлогчид (alternates), зөвлөхүүд (advisers)	Албан тушаал	Батлагдсан баримт бичиг, гол үйл явдал
Анхны чуулган (Inaugural Session)	Бельги Улс, Брюссель хот 1953, I/26	Монгол Улс оролцоогүй		
2-74 дүгээр чуулган		Монгол Улс оролцоогүй		- Энэ хугацаанд батлагдсан баримт бичгүүдийг дээр дурдсан байгаа
Монгол Улс ажиглагч (Observer)-ийн статустай оролцсон				
75/76	Турк Улс, Стамбул хот 1990, VI/26	Х.Оюунцэцэг Г.Сэсээр	- Гадаад худалдааны яамны Гэрээ, эрх зүйн хэлтсийн дарга - ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн	- Стамбулын Конвенц (Барааг түр хугацаагаар оруулах тухай дээр дурдсан эхний 16 Конвенц, Конвенцийн заалтаас өөртөө нэгтгэсэн)
77/78	Бельги Улс, Брюссель хот 1991, VI/24-26	Г.Сэсээр Д.Баярсайхан	- Гаалийн хэрэг эрхлэх газрын дарга - ГХЭГ-ын Бодлого, эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн	- ОХУ, Монгол Улс уг Конвенцийг соёрхон баталснаа мэдэгдсэн
Монгол Улс бүрэн эрхт гишүүн (Member)-ны статустай оролцсон				
79/80	Бельги Улс, Брюссель хот 1992, VI/22-24	Д.Амарсайхан Д.Оюунчимэг	- МУГЕГ-ын дэд дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	
81/82	Танзани Улс, Аруша хот 1993, VII/5-8	Г.Сэсээр Д.Оюунчимэг	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	- Арушагийн Тунхаглал

ГХАЗ/ ДГБ-ын чуулган	Зохион байгуулсан улс, хот, огноо	Төлөөлөгч (delegate), Орлогчид (alternates), зөвлөхүүд (advisers)	Албан тушаал	Батлагдсан баримт бичиг, гол үйл явдал
83/84	Бельги Улс, Брюссель хот 1994, VI/20-22	Г.Сэсээр Д.Оюунчимэг	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	- ДГБ гэсэн албан бус нэртэй болсон
85/86	Бельги Улс, Брюссель хот 1995, VI/19-21	Б.Шаравсамбуу Ч.Насантуяа	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Статистик, мэдээлэл, тооцооллын төвийн захирал	
87/88	Хонконг 1996, VI/17-21	Б.Шаравсамбуу Л.Дэлгэрбаяр	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн	- Энэ хугацаанд Монгол-АНУ-ын хооронд Гаалийн асуудлаар, хамтран ажиллах, харилцан туслах тухай хэлэлцээр байгуулсан
89 дүгээр тусгай чуулган (Special Session)	Бельги Улс, Брюссель хот 1996, XII/6	Б.Цэнд Д.Баярсайхан	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	- Төв байрны байршлыг сольсон
90	Унгар Улс, Будапешт хот 1997, VI/16-19	Монгол Улс оролцоогүй		
91/92	Марокко Улс, Марракеш хот 1998, VI/22-25	Монгол Улс оролцоогүй		
93/94	Бельги Улс, Брюссель хот 1999, VI/24-26	Монгол Улс оролцоогүй		- Киотогийн шинэчилсэн Конвенцийг Протоколоор баталсан
95/96	Бельги Улс, Брюссель хот 2000, VII/6-8	Ш.Цогтоо Э.Чинбат	- МУГЕГ-ын дэд дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, хамтын ажиллагааны хэлтсийн ГУАБ	
97/98	Бельги Улс, Брюссель хот 2001, VI/28-30	Х.Баатар Д.Баярсайхан	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Гаалийн бодлого, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	
99/100	Бельги Улс, Брюссель хот 2002, VI/27-29	Х.Баатар	- МУГЕГ-ын дарга	- ДГБ-ын 50 жилийн ой болсон
101/102	Бельги Улс, Брюссель хот 2003, VI/26-28	Х.Баатар	- МУГЕГ-ын дарга	- Йоханнесбургийн Конвенц - Арушагийн шинэчилсэн Тунхаглал

ГХАЗ/ ДГБ-ын чуулган	Зохион байгуулсан улс, хот, огноо	Төлөөлөгч (delegate), Орлогчид (alternates), зөвлөхүүд (advisers)	Албан тушаал	Батлагдсан баримт бичиг, гол үйл явдал
103/104	Бельги Улс, Брюссель хот 2004, VI/24-26	С.Онон Х.Оюунцэцэг	- ЕХ-нд суугаа Элчин сайд - ЭСЯ-ны худалдааны зөвлөх	
105/106	Бельги Улс, Брюссель хот 2005, VI/23-25	Х.Баатар	- МУГЕГ-ын дарга	- Аюулгүй байдлын багц стандарт (the SAFE Framework of Standards)
107/108	Бельги Улс, Брюссель хот 2006, VI/29- VII/1	Б.Баттөмөр Э.Чинбат	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын даргын зөвлөх	- Гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх “Колумбус хөтөлбөр” (Columbus Programme) эхэлсэн (энэ нь Аюулгүй байдлын багц стандартын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой)
109/110	Бельги Улс, Брюссель хот 2007, VI/28-30	Б.Баттөмөр Э.Чинбат	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын даргын зөвлөх	
111/112	Бельги Улс, Брюссель хот 2008, VI/26- 28	Д.Цэвээнжав Л.Дэлгэрбаяр	- МУГЕГ-ын дарга - МУГЕГ-ын Стратеги төлөвлөлт, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга	
	Чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ГЕГ, Голланд Улсын Татвар, гаалийн байгууллага, ДГБ хоорондын гурвалсан хэлэлцээр (Technical Cooperation Agreement On Capacity Building Between The Customs General Administration of Mongolia, The Dutch Tax And Customs Administration And The World Customs Organization” (Tripartite Agreement)-т гарын үсэг зурав.			
113/114	Бельги Улс, Брюссель хот 2009, VI/25-27	Д.Оюунчимэг	- МУГЕГ-ын дэд дарга	
115/116	Бельги Улс, Брюссель хот 2010, VI/24-26	Д.Цэвээнжав Л.Дэлгэрбаяр Э.Чинбат Б.Мандухай	- МУГЕГ-ын дарга - ТЗХАГ-ын дарга - ТЗХАГ-ын ГУАБ - ТЗХАГ-ын ГУБ	- ДГБ-ын - e-Learning- ийн монгол орчуулгын ажиллагааг танилцуулсан
117/118	Бельги Улс, Брюссель хот 2011, VI/23-25	Д.Цэвээнжав М.Өлзийбат	- МУГЕГ-ын дэд дарга - МУГЕГ-ын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга	
119/120	Бельги Улс, Брюссель хот 2012, VI/28-30	Монгол Улс оролцоогүй		

ГХАЗ/ ДГБ-ын чуулган	Зохион байгуулсан улс, хот, огноо	Төлөөлөгч (delegate), Орлогчид (alternates), зөвлөхүүд (advisers)	Албан тушаал	Батлагдсан баримт бичиг, гол үйл явдал
121/122	Бельги Улс, Брюссель хот 2013, VI/27-29	О.Ганбат О.Оч Ц.Янжив	- ГЕГ-ын дарга - Элчин сайд - Худалдааны атташе	
123/124	Бельги Улс, Брюссель хот 2014, VI/26-28	- Монгол Улс оролцоогүй - Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх Меркатор хөтөлбөрийг эхлүүлсэн		
125/126	Бельги Улс, Брюссель хот 2015, VI/11-13	Б.Цэнгэл Н.Болор-Оюу Я.Чинзориг	- ГЕГ-ын дарга - ГЕГ-ын ГХАХ-ийн ГУБ - ЭСЯ-ны 2 дугаар н/б	
127/128	Бельги Улс, Брюссель хот 2016, VII/14-16	Н.Энхцогт Х.Мөнхзул	- ГТЕГ-ын дэд дарга - ГТЕГ-ын ГЭУГ-ын ГУБ	
129/130	Бельги Улс, Брюссель хот 2017, VII/6-8	О.Оч Д.Эрдэнэсүрэн Н.Мөнхжаргал	- Элчин сайд - ГЕГ-ын ГЭУХ-ийн дарга - ЭСЯ-ны 2 дугаар н/б	
131	Бельги Улс, Брюссель хот 2017, XII/14-15	Б.Асралт О.Оч П.Баттөр Д.Долгорсүрэн Б.Даваасүрэн О.Лхагва-Эрдэнэ Д.Цэндсүрэн Н.Мөнхжаргал	- ГЕГ-ын дарга - Элчин сайд - ГЕГ-ын ГХШГ-ын дарга - ГЕГ-ын СХОХ-ийн дарга - ГСГГ-ын дарга - ХОГГ-ын дарга - ГЕГ-ын ГХАХ-ийн ГУАБ - ЭСЯ-ны 2 дугаар н/б	- ДГБ-ын НБДНГ- ын Ерөнхий нарийн бичгийн дэд даргын сонгууль болсон. Ноён Кунио Микурияа уг албан тушаалд улиран ажиллах болсон.
132	Бельги Улс, Брюссель хот 2018, VI/28-30	Б.Асралт Ё.Бат-Эрдэнэ Б.Мөнхөө П.Баттөр Ө.Цолмон С.Цэцгээ Д.Зоригоо Ч.Тамираа Д.Цэндсүрэн Н.Мөнхжаргал	- ГЕГ-ын дарга - ГЕГ-ын дэд дарга - ГЕГ-ын ГХШГ-ын дарга - ГЕГ-ын ХШДАХ-ийн дарга - ГЕГ-ын ГХАХ-ийн дарга - БУГГ-ын дарга - ЗУГГ-ын дарга - ГЕГ-ын ХХ-ийн ГУАБ - ГЕГ-ын ГХАХ-ийн ГУАБ - ЭСЯ-ны 2 дугаар н/б	- Аюулгүй байдлын багц стандартын 2018 оны хувилбар батлагдсан. - Хил дамнасан цахим худалдааны багц стандарт батлагдсан.
133/134	Бельги Улс, Брюссель хот 2019, VI/28-30	Б.Асралт П.Баттөр Д.Эрдэнэсүрэн О.Цэенрэгзэн Д.Цэндсүрэн	- ГЕГ-ын дарга - ГЕГ-ын ГХШГ-ын дарга - ГЕГ-ын ГЭУХ-ийн дарга - СШГГ-ын дарга - ГЕГ-ын ГХАХ-ийн ГУАБ	- ДГБ-ын 2019-2022 оны стратеги төлөвлөгөө баталсан.

Хүснэгт 6. Бүс нутгийн гаалийн байгууллагын дарга нарын Бага хурал

(REGIONAL CUSTOMS HEADS CONFERENCES - RHCA Conferences)

Хуралдаан	Хаана болсон	Хэзээ болсон	Хэн оролцсон	Албан тушаал
I Бага хурал		1987	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
II Бага хурал		1989		
III Бага хурал	Токио, Япон	1991, II/26-28	Г.Сэсээр Г.Пүрэвсүрэн	- ГХЭГ-ын дарга - Толгойтын гаалийн салбарын эрхлэгч
IV Бага хурал	Бангкок, Тайланд	1993, II/9-11	Г.Сэсээр Д.Оюунчимэг	- МУГЕГ-ын дарга - ГБХАХ-ийн дарга
V Бага хурал	Бээжин, Хятад	1995, IV/25-28	Б.Шаравсамбуу Ч.Насантуяа Л.Минжин	- МУГЕГ-ын дарга - СМТТ-ийн захирал - УБ хот дахь гаалийн газрын дарга
VI Бага хурал	Лангкави, Малайз	1996, IV/22-25	Б.Шаравсамбуу Ч.Насантуяа	- ГЕГ-ын дарга - ГЕГ-ын дэд дарга
VII Бага хурал	Шинэ Дели, Энэтхэг	1998, III/23-26	Д.Цэнд Э.Чинбат	- ГЕГ-ын дарга - ГЕГ-ын ГБХАХ-ийн дарга
VIII Бага хурал	Канберра, Австрали	2000, IV/7-16	Т.Лхагваа Д.Баярсайхан	- МУГЕГ-ын дарга - ГБХАХ-ийн дарга
IX Бага хурал	Хонконг, БНХАУ	2002, IV/8-12	Х.Баатар	- МУГЕГ-ын дарга
X Бага хурал	Окланд, Шинэ Зеланд	2004, III/29- IV/2	Б.Баттөмөр	- МУГЕГ-ын дэд дарга
XI Бага хурал	Бээжин, Хятад	2006, IV/3-6	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
XII Бага хурал	Шинэ Дели, Энэтхэг	2008, IV/14-17		
XIII Бага хурал	Сөүл, БНСУ	2010, IV/27-30	Д.Цэвээнжав Б.Мандухай	- ГЕГ-ын дарга - ТЗХАГ-ын ГУБ
XIV Бага хурал	Самуи, Таиланд	2012, V/8-11	Д.Оюунчимэг	- ГЕГ-ын дэд дарга
XV Бага хурал	Порт Дуглас, Австрали	2014, IV/29-V/2	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
XVI Бага хурал	Мельбурн, Австрали	2015, II/6		
XVII Бага хурал	Куала Лумпур, Малайз	2016, III/14-18		
XVIII Бага хурал	Сува, Фижи	2017, III/14-16		
XIX Бага хурал	Сигатока, Фижи	2018, V/14-17		
XX Бага хурал	Кочи, Энэтхэг	2019, V/08-10		

Хүснэгт 7. ДГБ-ын Бүс нутгийн холбоо баригч нарын уулзалт

(WCO RCP MEETINGS)

Уулзалт	Хаана болсон	Хэзээ болсон	Хэн оролцсон	Албан тушаал
I Бага хурал			Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
II Бага хурал				
III Бага хурал	Бээжин, Хятад	1993, 18-21/Х	С.Бахнаа Д.Баярсайхан	- Санхүү, татварын хэлтсийн дарга - ГБХАХ-ийн ажилтан
IV Бага хурал			Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
V Бага хурал				
VI Бага хурал	Лангкави, Малайз	1996, 22-25/IV	Ч.Насантуяа	- Дэд дарга
VII Бага хурал				
VIII Бага хурал	Канберра, Австрали	1998, X/27-29	Э.Чинбат	- ГЕГ-ын ГБХАХ-ийн дарга
IX Бага хурал	Тегеран, Иран	1999	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
X Бага хурал	Хонконг, БНХАУ	2000		
XI Бага хурал	Макао, БНХАУ	2001		
XII Бага хурал	Окленд, Шинэ Зеланд	2002		
XIII Бага хурал	Шинэ Дели, Энэтхэг	2003		
XIV Бага хурал	Бээжин, БНХАУ	2004, XI/1-4	Д.Очирбат	- БЗХАХ-ийн ГУАБ
XV Бага хурал	Бангкок, Тайланд	2005, XI/8-11	Ч.Энхтуяа	- ГБХАХ-ийн дарга
XVI Бага хурал	Шинэ Дели, Энэтхэг	2006	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
XVII Бага хурал	Гао, Энэтхэг	2007		
XVIII Бага хурал	Сөүл, БНСУ	2008		
XIX Бага хурал	Улаанбаатар, Монгол	2009, IX/6	Д.Оюунчимэг Л.Дэлгэрбаяр Э.Чинбат	- ГЕГ-ын дэд дарга - ТЗХАГ-ын дарга - ТЗХАГ-ын ГУБ
XX Бага хурал	Бангкок, Тайланд	2010, XI/1-5	Л.Дэлгэрбаяр	- ТЗХАГ-ын дарга
XXI Бага хурал	Брисбан, Австрали	2011, XI/9-11	Монгол оролцсон	
XXII Бага хурал	Адалейд, Австрали	2012	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
XXIII Бага хурал	Куала Лумпур, Малайз	2013, X/22-23		
XXIV Бага хурал	Лангкави Арал, Майлайз	2014, XI/18-20		
XXV Бага хурал	Куала Лумпур, Малайз	2015, XI/17-19		
XXVI Бага хурал	Сигатока, Фижи	2016, XI/9-11		
XXVII Бага хурал	Cairns, Австрали	2017, X/11-13		
XXVIII Бага хурал	Jaipur, Rajasthan, Энэтхэг	2018, XI/14-16		
XXIX Бага хурал	Puducherry, Энэтхэг	2019, XI/18-20		

Хүснэгт 8. ДГБ-ын Гаалийн зөрчлийн талаар холбоо баригч нарын бүсийн нутгийн уулзалт
(WCO RILO MEETINGS)

Уулзалт	Хаана болсон	Хэзээ болсон	Хэн оролцсон	Албан тушаал
V уулзалт	Бээжин, БНХАУ	1992, X/7-8	Д.Баасанжав Д.Баярсайхан	- ХШМХ-ийн дарга - ГБХАХ-ийн ажилтан
VIII уулзалт	Дели, Энэтхэг	1995, IX/24-29	Ч.Энхтуяа	- Гаалийн хяналт шалгалтын хэлтсийн дарга
IX уулзалт	Токио, Япон	1996, X/30-31	Ш.Цогтоо	- ГЕГ-ын дэд дарга
XII уулзалт	Токио, Япон	1999, XI/9-11	Г.Туулхүү	- ГХХБХ-ийн дарга
XV уулзалт	Токио, Япон	2003, XI/25-28	Д.Баярсайхан	- ГЭЗК-ийн багш
XVI уулзалт	Бээжин, БНХАУ	2004	Ч.Энхтуяа	- Гаалийн хяналт шалгалтын хэлтсийн дарга
XIX уулзалт	Бээжин, БНХАУ	2007, XI/21-23	Б.Мягмар	- Гаалийн зөрчилтэй тэмцэх хэлтсийн ГУАБ
XX уулзалт	Улаанбаатар, Монгол			
XXI уулзалт	Хонконг, БНХАУ	2009, X/20-22	Г.Энхтайван	- Гаалийн Эрсдэлийн удирдлагын албаны ГУБ
XXVII уулзалт	Сөүл, БНСУ	2017, XI/1-3	Б.Онон Д.Гантуг	- ГЗТХБГ-ын дарга - УБГГ-ын орлогч дарга

Хүснэгт 9. ДГБ-ын Чадавхийг бэхжүүлэх хорооны чуулган
(WCO Capacity Building Committee Sessions)

Чуулган	Хаана болсон	Хэзээ болсон	Хэн оролцсон	Албан тушаал
I чуулган	Брюссель, Бельги	2010, IX/27-29	Л.Дэлгэрбаяр Г.Баттулга	- ГЕГ-ын Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газрын дарга - ЭСЯ-ны ажилтан
II чуулган		2011, V/3-5	Д.Оюунчимэг Б.Ганбат	- ГЕГ-ын дэд дарга - ЭСЯ-ны атташе
III чуулган		2012, II/27-29	Монголын гаалийн төлөөлөгч оролцоогүй	
IV чуулган		2013, II/25-27		
V чуулган		2014, III/31-IV/2		
VI чуулган		2015, II/23-25		
VII чуулган		2016, IV/11-13		
VIII чуулган		2017, III/7-9		
IX чуулган		2018, II/26-28		

ДГБ-ын Бүс нутгийн сургалтын төвүүд (WCO Regional Training Centers (RTCs))

Өнөөдрийн байдлаар ДГБ-ын Бүс нутгийн сургалтын төв дэлхийн хэмжээнд 26 байна. Үүнээс, Ази, Номхон далайн бүсэд 7 (Хятад, Фижи, Гонконг, Энэтхэг, Япон, БНСУ, Малайз), Зүүн болон Өмнөд Африкт 4 (Kenya; Mauritius; South Africa; Zimbabwe), Баруун болон Төв Африкт 3 (Burkina Faso; Congo (Rep. of); Nigeria),

Европын бүсэд 6 (Azerbaijan; Hungary; Kazakhstan; The Former Yugoslav Republic of Macedonia; Russian Federation; Ukraine), Америк тивд 2 (Brazil; Dominican Republic), Хойд Африк, Ойрх болон Дундад Дорнодод 4 (Egypt; Jordan; Lebanon; Saudi Arabia) байна.



Зураг 4. ДГБ-ын Бүс нутгийн сургалтын төвүүд

Хүснэгт 10. Ази, Номхон далайн бүс нутгийн сургалтын төвийн дарга нарын жил бүрийн уулзалт
(Annual WCO A/P Regional Heads of Training Centers (RTCs) Meetings)

Уулзалт	Хаана болсон?	Хэзээ болсон?	Хэн оролцсон?	Албан тушаал
XI уулзалт	Сува, Фижи	2013, XI/5-6	Хятад, Фижи, Гонконг, Энэтхэг, Япон, БНСУ, Малайзын Бүс нутгийн сургалтын төвийн дарга нар	
XIII уулзалт	Малакка, Малайз	2015, XI/3-4		
XIV уулзалт	Гонконг	2016, XII/7-9		
XV уулзалт	Брюссель, Бельги	2018, II/23		



2. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенц (БТКУС-ийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on the Harmonized Commodity Description and Coding System (The HS Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Международная Конвенция о гармонизированной системе описания и кодирования товаров
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1983-06-14. Бельги Улсын Брюссель хот (Brussels, Belgium)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1988-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2017 оны байдлаар: 156 (155 улс + Европын холбоо)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1991-05-31
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1991-09-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1993-01-01
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	ДГБ-аас БТКУС-д 4-6 жил тутам нэмэлт, өөрчлөлт оруулдаг. Уялдуулсан системийн Тайлбар бичиг (the Explanatory Notes of the Harmonized System)-ийн 1992, 1996, 2002, 2007, 2012, 2017 оны хувилбарууд тус тус батлагдан гарч байсан. Уялдуулсан системийн 2017 оны хувилбар буюу 6 дахь хувилбар 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улс (ГЕГ) уг хувилбарт суурилсан үндэсний жагсаалтыг мөн 2017 онд баталж, хэвлүүлсэн болно.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	“Олон улсын зарим конвенцид нэгдэн орох тухай” Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 163 дугаар тогтоол

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Уг Конвенц нь 1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Брюссель хотноо байгуулагдаж, 1959 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон “Гаалийн тарифт барааг ангилах нэрийн цогцсын тухай” Конвенц, түүнд нэмэлт оруулсан протокол (Convention on Nomenclature for the Classification of goods in Customs Tariffs and Protocol of Amendment thereto - Конвенции о номенклатуре для классификации таможенных тарифов 1950 г.)-ын сайжруулсан хэлбэр болно. БТКУС-ыг *de jure* болон *de facto* байдлаар нийтдээ 190 гаруй улс хэрэглэдэг. Дэлхийн худалдааны 98 хувь нь БТКУС-аар ангилагддаг.

Уялдуулсан системийн конвенц нь олон улсын худалдааны барааг нэг мөр тодорхойлох, ангилах, кодлох замаар худалдаа болон мэдээлэл солилцоог хөнгөвчлөх зорилготой болно.

Уялдуулсан системийг гаалийн тариф тогтоох, мөн гадаад худалдааны статистик мэдээлэл гаргах зорилгоор ашигладаг. Түүнээс гадна, Уялдуулсан системийг төрийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, мөн хувийн хэвшлийнхэн дотоодын татвар тогтоож, ногдуулах, худалдааны бодлого боловсруулах, хориглосон, хязгаарласан бараанд хяналт тавих (monitoring of controlled goods), барааны гарал үүслийг тодорхойлох (rules of origin), тээврийн тариф (freight tariffs) тогтоох, ачаа тээврийн статистик мэдээ (transport statistics) гаргах, үнийн хяналт (price monitoring) тавих, квотын хяналтыг хэрэгжүүлэх (quota controls), үндэсний эдийн засгийн үзүүлэлтийг тооцон гаргах (compilation of national accounts), эдийн засгийн судалгаа, шинжилгээний ажил хийх (economic research and analysis) зэрэг олон зорилгоор ашиглаж байна.

Энэ конвенцийн дагуу “БТКУС” гэж зүйл (Heading: 01.01 ... 97.06 гэсэн 4 оронтой араб тоогоор илэрхийлэгдсэн 1222 зүйл байна), мөр (Sub-Heading: 0101.10 ... 9706.00 гэсэн 6 оронтой араб тоогоор илэрхийлэгдсэн 5387 мөр байна) болон тэдгээрийн тоон код (Numerical Codes), мөн хэсэг (Section: I-XXI гэсэн ром тоогоор илэрхийлэгдсэн 21 хэсэг байна), бүлэг (Chapter: 1-76, 78-97 гэсэн 1-2 оронтой араб тоогоор илэрхийлэгдсэн 96 бүлэг байна. 77, 98, 99 дүгээр бүлэг байхгүй), мөр (Sub-Heading)-ийн тайлбар, уялдуулсан системийн ерөнхий тайлбар дүрэм бүхий жагсаалтыг хэлнэ [the term “Harmonized Commodity Description and Coding System” means a nomenclature comprising of Headings, Subheadings and National Subheadings and their related numerical codes, as well as notes to Sections, Chapters and Subheadings, and the General Rules for interpretation of the Harmonized System]. БТКУС-ийн жагсаалтыг ДГБ-аас англи, франц, орос, испани хэлээр албан ёсоор гаргаж байна.

Монгол Улсад экспортын болон импортын барааны гаалийн тарифыг хэрэглэх бөгөөд гаалийн тарифыг тогтоохдоо барааны код, нэр төрлийг Уялдуулсан системд үндэслэсэн үндэсний кодын дагуу заана.

Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал улсын хилээр оруулах, гаргахыг

хориглох барааны, Засгийн газар тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтын дагуу зааж тус тус батална.

Монгол Улсын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар, Уялдуулсан системийг барааг гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтад хамааруулах, түүнчлэн гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээг эрхлэн гаргах зорилгоор хэрэглэнэ (ГТТХ-ийн 21.1.). Монгол Улс БТКУС-ыг үндэсний кодоор баяжуулан, 8 орны хэмжээнд задаргаа хийж, гадаад худалдааны статистик гаргах зорилгоор 1993 оноос хэрэгжүүлж эхэлсэн. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолоор импортын барааны гаалийн татварын хувь хэмжээг БТКУС-д суурилсан үндэсний жагсаалтыг үндэслэн тогтоосон. Түүнээс хойш энэ тогтоолд 12 удаа нэмэлт өөрчлөлт оруулаад байна.

Монгол Улсын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд зааснаар, Барааг тодорхойлох, кодлох Уялдуулсан системд суурилсан гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална (ГТТХ-ийн 21.2).



3. Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц (Киотогийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on Simplification and Harmonization of Customs Procedures (The Kyoto Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Международная Конвенция об упрощении и гармонизации таможенных процедур (пересмотренная Киотская Конвенция)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1973-05-18. Япон Улсын Киото хот (Kyoto, Japan)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1974-09-25 (Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц 2006 оны 2 дугаар сарын 3-ны өдөр)
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2017 оны байдлаар: 110 (109 улс + Европын холбоо)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2006-05-26
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2006-07-01
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2006-10-01
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: 1999 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Брюсселийн Протоколоор шинэчлэгдэж, шинэчлэгдсэн хувилбарыг баталсан баримт бичгийг 40 дэх улс 2005 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр гардуулж, 2006 оны 2 дугаар сарын 3-нд хүчин төгөлдөр болсон. Уг Протокол нь дараах зүүлтүүд (appendixes)-тэй:	<ul style="list-style-type: none"> a. Гаалийн горимыг хялбарчилах, уялдуулах тухай олон улсын 1973 оны үндсэн Конвенцийн бичвэрт нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбар (Body of the Convention) b. Ерөнхий хавсралт (10 бүлэгтэй)(General Annex - 10 Chapters) c. Тусгай хавралтууд (25 бүлэгтэй)(Specific Annexes - 25 Chapters) d. Ерөнхий хавсралт, тусгай хавсралт болон тэдгээрийн бүлэг бүрийн заавар - заавал дагаж мөрдөх албагүй (Guidelines to each annex and chapter - not binding)
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Гаалийн бурдуулэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцид нэгдэн орох тухай 2006 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хууль - Конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2006 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 44 дүгээр тогтоол

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Гаалийн бүх горимуудыг хялбарчлах, нэг мөр болгох, гаалийн хяналтыг эрсдэлийн менежмент болон аудитын шалгалтад түшиглэн явуулах, татвар буцаан олгох, гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулах, мэдээллийн технологийг өргөнөөр ашиглах, бизнесийн хүрээнийхэнтэй түншлэх, гарал үүслийг тодорхойлох асуудлуудыг цогцоор нь зохицуулсан.

Нийтдээ 349 стандарт заалттай. Тэдгээрийг баталсан бол 36 сарын дотор хэрэгжүүлэх ёстой.

Нийтдээ 13 шилжилтийн стандарт заалттай. Тэдгээрийг баталсан бол 60 сарын дотор

хэрэгжүүлэх ёстой. Шилжилтийн стандарт заалтууд нь зөвхөн Ерөнхий хавсралтад байгаа.

Нийтдээ 150 практик зөвлөмжтэй. Тэдгээрийг баталсан бол 36 сарын дотор хэрэгжүүлэх ёстой.

Практик зөвлөмжүүд нь зөвхөн тусгай хавсралтуудад байгаа.

Стандарт, шилжилтийн стандарт, практик зөвлөмжүүд бүгд нийлээд 512 болно.

Уг Конвенцид нэгдэж орох улс үндсэн Конвенц (Body of the Convention) болон Ерөнхий хавсралт (General Annex)-ын 10 бүлгийг бүхэлд нь, тусгай 10 хавсралтын (Specific Annexes) нийт 25 бүлгийн аль нэг бүлгийн стандарт заалтуудыг заавал

батлах ёстой. Тусгай хавсралтын аль нэг бүлэг хүчин төгөлдөр болоход уг бүлгийг наад зах нь 5 улс баталсан байх ёстой. Хүчин төгөлдөр болсон аль нэг бүлэг нь зөвхөн түүнийг баталсан улсуудын

хувьд хүчинтэй байна. Ерөнхий хавсралтын заалтууд бүх тусгай хавсралтуудад хамааралтай. Монгол Улсын хувьд бүгдийг нь баталсан.

Конвенцийн бүтэц: Ерөнхий хавсралт (General Annex):

I бүлэг:	Нийтлэг зарчмууд (General Principles)
II бүлэг:	Тодорхойлолт (Definitions)
III бүлэг:	Бүрдүүлэлт болон гаалийн ёс журмын бусад ажиллагаа (Clearance and Other Customs Formalities)
IV бүлэг:	Гаалийн болон бусад татвар: ногдуулах, хураах, төлөх, хойшлуулах, буцаан өгөх (Duties and Taxes: Assessment, Collection and Payment, Deferred Payment, Repayment)
V бүлэг:	Баталгаа (Security)
VI бүлэг:	Гаалийн хяналт (Customs Control)
VII бүлэг:	Мэдээллийн технологи ашиглах (Application of Information Technology)
VIII бүлэг:	Гаалийн байгууллага болон гуравдагч тал хоорондын харилцаа (Relationship between the Customs and Third Parties)
IX бүлэг:	Гаалийн байгууллагаас гаргаж өгсөн мэдээлэл, шийдвэр болон урьдчилсан шийдвэр: нийтлэг хэрэглээний мэдээлэл, тусгай мэдээлэл, шийдвэр болон урьдчилсан шийдвэр (Information, Decisions and Rulings Supplied by the Customs: Information of General Application, Information of a Specific Nature, Decisions and Rulings)
X бүлэг:	Гаалийн асуудлаар давж заалдах: давж заалдах эрх, давж заалдах хэлбэр, үндэслэл, давж заалдсан гомдлыг хянан шийдвэрлэх (Appeals in Customs Matters: Right of Appeal, Form and Grounds of Appeal, Consideration of Appeal)

Тусгай хавсралтууд:

1. Тусгай хавсралт А - Бараа гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх (Arrival of goods in a Customs territory)

I бүлэг. Барааны мэдүүлэг гаргаж өгөхөөс өмнөх ёс журмын ажиллагаа (Formalities prior to the lodgement of the Goods declaration)

II бүлэг. Барааг түр хадгалах (Temporary storage of goods)

2. Тусгай хавсралт В - Импортлох (Importation)

I бүлэг. Дотоодын хэрэглээнд зориулан оруулах (Clearance for home use)

II бүлэг. Өөрчлөлт оруулалгүйгээр буцаан оруулах (Re-importation in the same state)

III бүлэг. Импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх (Relief from import duties and taxes)

3. Тусгай хавсралт С - Экспортлох (Exportation)

I бүлэг. Бүрмөсөн гаргах (Outright exportation)

4. Тусгай хавсралт D - Гаалийн агуулах болон чөлөөт бүс (Customs warehouses and free zones)

I бүлэг. Гаалийн агуулах (Customs warehouses)

II бүлэг. Чөлөөт бүс (Free zones)

5. Тусгай хавсралт E - Дамжуулан өнгөрүүлэх (Transit)

I бүлэг. Дамжуулан өнгөрүүлэх гаалийн горим (Customs transit)

II бүлэг. Шилжүүлэн ачих (Transshipment)

III бүлэг. Барааг эргийн дагуу тээвэрлэх горим (Carriage of goods coastwise)

6. Тусгай хавсралт F - Бараанд боловсруулалт хийх (Processing)

I бүлэг. Дотоодод боловсруулах (Inward processing)

II бүлэг. Гадаадад боловсруулах (Outward processing)

III бүлэг. Татвар буцаан олгох горим (Drawback)

IV бүлэг. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах (Processing of goods for home use)

7. Тусгай хавсралт G - Түр хугацаагаар оруулах (Temporary admission)

I бүлэг. Түр хугацаагаар оруулах (Temporary admission)

8. Тусгай хавсралт H - Зөрчил (Offences)

I бүлэг. Гаалийн зөрчил (Customs offences)

9. Тусгай хавсралт J - Тусгай горимууд (Special procedures)

I бүлэг. Зорчигч (Travellers)

II бүлэг. Шуудан тээвэр (Postal traffic)

III бүлэг. Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгсэл (Means of transport for commercial use)

IV бүлэг. Олон улсын тээврийн үйлчилгээний бараа (Stores)

V бүлэг. Тусламжийн ачаа (Relief consignments)

10. Тусгай хавсралт K - Гарал үүсэл (Origin)

I бүлэг. Гарал үүслийн дүрэм (Rules of origin)

II бүлэг. Гарал үүслийг нотлох баримт (Documentary evidence of origin)

III бүлэг. Гарал үүслийн нотлох баримтыг шалгах (Control of documentary evidence of origin)

Эдгээр бүх хавсралт, бүлгийн заавар (Guidelines to the General Annex, Specific Annexes and Chapters therein)-ыг 2017 онд монгол хэл рүү хөрвүүлж, хэвлүүлсэн байгаа.



4. Түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on Simplification and Harmonization of Customs Procedures (The Kyoto Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Convention on Temporary Admission
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	(The Istanbul Convention)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	Конвенция о временном ввозе
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	1990-06-26. Турк Улсын Стамбул хот
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	(Istanbul, Turkey)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1993-11-27
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2017 оны байдлаар: 69 (68 улс + Европын холбоо)
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	2002-12-05 (Үндсэн конвенц, А, В1, В2, В5 хавсралт)
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	
- Конвенц соёрхон батлах тухай 2002 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль	
- Барааг түр хугацаагаар оруулах тухай конвенцийн В-З, С хавсралтад нэгдэн орсныг соёрхон батлах тухай 2007 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хууль	
- Конвенц хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2003 оны 145 дугаар тогтоол: Стамбулын Конвенцийн хүрээнд барааг Монгол Улсын хилээр түр хугацаагаар оруулах эрх бүхий гаалийн байгууллагын жагсаалт	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц нь холбогдох барааг түр хугацаагаар оруулах тухай дараах 13 хавсралттай (Монгол Улсын соёрхон баталсан хавсралтуудыг тодоор тэмдэглэв):

Хавсралт А: Түр хугацаагаар оруулах бичиг баримтад хамаарах хавсралт: АТА болон CPD карней (Annex Concerning Temporary Admission Papers: ATA Carnets and CPD Carnets)

Хавсралт В1: Үзэсгэлэн, яармаг худалдаа, уулзалт болон тэдгээртэй адилтгэх бусад арга хэмжээний үеэр үзүүлэх буюу ашиглах бараа (буцаан гаргах эцсийн хугацаа нь 6 сараас доошгүй байна) (Annex Concerning Goods For Display Or Use At Exhibitions, Fairs, Meetings Or Similar Events)

Хавсралт В2: Мэргэжлийн тоног төхөөрөмж (буцаан гаргах эцсийн хугацаа нь 12 сараас доошгүй байна) (Annex Concerning Professional Equipment)

Хавсралт В3: Худалдааны үйл ажиллагаатай холбогдуулан оруулах чингэлэг, ачааны тавиур, баглаа боодол, дээж загвар болон бусад бараа (буцаан гаргах эцсийн хугацаа нь 6 сараас доошгүй байна) (Annex Concerning Containers, Pallets, Packings, Samples and Other Goods Imported in Connection with a Commercial Operation)

Хавсралт В4: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдуулан оруулах бараа (Үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбогдуулан импортолсон барааг буцаан гаргах эцсийн хугацаа нь 12 сараас доошгүй байна, харин үйлдвэрлэлийн солих, орлох хэрэгслийг буцаан гаргах эцсийн хугацаа нь 6 сараас доошгүй байна) (Annex Concerning Goods Imported In Connection With A Manufacturing Operation)

Хавсралт В5: Боловсрол, шинжлэх ухаан, соёлын зориулалтаар оруулах бараа (6 сараас доошгүй хугацаанд буцаан гаргана) (Annex Concerning

Goods Imported For Educational, Scientific or Cultural Purposes)

Хавсралт В6: Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, спортын зориулалтаар оруулах бараа (Хувийн хэрэглээний эд зүйлсийг буцаан гаргах сүүлчийн хугацаа нь тэдгээрийг авч орж ирсэн этгээд тэдгээрийг түр хугацаагаар оруулсан нутаг дэвсгэрийг орхин гарах өдөр байна. Спортын зориулалтаар оруулсан барааг буцаан гаргах хугацаа нь түүнийг түр хугацаагаар оруулсан өдрөөс хойш 12 сараас доошгүй байна.) (Annex Concerning Travellers' Personal Effects and Goods Imported for Sports Purposes)

Хавсралт В7: Жуулчдад зориулсан зар сурталчилгааны материал (буцаан гаргах эцсийн хугацаа нь 6 сараас доошгүй байна) (Annex Concerning Tourist Publicity Material)

Хавсралт В8: Хилийн тээврээр оруулах бараа (Хилийн тээврээр оруулсан барааг буцаан гаргах хугацаа нь түүнийг түр хугацаагаар оруулсан өдрөөс хойш арван хоёр сараас доошгүй байна. Гэвч хилийн бүсэд байрших газар нутагт ажиллуулахаар оруулсан тоног төхөөрөмжийг уг ажил дууссан бол буцаан гаргана.) (Annex Concerning Goods Imported as Frontier Traffic)

Хавсралт В9: Хүмүүнлэгийн зорилгоор оруулах бараа (Эмнэлгийн, мэс заслын болон лабораторийн тоног төхөөрөмжийг буцаан гаргах хугацааг тэдгээрийн хэрэгцээг үндэслэн тогтооно. Тусламжийн ачааг буцаан гаргах хугацаа нь түүнийг түр хугацаагаар оруулсан өдрөөс хойш 12 сараас доошгүй байна) (Annex Concerning Goods Imported for Humanitarian Purposes)

Хавсралт С: Тээврийн хэрэгсэл (Худалдааны үйл ажиллагаанд ашиглах зориулалттай тээврийн хэрэгслийг холбогдох тээврийн үйл ажиллагаа дууссан бол буцаан гаргана. Хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэл түр хугацаагаар оруулсан нутаг дэвсгэрт арван хоёр сар тутам тасралттай, эсхүл тасралтгүй зургаан сарын хугацаагаар байж болно.) (Annex Concerning Means of Transport)

Хавсралт D: Мал, амьтад (буцаан гаргах эцсийн хугацаа нь 12 сараас доошгүй байна) (Annex Concerning Animals)

Хавсралт E: Импортын гаалийн болон бусад татвараас хэсэгчлэн чөлөөлж оруулах бараа. (буцаан гаргах эцсийн хугацааг хавсралтын 5, 6 дугаар зүйлийг харгалзан тогтооно) (Annex Concerning Goods Imported with Partial Relief from Import Duties and Taxes)

Уг Конвенцийн дараах хавсралтууд Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хувьд хүчин төгөлдөр болсноор холбогдох асуудлаар өмнө нь байгуулсан дор дурдсан Конвенц, зарим зүйл, заалт тухайн Талын хувьд хүчингүй болно:

- **Хавсралт А:** Барааг түр хугацаагаар оруулах зориуооттой АТА карнейн тухай гаалийн конвенц (the Customs Convention on the ATA carnet for the temporary admission of goods, Brussels, 6 December 1961 (ATA Convention));
- **Хавсралт В1:** Үзэсгэлэн, яармаг худалдаа, хурал чуулган болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үеэр үзүүлэх буюу хэрэглэх барааг оруулах хөнгөлөлттэй журмын тухай гаалийн конвенц (the Customs Convention concerning facilities for the importation of goods for display or use at exhibitions, fairs, meetings or similar events, Brussels, 8 June 1961);
- **Хавсралт В2:** Мэргэжлийн тоног төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of professional equipment, Brussels, 8 June 1961);
- **Хавсралт В3:**
 - Олон улсын тээвэрт ашигласан ачааны тавиурын гаалийн бүрдүүлэлтийн тухай Европын конвенц (European Convention on Customs treatment of pallets used in international transport, Geneva, 9 December 1960);
 - Баглаа боодлыг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (Customs Convention on the temporary importation of packings, Brussels, 6 October 1960);
 - Чингэлгийн тухай гаалийн конвенцийн 2-11 дүгээр зүйл, мөн Хавсралт 1 (1, 2 дугаар заалт) - 3 (Articles 2-11 and Annexes 1 (paragraphs 1 and 2) -3 to the Customs Convention on Containers, Geneva, 2 December 1972);
 - Худалданы дээж, загвар болон сурталчилгааны материалын импортыг хөнгөвчлөх тухай олон улсын Конвенцийн 3 болон 5 дугаар зүйл, мөн 6 дугаар зүйлийн 1.b болон 2 дахь заалт (Articles 3, 5 and 6 (1.b and 2) to the International Convention to facilitate the importation of commercial samples and advertising material, Geneva, 7 November 1952);

- **Хавсралт В5:**
 - Далайчдын халамжийн материалын тухай гаалийн конвенц (the Customs Convention on welfare material for seafarers, Brussels, 1 December 1964);
 - Шинжлэх ухааны багаж төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of scientific equipment, Brussels, 11 June 1968);
 - Сурган хүмүүжүүлэх материалыг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of pedagogic material, Brussels, 8 June 1970);
- **Хавсралт В6:** Аялал жуулчлалын гаалийн хөнгөлөлтийн тухай конвенцийн 2 болон 5 дугаар зүйл (Articles 2 and 5 of the Convention concerning Customs facilities for touring, New York, 4 June 1954);
- **Хавсралт В7:** Аялал жуулчлалын гаалийн хөнгөлөлтийн тухай конвенцийн “Жуулчдад зориулсан зар сурталчилгааны бичиг баримт болон материалыг оруулах тухай” нэмэлт протокол (the Additional Protocol to the Convention concerning Customs facilities for touring, relating to the importation of tourist publicity documents and material, New York, 4 June 1954);
- **Хавсралт С:**
 - Хувийн автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of private road vehicles, New York, 4 June 1954);
 - Худалдааны (үйл ажиллагаанд ашиглах зориулалттай) автотээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation of commercial road vehicles, Geneva, 18 May 1956);
 - Хувийн хэрэглээний агаарын хөлөг, аяллын завийг түр хугацаагаар оруулах тухай гаалийн конвенц (the Customs Convention on the temporary importation for private use of aircraft and pleasure boats, Geneva, 18 May 1956).

Бараа, тээврийн хэрэгслийг өөрийн нутаг дэвсгэрт байлгах түр хугацааг гаалийн байгууллага холбогдох хавсралтад зааснаас илүү урт хугацаагаар тогтоож, сунгаж болно (Конвенцийн 7.2).

Конвенцид заасан болзол нөхцлийг хангасан тохиолдолд түр хугацаагаар оруулах эрхийг өөр этгээдэд шилжүүлж болно (Конвенцийн 8 дугаар зүйл).

Түр хугацаагаар оруулсан бараа, тээврийн хэрэгслийг нэг, эсхүл хэд хэдэн ачилтаар, анх оруулснаас өөр боомтоор буцаан гаргаж болно (Конвенцийн 10, 11 дүгээр зүйл). Түр хугацаагаар оруулах ажиллагааг бараа (тээврийн хэрэгсэл хамаарна)-г дараа нь экспортлох, эсхүл зөвшөөрөгдсөн бусад зориулалтаар захиран зарцуулах зорилгоор эрх бүхий байгууллага зөвшөөрсөн бол чөлөөт боомт буюу чөлөөт бүсэд, эсхүл гаалийн агуулахад, эсхүл дамжин өнгөрүүлэх гаалийн горимд байршуулах замаар дуусгавар болгож болно (Конвенцийн 12 дугаар зүйл).

АТА карнейг түр хугацаагаар оруулах бараанд, CPD карнейг түр хугацаагаар оруулах тээврийн хэрэгсэлд тус тус хэрэглэнэ. Эдгээр нь гаалийн болон бусад татвар төлөх баталгаа болно. Баталгааны хэмжээ чөлөөлөгдсөн импортын гаалийн (ердийн, эсхүл нэн тааламжтай) болон бусад татварын хэмжээнээс хэтрэхгүй байна. Хориглосон, хязгаарласан бараа, тээврийн хэрэгслийн хувьд үндэсний хууль тогтоомжид зааснаар нэмэлт баталгаа шаардаж болно (Конвенцийн 4 дүгээр зүйл).

“АТА” гэдэг нь “Admission Temporaire/Temporary Admission.” (түр хугацаагаар оруулах) гэсэн франц, англи үгний хослол (A combination of French and English phrases “Admission Temporaire/Temporary Admission.”), “CPD” гэдэг нь “Carnet de Passage en Douane” (гаалиар нэвтрэх зөвшөөрөл) гэсэн франц үгний товчлол болно. Экспортын барааны АТА, CPD карнейг МҮХАҮТ олгоно. Импортын барааны АТА, CPD карнейг экспортлогч улсын эрх бүхий байгууллага олгоно. Түр хугацаагаар оруулах зөвшөөрөл олгохдоо, эдийн засгийн шинжтэй импортын хориг, хязгаарлалт хэрэглэхгүй бөгөөд, Хавсралт “E”-д зааснаас бусад тохиолдолд, импортын гаалийн болон бусад татвар авахгүй. (Конвенцийн 2.2 заалт).

Бараа (тээврийн хэрэгсэл хамаарна)-г байнга түр хугацаагаар оруулдаг этгээдээр “ерөнхий баталгаа” (general security) гаргуулж болно (Конвенцийн 4.2 заалт). Баталгааны хэмжээ түр чөлөөлөгдсөн импортын гаалийн (ердийн, эсхүл нэн тааламжтай) болон бусад татварын хэмжээнээс хэтрэхгүй байна (Конвенцийн 4.3 заалт). Хориглосон буюу хязгаарласан бараа (тээврийн хэрэгсэл хамаарна)-ны хувьд, дотоодын хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт баталгаа шаардаж болно (Конвенцийн 4.4 заалт).

ATA карнейн хувьд, баталгаа гаргагч холбооны төлөх төлбөр импортын гаалийн (ердийн, эсхүл нэн тааламжтай) болон бусад татварын хэмжээ, мөн түүний 10 хувиас хэтрэхгүй байна (Хавсралт А-гийн 8.2). Харин CPD карнейн хувьд уг төлбөр нь импортын гаалийн (ердийн, эсхүл нэн тааламжтай) болон бусад татварын хэмжээ, мөн хүүний нийт хэмжээнээс хэтрэхгүй байна (Хавсралт А-гийн 8.3). Түр хугацаагаар оруулж байгаа нутаг дэвсгэрийн гаалийн байгууллага тодорхой бараа (тээврийн хэрэгсэл хамаарна)-ны хувьд түр хугацаагаар оруулах бичиг баримтыг аливаа болзолгүйгээр хаасан бол холбогдох бараа, тээврийн хэрэгсэлд хамаарах төлбөрийг баталгаа гаргагч холбооноос шаардах эрхгүй болно. (Хавсралт А-гийн 8.3).

ATA карнейн хүчинтэй хугацаа дуусгавар болсноос хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол

холбогдох ATA карнейн хувьд дээрх төлбөрийг гаалийн байгууллага нэхэмжлэх эрхгүй болно (Хавсралт А-гийн 8.4). Харин CPD карнейн хувьд гаалийн байгууллага түүнд хаалт хийсэн тухай мэдэгдлийг түүний хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор баталгаа гаргагч холбоонд өгөөгүй бол дээрх төлбөрийг ямар ч нөхцөлд баталгаа гаргагч холбооноос шаардах эрхгүй болно (Хавсралт А-гийн 8.5).

ATA карнейг шуудан тээвэрт хэрэглэхгүй байхаар тайлбар хийж болно (Хавсралт А-гийн 18 дугаар зүйл). Энэ тохиолдолд Конвенцийн 29 дүгээр зүйлийг мөрдөнө. Монгол Улс ийм тайлбар хийгээгүй. Тиймээс Монгол Улс ATA карнейг шуудан тээвэрт хэрэглэхээс татгалзах эрхгүй юм.

ATA карнейн хуудсууд

- Ногоон өнгийн нүүр хуудас (нүүрэн тал) - Үүнд ATA карнейн эзэмшигч/хэрэглэгч (holder/user) буюу барааны эзэн (Owner of the goods)-ий тухай мэдээлэл, мөн ATA карнейг хүлээн зөвшөөрсөн улсын жагсаалт байна. https://www.atacarnet.com/sites/default/files/green_front_countries.jpg
- Ногоон өнгийн нүүр хуудас (ар тал) - Барааны жагсаалт.

A.T.A. CARNET FOR TEMPORARY ADMISSION OF GOODS
CARNEET A.T.A. POUR L'ADMISSION TEMPORAIRE DE MARCHANDISES
CUSTOMS CONVENTION OF THE U.S.A. CONVENTION POUR L'ADMISSION TEMPORAIRE DE MARCHANDISES
CONVENTION ON TEMPORARY ADMISSION / **CONVENTION RELATIVE A L'ADMISSION TEMPORAIRE**

A. HOLDER AND ADDRESS / **Titulaire et adresse**
B. REPRESENTED BY / **Représenté par**
C. INTENDED USE OF GOODS / **Destination prévue des marchandises**

D. FOR ISSUING ASSOCIATION USE / **Association**
1) A.T.A. CARNET No. / **Carte A.T.A. N°**
2) Number of continuation sheets / **Nombre de pages supplémentaires**
3) ISSUED BY / **Émise par**
4) VALID UNTIL / **Valable jusqu'à**

UNITED STATES COUNCIL FOR International Business

EUROPEAN COUNTRIES
 AUSTRIA (AT), BELGIUM (BE), BULGARIA (BG), CYPRUS (CY), CZECH REPUBLIC (CZ), DENMARK (DK), ESTONIA (EE), FINLAND (FI), FRANCE (FR), GERMANY (DE), GREECE (GR), HUNGARY (HU), IRELAND (IE), ITALY (IT), LITHUANIA (LT), LUXEMBOURG (LU), MALTA (MT), NETHERLANDS (NL), PORTUGAL (PT), ROMANIA (RO), SLOVAKIA (SK), SLOVENIA (SI), SPAIN (ES), SWEDEN (SE), UNITED KINGDOM (GB)

OTHER COUNTRIES
 ALGERIA (DZ), ANDREA (AO), AUSTRALIA (AU), BELARUS (BY), CANADA (CA), CHINA (CN), CUBA (CU), CROATIA (HR), CEYLON (CZ), HONG KONG, CHINA (HK), ICELAND (IS), INDIA (IN), ISRAEL (IL), JAPAN (JP), KOREA (KR), KOSOVO (KS), KUWAIT (KW), MALAYSIA (MY), MAURITIUS (MU), MOROCCO (MA), NEW ZEALAND (NZ), NORWAY (NO), PAKISTAN (PK), RUSSIA (RU), SINGAPORE (SG), SOUTH AFRICA (ZA), SRI LANKA (LK), SWITZERLAND (CH), THAILAND (TH), TURKEY (TR), UNITED STATES (US)

CONTINUATION SHEET GENERAL LIST No. 0
FEUILLE SUPPLEMENTAIRE LISTE GENERALE N° 0

CARNET No. / **Carte N°**
US 89/08-SAMPLE

Item No.	Trade description of goods and marks and numbers, if any	Number of Pieces	Weight or Volume	Value*	Country of Origin	Particulars (if any)
N° Article	Description commerciale des marchandises et, le cas échéant, marques et numéros	Nombre de Pièces	Poids ou Volume	Valeur*	Pays d'Origine	Détails (s'il y a lieu)
1	2	3	4	5	6	7
NO CHANGES OR ADDITIONS ABOVE OR BELOW THIS LINE						
TOTAL or CARRIED OVER / TOTAL ou A REPORTER						

- Шар, цагаан, цэнхэр өнгийн гэрчилгээний багц (yellow, white & blue certificate sets) - эдгээр нь тасалбар (counterfoils) болон ваучер (vouchers) юм. Тасалбарууд нь ATA карнейн эзэмшигчийн хяналтын баримт бөгөөд тэдгээрийг ATA карнейгаас салгаж үл болно (ATA карнейн хамт ATA карнейн эзэмшигчид үлдэнэ). Ваучерууд нь гаалийн байгууллагын хяналтын баримт бөгөөд гаалийн байгууллагад үлдэнэ.
- Шар өнгийн гэрчилгээний багц (yellow certificate sets) - энд зөвхөн барааг ATA карней олгосон улсын хилээр гаргах тасалбар, мөн уг улсад буцаан оруулах тасалбар байна. Энэ хуудсыг ATA карнейгаас салгаж болохгүй. Энд ваучер байхгүй.

COUNTERFOIL

A.T.A. CARNET / CARNET A.T.A. CARNET No. / Carnet N° **US 89/08-SAMPLE**

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

DO NOT REMOVE FROM THE CARNET / NE PAS DÉTACHER DU CARNET N2 (04/04)

COUNTERFOIL

A.T.A. CARNET / CARNET A.T.A. CARNET No. / Carnet N° **US 89/08-SAMPLE**

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

DO NOT REMOVE FROM THE CARNET / NE PAS DÉTACHER DU CARNET N2 (04/04)

- Цагаан өнгийн гэрчилгээний багц (white certificate sets) - энд барааг хүлээн авагч улсад оруулах тасалбар болон ваучер, мөн уг улсаас буцаан гаргах тасалбар болон ваучер байна.

Тасалбар (counterfoils)

COUNTERFOIL

A.T.A. CARNET / CARNET A.T.A. CARNET No. / Carnet N° **US 89/08-SAMPLE**

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Registered under reference No. 1? / Énuméré sous le N°1? 4. 5. 6. 7. 8.

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Registered under reference No. 1? / Énuméré sous le N°1? 4. 5. 6. 7. 8.

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

DO NOT REMOVE FROM THE CARNET / NE PAS DÉTACHER DU CARNET N3 (04/04)

COUNTERFOIL

A.T.A. CARNET / CARNET A.T.A. CARNET No. / Carnet N° **US 89/08-SAMPLE**

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Registered under reference No. 1? / Énuméré sous le N°1? 4. 5. 6. 7. 8.

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. have been temporarily imported, and are exported. / ont été temporairement importées et réexportées.

2. Final date for re-exportation to the Customs of goods? / Date limite pour la réexportation en douane des marchandises? year / month / day / annee / mois / jour

3. Registered under reference No. 1? / Énuméré sous le N°1? 4. 5. 6. 7. 8.

3. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.

1. The goods described in the General List under item No. 1. Les marchandises énumérées à la liste générale sous l'item N°1. which were temporarily imported under cover of expedition vouchers (Bills of Lading, Airway Bills, etc.) are now being re-exported. / lesquelles ont été temporairement importées sous couvert de (ou sous l'usage de) expéditionnaires (Bills of Lading, Airway Bills, etc.) sont maintenant réexportées. / de ce Carnet n'ont été réexportées qu'au porteur carnet ou des expéditionnaires.

2. Other remarks? / Autres remarques? 4. 5. 6. 7. 8.


DO NOT REMOVE FROM THE CARNET / NE PAS DÉTACHER DU CARNET N3 (04/04)

Ваучер (vouchers)

VOUCHER	
A.T.A. CARNET BY THE ISSUING AND ADDRESS: Issuing or address City, Country 225 N. Nough Street Burlington, V. 05401	
CARNET A.T.A. FOR ISSUING AND ADDRESS: Issuing or address City, Country 225 N. Nough Street Burlington, V. 05401	
1 A.T.A. CARNET No. US 8909-SAMPLE	G. RE-EXPORTATION VOUCHER No. 1 A.T.A. CARNET No. US 8909-SAMPLE
H. ISSUED BY: Issued by United States Council for International Business	
I. VALID UNTIL: Valid until 2009 4 24	
J. PURPOSE OF GOODS: Purpose of use for international Exhibitions and Fairs	
K. MEANS OF TRANSPORT: Means of transport	
L. PACKAGING DETAILS: Details: Size, Marks, etc. (For Customs Use Only)	
M. DECLARATION OF EXPORTER: Declaration of Exporter I, the undersigned, do hereby certify that the goods described in this carnet are for exportation to the countries named in the carnet and are to be used for the purposes stated in the carnet. I declare that the goods are not to be used for any other purpose and that they are not to be re-exported to the countries named in the carnet. I declare that the goods are not to be used for any other purpose and that they are not to be re-exported to the countries named in the carnet.	
N. OTHER INFORMATION: Other information (For Customs Use Only)	
O. SIGNATURE: Signature (For Customs Use Only)	
P. DATE: Date (For Customs Use Only)	
Q. CHECKS: Checks (For Customs Use Only)	
R. TOTAL: Total (For Customs Use Only)	
TO BE REMOVED BY FOREIGN CUSTOMS AT THE TIME OF VALIDATION A DÉTACHER PAR LES DOUANES ÉTRANGÈRES LORS DU VISA	

VOUCHER	
A.T.A. CARNET BY THE ISSUING AND ADDRESS: Issuing or address City, Country 225 N. Nough Street Burlington, V. 05401	
CARNET A.T.A. FOR ISSUING AND ADDRESS: Issuing or address City, Country 225 N. Nough Street Burlington, V. 05401	
1 A.T.A. CARNET No. US 8909-SAMPLE	G. RE-EXPORTATION VOUCHER No. 1 A.T.A. CARNET No. US 8909-SAMPLE
H. ISSUED BY: Issued by United States Council for International Business	
I. VALID UNTIL: Valid until 2009 4 24	
J. PURPOSE OF GOODS: Purpose of use for international Exhibitions and Fairs	
K. MEANS OF TRANSPORT: Means of transport	
L. PACKAGING DETAILS: Details: Size, Marks, etc. (For Customs Use Only)	
M. DECLARATION OF EXPORTER: Declaration of Exporter I, the undersigned, do hereby certify that the goods described in this carnet are for exportation to the countries named in the carnet and are to be used for the purposes stated in the carnet. I declare that the goods are not to be used for any other purpose and that they are not to be re-exported to the countries named in the carnet. I declare that the goods are not to be used for any other purpose and that they are not to be re-exported to the countries named in the carnet.	
N. OTHER INFORMATION: Other information (For Customs Use Only)	
O. SIGNATURE: Signature (For Customs Use Only)	
P. DATE: Date (For Customs Use Only)	
Q. CHECKS: Checks (For Customs Use Only)	
R. TOTAL: Total (For Customs Use Only)	
TO BE REMOVED BY FOREIGN CUSTOMS AT THE TIME OF VALIDATION A DÉTACHER PAR LES DOUANES ÉTRANGÈRES LORS DU VISA	




- Цэнхэр өнгийн гэрчилгээний багц (blue certificate sets) - энд барааг дамжуулан өнгөрүүлэх тасалбар болон ваучер байна.




Зураг 5. АТА карней ашиглаж буй улсууд



CPD карнейн хуудсууд



Зураг 6. CPD карней ашиглаж буй байдал



- CPD карней шаардах улсууд
- CPD карней бүхий автотээврийн хэрэгслийг зөвшөөрдөг улсууд
- CPD карней шаардах эсэх талаар мэдээллээ өгөөгүй улсууд



5. ТИР карней ашиглан барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай Конвенц (ТИР Конвенц)

1.a. Гэрээний нэр англиар:	Convention on the International Transport of Goods under Cover of TIR Carnets (The TIR Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Таможенная Конвенция о международной перевозке грузов с применением книжки МДП (Конвенция МДП, 1975 г.)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1975-11-14. Швейцарь Улсын Женев хот (Geneva, Switzerland)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1978-03-20
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2017 оны байдлаар: 73 (72 улс + Европын Холбоо)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2001-11-15
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2002-10-01
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2003-04-01
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Хамгийн сүүлчийн нэмэлт өөрчлөлт 2006 оны 8 дугаар сарын 12-нд хүчин төгөлдөр болсон. Түүгээр 10 дугаар хавсралтыг нэмж, ТИР карнейд электрон байдлаар хяналт тавих SafeTIR системийг нэвтрүүлэхээр заасан.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Конвенцид нэгдэн орох тухай 2001 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хууль - Конвени хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 86 дугаар тогтоол (Хавсралт 1: ТИР конвенцийн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэхэд монгол улсын нутаг дэвсгэрт гаалийн бүрдүүлэлт хийх, хяналт тавих байгууллагын жагсаалт; Хавсралт 2: ТИР конвенцийн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэхэд монгол улсын хилээр нэвтрүүлэх гаалийн байгууллагуудын жагсаалт)

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

“TIR” гэдэг нь “transports internationaux routiers” гэсэн франц үгний товчлол бөгөөд англиар “international road transport” (олон улсын автозамын тээвэр) гэсэн утгатай болно.

ТИР карней (ТИР дэвтэр, TIR Carnet, книжка МДП) нь ТИР тээвэрлэлтийн (ТИР тээврийн) явцад гаалийн болон бусад татвараас зайлсхийх эрсдлээс хамгаалж, тийм зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох улсын гаалийн хууль тогтоомжид заасан гаалийн болон бусад татвар, мөн уг хууль тогтоомжид заасан алданги төлөх, эсхүл гаалийн болон бусад татвар, алдангийн талаар заагаагүй бол захиргааны торгууль буюу

өөр бусад хэлбэрийн мөнгөн шийтгэл зэргийг төлөх баталгаа юм (8 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, тэдгээрийн тайлбар). Уг баталгааны хэмжээ ердийн барааны хувьд 50'000 ам. доллараас илүүгүй, тамхи, согтууруулах ундааны хувьд 200'000 ам доллараас илүүгүй байна (8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн тайлбар).

Уг карнейг автозамын тээврээр нэгээс доошгүй улсын хилээр дамжуулан тээвэрлэх бараанд хэрэглэнэ. Холимог тээврийн үед аль нэг хэсэгт нь автозамын тээвэр оролцсон байх ёстой. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарч Монгол Улсын хилээр буцаж орж ирэх бараанд ТИР карнейг хэрэглэж болно (2 дугаар зүйлийн тайлбар).

ТИР карнейг Олон улсын авто тээврийн холбоо (the International Road and Transport Union - IRU) хэвлэж тараана. Монгол Улсын экспортын барааны ТИР карнейг Монголын автотээвэр эрхлэгчдийн холбоо (NARTAM) олгоно.

ТИР конвенц нь илгээгч улсын (илгээгч газрын) нэг буюу хэд хэдэн гаалийн байгууллагаас хүлээн авагч улсын (хүрэх газрын) нэг буюу хэд хэдэн гаалийн байгууллага хүртэл (эдгээр нь нийлээд бүгд 4 хүртэл тооны гаалийн байгууллага байна) бараа тээвэрлэх олон улсын тээврийн үйл ажиллагааг хөнгөвчилж өгдөг. Дамжин өнгөрөх улсын (завсрын гаалийн байгууллагын) тоо хэд ч байж болно. ТИР үйл ажиллагаанд ашиглах авто тээврийн хэрэгсэл (тээврийн хэрэгслийн хослол, эсхүл чингэлэг) энэхүү конвенцид тусгагдсан тусгай шаардлагыг хангасан (энэ тохиолдолд төрийн эрх бүхий байгууллага “зөвшөөрлийн гэрчилгээ” (approval certificate) олгоно) байх ёстой бөгөөд зөвхөн гаалийн байгууллагаас зөвшөөрсөн тээвэрлэгч ТИР горимын дагуу бараа тээвэрлэх эрхтэй байна. ТИР карней бүхий бараа тээвэрлэж буй автомашин нь тээвэрлэлтийн бүхий л хугацаанд гаалийн битүүмжлэлтэй байна. Тэгэхээр тийм битүүмжлэлтэй барааг зарчмын хувьд хил дээр шалгахгүй. Гэвч гаалийн байгууллага тийм барааг сэжигтэй гэж үзвэл, эсхүл санамсаргүй сонголтын үндсэн дээр шалгаж болно.

ТИР карней (ТИР дэвтэр) нь дараах хуудсуудаас бүрдэнэ:

ТИР карнейн нүүр хуудас
(хавтас, TIR carnet cover page)

- ТИР карнейн нүүр хуудас (хавтас, TIR carnet cover page);
- гаалийн бус барааны манифест болох шар өнгийн хуудас (yellow non-Customs goods manifest);
- цагаан болон ногоон өнгийн хос ваучер - тасалбар болон ТИР үйл ажиллагааг дуусгавар болгох гэрчилгээний хамт (pairs of white and green vouchers (volet) - with their counterfoils (souche) and certificate of termination);
- тусгай тэмдэглэлийн хуудас (баталгаажсан мэдээ, протокол, certified report (procis-verbal de constat));
- ТИР карнейн арын хуудас, бар код бүхий таслах картны хамт (back cover with tear-off card - there is a card with a bar code or a numbered corner (slip) on the back cover).

ТИР карнейн нүүр хуудасны эхний 4 нүдийг баталгаа гаргач холбоо (guaranteeing association) ТИР карней олгох үед, тээвэрлэлт эхлэхээс өмнө бөглөнө. 5 дахь нүдэнд олон улсын байгууллага (IRU)-ын даргын гарын үсэг байна. 6-12 дахь нүдийг ТИР карнейн эзэмшигч (тээвэрлэгч) мөн ТИР карней олгох үед, тээвэрлэлт эхлэхээс өмнө бөглөнө. ТИР карнейг илгээгч газрын гаалийн байгууллага түүнийг олгосноос хойш 60 хоногийн дотор баталгаажуулна.

Гаалийн бус барааны манифест
(Non-Customs Goods Manifest)

Гаалийн бус барааны манифест бүхий шар хуудсыг ТИР карнейн эзэмшигч (тээвэрлэгч) тээвэрлэлт эхлэхээс өмнө бөглөнө. Энэ хуудас нь гаалийн хувь биш учир түүнийг гаалийн байгууллага авч үлдэж болохгүй.

Цагаан өнгийн хуудас №1-д байгаа ваучер №1 болон түүний тасалбар №1-ийг илгээгч гаалийн байгууллага (бас ТИР карнейн эзэмшигч) тээвэрлэлт эхлэхийн өмнө бөглөж, ваучер №1-ийг авч үлдэн, бүртгэлд оруулж, ТИР карнейг тасалбар №1-ийн хамт жолоочид буцаан өгнө.

Ногоон өнгийн хуудас №2-т байгаа ваучер №2 болон түүний тасалбар №2-ыг илгээгч улсын хилийн гарах боомтын гаалийн байгууллага (бас

ТИР карнейн эзэмшигч) тээвэрлэлт эхлэхийн өмнө бөглөж, ваучер №2-ыг авч үлдэн, бүртгэлд оруулж, ТИР карнейг тасалбар №2-ын хамт жолоочид буцаан өгнө. Ваучер №2-ын 18-28 дахь нүд бүхий тухайн ТИР үйл ажиллагааг дуусгавар болгосон гэрчилгээг таслан авч, илгээгч гаалийн байгууллага руу явуулна. Үүгээр илгээгч улс дахь ТИР үйл ажиллагаа дуусгавар болно.

Цагаан болон ногоон өнгийн хос ваучер -тасалбар болон ТИР үйл ажиллагааг дуусгавар болгох гэрчилгээний хамт (Pairs of white and green vouchers (volets) - with their counterfoils (souches) and certificate of termination)

CLEAR FORM
VOLET N° 1
CARNET TIR MX51000000

CLEAR FORM
VOLET N° 1
CARNET TIR MX51000000

CLEAR FORM
VOLET N° 1
CARNET TIR MX51000000

MANIFESTE DE MARCHANDISES

SOUCHÉ N° 1 MX51000000 PAGE 3 du CARNET TIR

CLEAR FORM
VOLET N° 2
CARNET TIR MX51000000

CLEAR FORM
VOLET N° 2
CARNET TIR MX51000000

CLEAR FORM
VOLET N° 2
CARNET TIR MX51000000

MANIFESTE DE MARCHANDISES

SOUCHÉ N° 2 MX51000000 PAGE 6 du CARNET TIR

ТИР карней нь дамжин өнгөрөх улс (гаалийн байгууллага)-ын тооноос хамаарч 4, 6, 14, 20 ширхэг ваучертай байна. ТИР үйл ажиллагаа бүрт 1 цагаан, 1 ногоон өнгийн хос ваучер шаардагдана. Хэрэв ТИР тээвэрлэлт 1 улсаар дамжин өнгөрөх бол 6 ваучер байх бөгөөд дамжин өнгөрөх улсын хилийн орох боомтын гаалийн байгууллага цагаан өнгийн хуудас №3-т байгаа ваучер №1-ийг, тэрхүү дамжин өнгөрөх улсын хилийн гарах боомтын гаалийн байгууллага ногоон өнгийн хуудас №4-т байгаа ваучер №2-ыг бөглөж, өөртөө авч үлдэнэ. Эдгээр хуудсанд байгаа тасалбар №1 болон №2 нь ТИР карнейн хамт жолоочид үлдэнэ. Үүгээр уг дамжин өнгөрөх улс дахь ТИР үйл ажиллагаа дуусгавар болно. ТИР үйл ажиллагааг дамжин

өнгөрөх улсад дуусгавар болгосон хилийн гарах боомтын гаалийн байгууллага ногоон өнгийн хуудас №4 дэх ТИР үйл ажиллагааг дуусгавар болгох гэрчилгээг өөрийн хилийн орох боомтын гаалийн байгууллагад буцаан илгээнэ. Хэрэв ТИР тээвэрлэлт 1 улсаар дамжин өнгөрсөн бол хүлээн авагч улсын хилийн орох боомтын гаалийн байгууллага цагаан өнгийн хуудас №5-д байгаа ваучер №1-ийг, бараа хүрэх газрын гаалийн байгууллага ногоон өнгийн хуудас №6-д байгаа ваучер №2-ыг бөглөж, өөртөө авч үлдэнэ.

Дээрх маягаар ТИР тээвэр нэлээд хэдэн улс, нэлээд хэдэн гаалийн байгууллагаар дамжин өнгөрч болно.

Тусгай тэмдэглэлийн хуудас (баталгаажсан мэдээ, протокол, certified report) (procis-verbal de constat)

ТИР карнейн арын хуудас, таслах картны хамт (back cover with tear-off card)

Гаалийн байгууллага ТИР тээвэрлэлт хийх маршрут, цаг хугацааг тогтоон өгч болно. Тээвэрлэгч (ТИР карнейн эзэмшигч буюу жолооч) хэрэв үер ус, цасан шуурга, автомашины эвдрэл гэмтэл зэрэг аливаа нэг шалтгаанаар тэрхүү маршрут, цаг хугацааг баримталж чадаагүй замдаа саатсан бол түүнийгээ нотлох баримттай байх ёстой. Ломбо гэмтсэн, барааг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих шаардлага гарсан, ачаа бүхэлдээ, эсхүл зарим хэсэг нь эвдэрч гэмтсэн зэрэг ноцтой хэрэг гарсан тохиолдолд тээвэрлэгч ТИР карнейн "тусгай тэмдэглэлийн хуудас" (баталгаажсан мэдээ, протокол, certified report,

procis-verbal de constat)-ыг ашиглан орон нутгийн аль боломжтой төрийн байгууллагаас албан ёсны тодорхойлолт хийлгэсэн байна.

Эрх бүхий байгууллага аль нэг ТИР карнейг хугацаа нь дууссан гэдэг шалтгаанаар, эсхүл мөрдөн шалгалт явуулах шаардлага гарсан зэрэг шалтгаанаар саатуулах бол уг ТИР карнейн арын хуудасны картыг таслан ТИР карнейн эзэмшигчид өгнө. Уг картан дээр холбогдох ТИР карнейг саатуулсан байгууллагын нэр, хаяг, огноо, шаардлагатай өөр бусад мэдээллийг бичиж, гарын үсэг зуран, тамга (тэмдэг) дарсан байна. ТИР карнейг саатуулсан байгууллага уг ТИР



6. Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох зорилгоор байгууллага хооронд харилцан туслах тухай олон улсын Конвенц (Наиробийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on Mutual Administrative Assistance for the Prevention, Investigation and Repression of Customs Offences (The Nairobi Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Международная Конвенция о взаимном административном содействии в предотвращении, расследовании и пресечении таможенных правонарушений (Наиробская Конвенция)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1977-06-09. Кени Улсын Наироби хот (Nairobi, Kenya)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1980-05-21
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2012 оны байдлаар: 52
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	2003 оны "Гаалийн асуудлаар байгууллагын хүрээнд харилцан туслах тухай" Йоханнесбургийн Конвенцоор уг Конвенцийн бүх хавсралтуудыг нэгтгэн, шинэчилсэн.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хоёр талын хэлэлцээрүүд (16 улстай байгуулсан - эдгээрийн хэлэлцээрийн жагсаалтыг энэ номны "Олон улсын хоёр талт гэрээ"-ний хэсгийн VI бүлэгт оруулсан байгаа.)

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц нь холбогдох асуудлыг зохицуулсан дараах 11 хавсралттай:

1. Гаалийн аль нэг байгууллага өөрийн санаачилгаар туслалцаа үзүүлэх (Assistance by a Customs administration on its own initiative) - Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гаалийн ноцтой зөрчил үйлдэж болзошгүй гэсэн хангалттай үндэслэл байгаа тохиолдолд материаллаг туслалцаа үзүүлэх, эсхүл мэдээлэл дамжуулах;
2. Импорт, экспортын гаалийн болон бусад татварыг ногдуулахад/тооцоход нөгөө талын хүсэлтээр туслалцаа үзүүлэх

(Assistance on request, in the assessment of import or export duties and taxes) - гаалийн ноцтой зөрчил үйлдсэн гэж үзвэл барааны үнэ, тарифын ангилал, гарал үүсэлтэй холбоотой мэдээлэл өгөх;

3. Хяналттай холбоотой асуудлаар нөгөө талын хүсэлтээр туслалцаа үзүүлэх (Assistance, on request, relating to controls) - бичиг баримт үнэн зөв, импорт, экспортын үйл ажиллагаа хууль ёсны болох талаар мэдээлэл өгөх;
4. Ажиглалт/гүйцэтгэх ажил хийхтэй холбогдсон асуудлаар хүсэлтийн дагуу туслалцаа үзүүлэх (Assistance, on request, relating to surveillance) - сэжигтэй этгээд, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн,

- хууль бус худалдааны бараа хадгалж буй газрын талаар мэдээлэл өгөх;
5. Хэлэлцэн тохирогч өөр нэг Талын нэрийн өмнөөс байцаалт явуулах, мэдэгдэх (Enquiries and notifications, on request, on behalf of another Contracting Party) - Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал өөрийн нутаг дэвсгэрт явуулсан байцаалтын протокол, эд мөрийн баримтыг хүсэлт гаргасан талд хүргүүлнэ. Мөн авсан арга хэмжээ, гаргасан шийдвэрийн талаар өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж буй холбогдох этгээдэд мэдэгдэнэ;
 6. Гаалийн байцаагч гадаад орны шүүх хуралдаанд оролцох (Appearance by Customs officials before a court or tribunal abroad) - гаалийн зөрчилтэй холбогдуулан гаалийн байцаагч хүсэлт тавьсан орны шүүх хуралдаанд гэрчээр, эсхүл мэргэжилтнээр оролцох эрх олгох (бичгээр гаргасан мэдүүлэг хангалтгүй тохиолдолд);
 7. Хэлэлцэн тохирогч нэг Талын гаалийн байцаагч Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллах (Presence of Customs officials of one Contracting Party in the territory of another Contracting Party) -санхүүгийн бүртгэл, дэвтэр, бусад бичиг баримтын талаар тодруулга хийх зорилгоор хүсэлт гаргасан улсын нутаг дэвсгэрт ажиллах эрх олгох;
 8. Гадаад оронд явуулж буй мөрдөн шалгах ажиллагаанд оролцох (Participation in investigations abroad) - 7 дугаар хавсралтад заасан ажиллагааг гүнзгийрүүлэн явуулах;
 9. Мэдээлэл татах (Pooling of information) - Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл гаалийн луйвартай холбогдсон мэдээллийн төв/нэгдсэн бааз үүсгэх, судалгаа хийх, тойм бэлдэх, түүнийгээ Хэлэлцэн тохирогч Талуудад хүргүүлэх - контрабанд үйлдсэн, үйлдэхийг завдсан этгээд, контрабандаас өөр бусад гаалийн луйвар, тэдгээрийг үйлдсэн арга (including fraud by forgery, falsification and counterfeiting), олон улсын ашиг сонирхол хөндөгдөхөөр бол контрабандад холбогдсон тээврийн хэрэгслийн талаар;
 10. Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисын контрабандын эсрэг арга хэмжээ авахад туслалцаа үзүүлэх (Assistance in actions against the smuggling of narcotic drugs and psychotropic substances) -өөрийн санаачилгаар мэдээлэл солилцох, нөгөө талын хүсэлтээр, ажиглалт хийх асуудлаар туслалцаа үзүүлэх, нөгөө талын нэрийн өмнөөс байцаалт явуулах, гаалийн байцаагч нөгөө талын нутаг дэвсгэрт ажиллах, шүүх болон мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мэдээллийн бааз үүсгэх, дээрх контрабандтай холбогдсон санхүүгийн операцийг хамруулах, НҮБ болон Интерполтой хамтран ажиллах, дотоодын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх;
 11. Урлагийн бүтээл, эртний эд зүйлс, соёлын бусад өвийн контрабандын эсрэг арга хэмжээ авахад туслалцаа үзүүлэх (Assistance in actions against the smuggling of works of art, antiques and other cultural property) - Соёлын өвийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг хууль бусаар шилжүүлэх явдлыг хориглох, урьдчилан сэргийлэх арга замын тухай ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенцийг хэрэгжүүлэх - өөрийн санаачилгаар мэдээлэл солилцох, нөгөө талын хүсэлтээр, ажиглалт хийх асуудлаар туслалцаа үзүүлэх, нөгөө талын нэрийн өмнөөс байцаалт явуулах, гаалийн байцаагч нөгөө талын нутаг дэвсгэрт ажиллах, шүүх болон мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, ДГБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт мэдээллийн бааз үүсгэх, дээрх контрабандтай холбогдсон санхүүгийн операцийг хамруулах.
- I-IX хавсралтад худалдааны луйврыг ерөнхийлөн авч үзсэн бол X, XI хавсралтаар тодорхой барааны луйвартай холбоотой асуудлыг зохицуулсан болно.



7. Гаалийн асуудлаар байгууллагын хүрээнд харилцан туслах тухай Конвенц (Йоханнесбургийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	International Convention on mutual administrative assistance in Customs matters (The Johannesburg Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о взаимном административном содействии по таможенным вопросам (Йоханнесбургская Конвенция)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	2003-06-27. Бельги Улсын Брюссель хот (Brussels, Belgium)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	Хүчин төгөлдөр болоогүй
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 2
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	-
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	-
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	-
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	-
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай хоёр талын хэлэлцээрүүд (16 улстай байгуулсан - эдгээрийн хэлэлцээрийн жагсаалтыг энэ номны "Олон улсын хоёр талт гэрээ"-ний хэсгийн VI бүлэгт оруулсан байгаа.)

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

"Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох зорилгоор байгууллага хооронд харилцан туслах тухай" 1977 оны олон улсын Наиробийн Конвенц, түүний 11 хавсралтыг нэгтгэн дараах бүтцийг бий болгосон:

Удиртгал хэсэг (Preamble)

I бүлэг: Тодорхойлолтууд (Definitions)

- 1 дүгээр зүйл. Конвенцид хэрэглэсэн 22 нэр томъёог тодорхойлсон.

II бүлэг: Конвенцийн үйлчлэх хүрээ (Scope of the Convention)

- 2 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч Талууд гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох, мөн олон улсын хэмжээнд бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хамгаалах (to ensure the security of the international trade supply chain) зорилгоор гаалийн хууль тогтоомжийг зохих ёсоор мөрдүүлэх үүднээс энэхүү Конвенцид заасан хүрээнд харилцан туслалцаа үзүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал энэхүү Конвенцийн дагуу аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ дотоодын хууль тогтоомжийн заалт, өөрийн гаалийн байгууллагын эрх хэмжээ, нөөц бололцоог харгалзан үзнэ. Энэхүү Конвенц нь “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай” хоёр талын Хэлэлцээрийн заалтыг хөндөхгүй бөгөөд хэрэв хоёр талын Хэлэлцээрт өөр байгууллага туслалцаа үзүүлэх тухай заасан бол энэ тухай мэдэгдэж, тухайн Хэлэлцээрийн заалтыг мөрдөнө. Тулалцаа хүсэх тухай хүсэлт гаргахад аливаа этгээд саад хийх эрхгүй.

III бүлэг: Туслалцаа үзүүлэх нийтлэг процедур (General Assistance Procedures)

- 3 дугаар зүйл. Хүсэлт хүргүүлэх (Communication of Requests)
- 4 дүгээр зүйл. Туслалцааг цаг алдалгүй (яаралтай, шуурхай) үзүүлэх (Spontaneous Assistance)

IV бүлэг: Мэдээлэл (Information)

- 5 дугаар зүйл. Гаалийн хууль тогтоомжийн заалт хэрэглэх, сахиулах зорилготой мэдээлэл (Information for the Application and Enforcement of Customs Law)
- 6 дугаар зүйл. Гаалийн зөрчилтэй холбогдсон мэдээлэл (Information Relating to Customs Offences)
- 7 дугаар зүйл. Импорт, экспортын гаалийн болон бусад татварыг ногдуулах/тооцох зорилготой мэдээлэл (Information for the Assessment of Import or Export Duties and Taxes)
- 8 дугаар зүйл. Тодорхой төрлийн мэдээлэл (Particular Types of Information)
- 9 дүгээр зүйл. Мэдээллийг автоматаар солилцох (Automatic Exchange of Information)
- 10 дугаар зүйл. Мэдээллийг урьдчилан солилцох (Advance Exchange of Information)

V бүлэг: Туслалцаа үзүүлэх өвөрмөц хэлбэрүүд (Special Types of Assistance)

- 11 дүгээр зүйл. Ажиглалт хийх (гүйцэтгэх ажил явуулах)(Surveillance)
- 12 дугаар зүйл. Хяналтын дор хүргэх (Controlled Delivery)
- 13 дугаар зүйл. Мэдэгдэх (Notification)
- 14 дүгээр зүйл. Гаалийн нэхэмжлэлийг барагдуулах (Recovery of Customs Claims)
- 15 дугаар зүйл. Мэргэжилтэн болон гэрчийн этгээд (Experts and Witnesses)
- 16 дугаар зүйл. Албан тушаалтнууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байлцах (Presence of Officials in the Territory of Another Contracting Party)
- 17 дугаар зүйл. Хүсэлт гаргасан байгууллагын албан тушаалтнууд хүсэлт хүлээн авсан байгууллагын урилгаар байлцах (Presence of Officials of the Requesting Administration at the Invitation of the Requested Administration)
- 18 дугаар зүйл. Айлчлал хийж буй албан тушаалтнуудад хамаарах арга хэмжээ (Arrangements for Visiting Officials)

VI бүлэг: Хил дамнасан хамтын ажиллагаа (Cross-Border Co-operation)

- 19 дүгээр зүйл. Ерөнхий зүйл (General Provisions)
- 20 дугаар зүйл. Халуун мөр хөөх (Hot Pursuit)
- 21 дүгээр зүйл. Хил дамнуулан ажиглалт хийх/гүйцэтгэх ажил явуулах (Cross-Border Surveillance)
- 22 дугаар зүйл. Нууц мөрдөн шалгалт явуулах (Covert Investigations)
- 23 дугаар зүйл. Хяналт, мөрдөн шалгалт явуулах хамтарсан баг (Joint Control and Investigation Teams)

VII бүлэг: Мэдээлэл ашиглах, нууцлах, хамгаалах (Use, Confidentiality and Protection of Information)

- 24 дүгээр зүйл. Мэдээлэл ашиглах (Use of Information)
- 25 дугаар зүйл. Мэдээллийг нууцлах, хамгаалах (Confidentiality and Protection of Information)
- 26 дугаар зүйл. Хувийн мэдээл баримтыг хамгаалах (Personal Data Protection)

VIII бүлэг: Мэдээллийг төвлөрүүлэх (Centralization of Information)

- 27 дугаар зүйл. Төвлөрүүлэх зорилго (Purpose of Centralization)
- 28 дугаар зүйл. Хувь этгээдэд хамааралгүй мэдээлэл (Non-Personal Information)
- 29 дүгээр зүйл. Хувь хүн болон хуулийн этгээдийн тухай мэдээлэл (Information on Natural and Legal Persons)
- 30 дугаар зүйл. Бусад мэдээлэл (Other Information)
- 31 дүгээр зүйл. Мэдээллийн автоматжуулсан төв систем (Central Automated Information System)
- 32 дугаар зүйл. Мэдээллийн автоматжуулсан төв системийн менежмент (Management of the Central Automated Information System)

IX бүлэг: Мэдээллийн автоматжуулсан төв системийн аюулгүй байдал (Security of the Central Automated Information System)

- 33 дугаар зүйл. Аюулгүй байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг (Responsibility for Security Measures)
- 34 дүгээр зүйл. Аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх (Implementation of Security Measures)

X бүлэг: Мэдээллийн автоматжуулсан төв системийн мэдээллийг хамгаалах (Protection of Information in the Central Automated Information System)

- 35 дугаар зүйл. Мэдээлэл оруулах (Inclusion of Information)
 - 36 дугаар зүйл. Мэдээлэл ашиглах (Use of Information)
 - 37 дугаар зүйл. Хувийн мэдээллийг хадгалах (Retention of Personal Data)
 - 38 дугаар зүйл. Нэвтрэх (Access)
 - 39 дүгээр зүйл. Мэдээллийн автоматжуулсан төв систем дэх хувь этгээдэд хамааралгүй мэдээлэлд өөрчлөлт оруулах (Modification of Non-Personal Information in the Central Automated Information System Use of Information)
 - 40 дүгээр зүйл. Мэдээллийн автоматжуулсан төв систем дэх хувийн мэдээ баримтад өөрчлөлт оруулах (Modification of Personal Data in the Central Automated Information System Use of Information)
 - 41 дүгээр зүйл. Үүрэг, хариуцлага (Responsibilities and Liabilities)
- XI бүлэг: Туслалцаа үзүүлэхээс татгалзах, Конвенцид тайлбар хийх (Exemptions and Reservations)
- 42 дугаар зүйл. Туслалцаа үзүүлэхээс татгалзах reciprocity
 - 43 дугаар зүйл. Конвенцид тайлбар хийх (Reservations) - Конвенцийн 9, 10, 12, 14, 15, 16, 17, 19, 20, 21, 22, 23, 29, 30 дугаар зүйлүүдэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тайлбар хийж болно.

XII бүлэг: Зардал (Costs)

- 44 дүгээр зүйл. (Мэргэжилтэн болон гэрчийн этгээд нь төрийн албан хаагч биш бол зардлыг ерөнхийдөө хүсэлт гаргасан тал хариуцна. Бусад тохиолдолд талууд тухай бүр хэлэлцэн тохирно)

XIII бүлэг: Төгсгөлийн заалтууд (Final Provisions)

- 45-54 дугаар зүйл. АНУ-д болсон 2001 оны 9 дугаар сарын 11-ний өдрийн аллага (terrorist action)-ын дараахан байгуулагдсан, хил дамнасан гэмт хэрэг (transnational crime), төсвийн луйвар (revenue fraud)-тай тэмцэх, хилийн аюулгүй байдал (border security)-ыг хамгаалах хүрээнд Хэлэлцэн тохирогч Талууд гаалийн хууль тогтоомжийг зохих ёсоор мөрдүүлэх үүднээс мэдээлэл солилцох, хүсэлтийн дагуу туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тавьсан энэхүү Конвенц нь харилцан адил байх зарчимд тулгуурласан бөгөөд нэгэнт Хэлэлцэн тохирогч тал болсон бол тухайн тал тайлбаргүйгээр хүлээн зөвшөөрсөн бүх заалтуудыг заавал дагаж мөрдөх ёстой. Конвенцийн заалтуудыг тайлбарласан Тайлбар бичиг бас бий (The Convention is supported by the Commentary that explains the provisions of the Convention).



8. Гаалийн байгууллага дахь сайн засаглал, ариун шударга ёсны тухай тунхаглал (Арушагийн тунхаглал)

1.а. Гэрээний нэр англиар:	The WCO Declaration Concerning Good Governance and Integrity in Customs (Arusha Declaration)
1.б. Гэрээний нэр оросоор:	Декларация Аруша о профессиональной этике
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1993-07-07. Танзани Улсын Аруша хот (Arusha, Tanzania)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	-
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	-
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	-
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	-
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	-
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	2003 оны 6 дугаар сард Брюссель хотноо ДГБ-ын 101/102 дугаар чуулганаар шинэчлэгдсэн.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - 2008 оны Гаалийн тухай болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиуд - Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм (ЗГТ 2009-4-1, №90) - ГУБ-ийн ёс зүйн дүрэм (ГЕГ 2009-10-19, №534) - ГУБ-ийн үйлчилгээний стандарт (ГЕГ 2005-3-2, №121)

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

ДГБ-ын 81/82 дугаар чуулганаар анх батлагдаж, 101/102 дугаар чуулганаар шинэчлэгдсэн эл Тунхаглалаар ДГБ ариун шударга ёсыг бэхжүүлэх нь бүх үндэстэн, гаалийн бүх байгууллагын хувьд ноцтой асуудал болж, авилга (хээл хахууль) нүүрлэсэн тохиолдолд гаалийн байгууллагын үүргээ эрчимтэй гүйцэтгэх чадвар эрс хязгаарлагдаж болзошгүй бөгөөд авилга (хээл хахууль) нь дараах сөрөг үр дагавартай байж болохыг хүлээн зөвшөөрсөн:

- үндэстний аюулгүй байдал, хамтын нийгэмлэгийн хамгаалалт сулрах;
- төсвийн орлого алдагдах, төсвийн орлогоос луйвардах;
- гадаадын хөрөнгө оруулалт багасах;

- эцсийн эцэст нийгмийн нуруун дээр үүрэгдэх зардал өсөх;
- олон улсын худалдаа, эдийн засгийн өсөлтөд саад бэрхшээл учирах;
- төрийн албадад чиглэсэн олон нийтийн итгэл, үнэмшил буурах;
- гаалийн байгууллагууд, төрийн бусад албад хоорондын хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийн түвшин доошлох;
- гаалийн хууль тогтоомжийг сайн дурын үндсэн дээр сахин биелүүлэх түвшин буурах;
- боловсон хүчний ёс суртахуун, 'esprit de corps' доошлох;

Тунхаглалд дор дурдсан 10 зүйлийг тусгасан болно.

Хүснэгт 11. Арушагийн тунхаглалд тусгасан 10 зүйл

1. Манлайлал, үүрэг амлалт (Leadership and Commitment):	
<p>Авилгаас урьдчилан сэргийлэх гол хариуцлага гаалийн байгууллагын дарга, удирдлагад ногдоно. Ариун шударга ёсыг ягштал сахих шаардлагатайг цохон тэмдэглэж, авилгатай тэмцэх урт хугацааны үүрэг амлалт авбал зохино. Гаалийн байгууллагын дарга, удирдлага бүхнийг манлайлах үүрэгтэй ажиллаж, ариун шударга ёсыг гаалийн ажлын бүх хүрээнд ягштал сахиулах үүрэг хариуцлагатайгаа хүлээн зөвшөөрнө. Гаалийн байгууллагын удирдлагууд ариун шударга ёсыг эргэлзээгүй баримталдаг болохоо харуулж, Ёс зүйн дүрмийн үг үсэг, утга санаанд нийцсэн үлгэр жишээ үзүүлбэл зохино.</p>	<p>The prime responsibility for corruption prevention must rest with the head of Customs and the executive management team. The need for high levels of integrity must be stressed and commitment to the fight against corruption maintained over the long term. Customs managers and supervisors should adopt a strong leadership role and accept an appropriate level of responsibility and accountability for maintaining high levels of integrity in all aspects of Customs work. Customs managers should demonstrate a clear and unequivocal focus on integrity and be seen to set an example that is consistent with both the letter and spirit of the Code of Conduct.</p>
2. Эрх зүйн хүрээ (Regulatory Framework):	
<p>Гаалийн хууль, журам, заавар, горимуудыг хооронд нь дээд зэргээр уялдуулан, хялбарчилбал зохино. Ингэснээр гаалийн үйл ажиллагаанд элдэв хүндрэл гарахгүй болно. Олон улсын хэмжээнд тохиролцсон болон хүлээн зөвшөөрөгдсөн Конвенцууд, бусад гэрээ Хэлэлцээр, тэдгээрийн заалтуудыг батлах явдал энэ явцад хамаарна. Хүнд суртлыг арилгах, ажлын (шаардлагагүй) давхардлыг багасгах зорилгоор гаалийн практик үйл ажиллагааг хянан үзэж, шинэчлэн өөрчилж байх шаардлагатай. Гаалийн албан татварын хувь хэмжээг болж өгвөл зөөлрүүлж, хуулийн дагуу татвараас чөлөөлөх явдлыг цөөлөх хэрэгтэй. (Автоматжуулсан) системүүд болон горимууд нь Гаалийн горимыг хялбарчилах, уялдуулах тухай олон улсын шинэчлэгдсэн Конвенц (Киотогийн шинэчлэгдсэн Конвенц)-д нийцсэн байх ёстой.</p>	<p>Customs laws, regulations, administrative guidelines and procedures should be harmonized and simplified to the greatest extent possible so that Customs formalities can proceed without undue burden. This process involves the adoption of internationally agreed conventions, other instruments and accepted standards. Customs practices should be reviewed and redeveloped to eliminate red tape and reduce unnecessary duplication. Duty rates should be moderated where possible and exemptions to standard rules be minimized. Systems and procedures should be in accordance with the revised International Convention on the Simplification and Harmonization of Customs Procedures (Revised Kyoto Convention).</p>
3. Ил тод байдал (Transparency):	
<p>Гаалийн байгууллагын түншүүд гаалийн байгууллагатай харьцахдаа маш тодорхой, урьдчилан харах боломжтой байдлыг хүсэн хүлээх эрхтэй. Гаалийн хууль, журам, заавар, горимууд нь нийтэд хүртээлтэй, олж мэдэхэд хялбар, хоорондоо зөрчилгүй, нэг мөр хэрэглэгддэг байвал зохино. Аливаа асуудлыг эрх мэдлийнхээ хүрээнд шийдэх тохиолдол, үндэслэлийг тодорхой заасан байвал зохино. Гаалийн байгууллагын түншүүд гаалийн байгууллагын шийдвэрийг давж заалдах, эсхүл хянан үзэхийг шаардах боломжтой байх нөхцлийг хангах үүднээс давж заалдах болон захиргааны журмаар хянан үзэх механизм бий болгосон байна. Түншдээ үйлчилсэн дүнгийн самбар, эсхүл үйлчилгээний стандарт бий болгон ажиллавал зохино. Түүнд түншүүд гаалийн байгууллагаас ямар түвшингийн үйлчилгээ шаардаж байгааг заасан байна.</p>	<p>Customs clients are entitled to expect a high degree of certainty and predictability in their dealings with Customs. Customs laws, regulations, procedures and administrative guidelines should be made public, be easily accessible and applied in a uniform and consistent manner. The basis upon which discretionary powers can be exercised should be clearly defined. Appeal and administrative review mechanisms should be established to provide a mechanism for clients to challenge or seek review of Customs decisions. Client service charters or performance standards should be established which set out the level of service clients can expect from Customs.</p>

4. Автоматжуулалт (Automation):	
<p>Гаалийн үйл ажиллагааг автоматжуулснаар буюу компьютержуулснаар ажлын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлж, авилга авах олон боломжийг хаах нөхцөл бүрдэнэ. Автоматжуулалт нь бас хариуцлага тооцох түвшинг нэмэгдүүлж, захиргааны шийдвэр болон албан тушаалтан эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг хожим нь хянан үзэх зорилгоор аудитын шалгалт хийх боломж олгоно. Боломжтой бол, албан тушаалтан эрх мэдлийнхээ хүрээнд зохимжгүй шийдвэр гаргах, гаалийн ажилтнууд түншүүдтэйгээ шууд нүүр тулан ажиллах, бэлэн мөнгөтэй харьцах боломжийг багасгах зорилгодоо тохируулан автоматжуулсан системийг хувирган өөрчлөх нь зүйтэй.</p>	<p>Automation or computerization of Customs functions can improve efficiency and effectiveness and remove many opportunities for corruption. Automation can also increase the level of accountability and provide an audit trail for later monitoring and review of administrative decisions and the exercise of official discretion. Where possible, automated systems should be configured in such a way as to minimize the opportunity for the inappropriate exercise of official discretion, face-to-face contact between Customs personnel and clients and the physical handling and transfer of funds.</p>
5. Өөрчлөлт, шинэчлэлт (Reform and Modernization):	
<p>Авилга ерөнхийдөө хуучирсан, үр ашиггүй арга ажиллагаатай газар, мөн түншүүд нь хахууль өгөх, шуурхай үйлчилгээний хураамж төлөх замаар удаан, яршигтай ажиллагаанаас зайлсхийх сонирхолтой байгаа тохиолдолд тохиолддог. Гаалийн байгууллагууд, албан шаардлагаар далимдуулан аливаа давуу тал олж авах явдлыг арилгах зорилгоор, өөрсдийн автоматжуулсан систем, үйл ажиллагааны горимоо өөрчлөн шинэчлэх шаардлагатай. Тийм өөрчлөлт, шинэчлэлт хийх санаачилга нь өргөн хүрээтэй байж, гаалийн үйл ажиллагааны бүх талыг хамарсан байх ёстой. Ийм санаачилгыг хэрэгжүүлэх тулгуур баримт бичиг нь Киотогийн шинэчлэгдсэн Конвенц болно.</p>	<p>Corruption typically occurs in situations where outdated and inefficient practices are employed and where clients have an incentive to attempt to avoid slow or burdensome procedures by offering bribes and paying facilitation fees. Customs administrations should reform and modernize their systems and procedures to eliminate any perceived advantages which might be obtained through circumventing official requirements. Such reform and modernization initiatives should be comprehensive in nature and focus on all aspects of Customs operations and performance. The Revised Kyoto Convention provides a sound reference point for such initiatives.</p>
6. Аудитын хяналт, мөрдөн шалгалт (Audit and Investigation):	
<p>Дотоод хяналтын программууд, дотоодын болон хөндлөнгийн (гадны байгууллагын) аудитын хяналт, мөрдөн шалгалт, байцаалт зэрэг хяналт, шалгалтын аль тохиромжтой механизмыг нэвтрүүлбэл тэр нь гаалийн байгууллагад авилга гарахаас урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих ажилд тус дөхөм болно. Эдгээр аргууд нь ариун шударга ёсыг дээд хэмжээгээр сахих явдлыг хөхүүлэн дэмжсэн эерэг стратеги болон авилгад өртсөн тохиолдлыг илрүүлж, түүнд оролцсон хүмүүсийг хүмүүжүүлэх (шийтгэх) буюу байцаахад зориулагдсан сөрөг стратеги хоёрын зохистой тэнцвэрийг хангасан байвал зохино. Гаалийн ажилтан, түншүүд болон энгийн иргэд авилга, ёс зүйгүй буюу хууль бус ажиллагааны талаар мэдээлэл өгөх явдлыг хөхүүлэн дэмжиж, хэрэв тийм мэдээлэл өгсөн бол шуурхай, нарийвчилсан мөрдлөг явуулж, мэдээллийн эх сурвалжийг нууцлан хамгаална. Хэрэв том хэмжээний буюу цогц мөрдлөг хийхийг зөвшөөрсөн, эсхүл тухайн байгууллагад авилга даамжирсан тохиолдолд бас авилгатай тэмцэх бие даасан байгууллагад хандах хэрэгтэй.</p>	<p>The prevention and control of corruption in Customs can be assisted by the implementation of a range of appropriate monitoring and control mechanisms such as internal check programmes, internal and external auditing and investigation and prosecution regimes. Such regimes should strike a reasonable balance between positive strategies to encourage high levels of integrity and repressive strategies designed to identify incidences of corruption and to discipline or prosecute those personnel involved. Customs personnel, clients and the general public should be encouraged to report corrupt, unethical or illegal activity and, when such information is provided, it should be investigated in a prompt and thorough manner and sources should be protected. Where large scale or complex investigations are warranted or in administrations where corruption is widespread, there should also be recourse to independent anti-corruption agencies.</p>

7. Ёс зүйн дүрэм (Code of Conduct):	
<p>Ариун шударга ёсыг бэхжүүлэх үр ашигтай аливаа хөтөлбөрийн үндсэн элемент бол өргөн хүрээтэй ёс зүйн дүрэм боловсруулж, хэвлүүлж, хүлээн зөвшөөрүүлэх явдал болно. Түүндээ гаалийн бүх ажилтнуудаас хүсэн хүлээж буй зан үйлийг амьдралд маш ойр дөт байдлаар, хоёрдмол санаагүйгээр тусгах нь зүйтэй. Уг дүрэмд түүнийг зөрчсөн тохиолдолд, зөрчлийн ноцтой эсэхийг харгалзан хүлээлгэх хариуцлага (шийтгэл)-ын талаар зааж, хууль буюу хуульчилсан холбогдох актаар баталгаажуулна.</p>	<p>A key element of any effective integrity programme is the development, issue and acceptance of a comprehensive code of conduct which sets out in very practical and unambiguous terms the behaviour expected of all Customs personnel. Penalties for non-compliance should be articulated in the code, calibrated to correspond to the seriousness of the violation and supported by appropriate administrative and legislative provisions.</p>
8. Хүний нөөцийн удирдлага (Human Resource Management):	
<p>Хүний нөөцийн менежментийн шалгарсан арга, хэлбэрээс нэвтрүүлэх нь гаалийн байгууллагын доторх авилгатай тэмцэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ. Гаалийн байгууллага дахь авилгыг хянаж, устгахад ашигтай болох нь нотлогдсон хүний нөөцийн менежментийн дараах туршлагауд байна:</p>	<p>The implementation of sound human resource management policies and procedures plays a major role in the fight against corruption in Customs. Human resource management practices, which have proved useful in controlling or eliminating corruption in Customs, include:</p>
<ul style="list-style-type: none"> • гаалийн ажилтан амьжиргааны даруу төвшинд амьдрах боломжтой байх явдлыг хангах үүднээс тэдэнд хангалттай цалин олгох, бусад урамшил, нөхцлөөр хангах; 	<ul style="list-style-type: none"> • providing sufficient salary, other remuneration and conditions to ensure Customs personnel are able to maintain a decent standard of living;
<ul style="list-style-type: none"> • ариун шударга ёсны өндөр стандарт хангасан, эсхүл түүнийг хангах боломжтой хүмүүсийг ажилд авч, үлдээх; 	<ul style="list-style-type: none"> • recruiting and retaining personnel who have, and are likely to maintain, high standards of integrity;
<ul style="list-style-type: none"> • боловсон хүчин шилж сонгох, албан тушаалд дэвшүүлэхдээ хөндлөнгийн нөлөө, танил тал харах явдлаас ангид байж, гавъяаг нь үнэлэх зарчимд суурилах явдлыг хангах; 	<ul style="list-style-type: none"> • ensuring staff selection and promotion procedures are free of bias and favoritism and based on the principle of merit;
<ul style="list-style-type: none"> • боловсон хүчин томилох, солилцох (тойргоор ажиллуулах), шилжүүлэх тухай шийдвэр нь гаалийн ажилтан эмзэг албан тушаалд удаан хугацаагаар томилогдон ажиллах боломжийг хаах шаардлагыг харгалзан үзсэн байх явдлыг хангах; 	<ul style="list-style-type: none"> • ensuring that decisions on the deployment, rotation and relocation of staff take account of the need to remove opportunities for Customs personnel to hold vulnerable positions for long periods of time;
<ul style="list-style-type: none"> • гаалийн ажилтныг ажилд авмагцаа, мөн ажил алба эрхлэх бүхий л хугацаанд нь зохих ёсоор сургаж, мэргэшүүлэх замаар ёс суртахуун, мэргэжлийн өндөр стандарт олгох явдал чухал болохыг ямагт сайшаан дэмжих; мөн 	<ul style="list-style-type: none"> • providing adequate training and professional development to Customs personnel upon recruitment and throughout their careers to continually promote and reinforce the importance of maintaining high ethical and professional standards; and
<ul style="list-style-type: none"> • шилдэг (тэргүүн) туршлагыг дэмжих, боловсон хүчин, мэргэжлийн ариун шударга ёсны өндөр түвшинг хангах чадалтай, ажлын үр дүн тооцох болон менежмент хийх зохистой систем нэвтрүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • implementing appropriate performance appraisal and management systems which reinforce sound practices and which foster high levels of personal and professional integrity.

9. Ёс суртахуун ба байгууллагын соёл (Morale and Organizational Culture):	
<p>Ёс суртахуун буюу 'esprit de corps' доогуур түвшинд байгаа байгууллагад, мөн гаалийн ажилтнууд өөрийн байгууллагын нэр төрөөр бахархах сэтгэлгүй тохиолдолд авилга төрөх магадлалтай. Ёс суртахуун өндөртэй, хүний нөөцийн менежментийн шударга арга барилтай, албан тушаал ахих зохих ёсны боломжтой тохиолдолд гаалийн ажилтнууд ариун шударга ёсыг дагаж ажиллах төлөвтэй. Авилгын эсрэг компани ажилд (хөтөлбөрт) бүх шатны ажилтнуудыг хамруулан оролцуулж, байгууллага цэвэр ариун байхын төлөө хүн бүр хүлээх хариуцлагынхаа хэмжээг хүлээн зөвшөөрөх явдлыг хөхүүлэн дэмжих;</p>	<p>Corruption is most likely to occur in organizations where morale or 'esprit de corps' is low and where Customs personnel do not have pride in the reputation of their administration. Customs employees are more likely to act with integrity when morale is high, where human resource management practices are fair and where there are reasonable opportunities for career development and progression. Employees at all levels should be actively involved in the anti-corruption programme and should be encouraged to accept an appropriate level of responsibility for the integrity of the administration;</p>
10. Хувийн сектортой холбоо тогтоох (Relationship with the Private Sector):	
<p>Гаалийн байгууллагууд хувийн сектортой нээлттэй, тодорхой, үр дүнтэй харилцаа холбоо тогтоон ажиллах явдлыг дэмжинэ. Түншүүд аливаа асуудал сөхөж тавих, түүнийг шийдэх практик алхмыг олж, хэрэгжүүлэхийн төлөө зохих түвшинд хариуцлага хүлээх явдлыг хөхүүлэн дэмжих нь зүйтэй. Үүнтэй уялдан, гаалийн байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд Итгэлцлийн меморандум байгуулан ажиллавал ашигтай байж болно. Мөн мэргэжлийн зан үйлийн стандартыг тод тусгасан, хувийн секторт мөрдвөл зохих ёс зүйн дүрмийг боловсруулж ажиллавал ашигтай байна. Түншүүд хөнгөлөлттэй үйлчилгээ хүсч хахууль өгөхөөс, эсхүл шуурхай үйлчилгээний төлбөр төлөхөөс зайлсхийх явдлыг хангах үүднээс авилгад холбогдогсдод хүлээлгэх ял шийтгэлийг хангалттай хэмжээнд тогтоосон байх ёстой.</p>	<p>Customs administrations should foster an open, transparent and productive relationship with the private sector. Client groups should be encouraged to accept an appropriate level of responsibility and accountability for the problem and the identification and implementation of practical solutions. The establishment of Memoranda of Understanding between Customs and industry bodies can be useful in this regard. Likewise, the development of codes of conduct for the private sector, which clearly set out standards of professional behaviour, can be useful. Penalties associated with engaging in corrupt behaviour must be sufficient to deter client groups from paying bribes or facilitation fees to obtain preferential treatment.</p>
<p>Бид, ГХАЗ-ийн гишүүн орнууд, дээр дурдсан үндсэн зарчмуудад тулгуурлан, ариун шударга үйл ажиллагааны бүх талыг хамарсан, тогтвортой төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхийг гаалийн байгууллагуудад, мөн ийнхүү авилгын эсрэг тэмцэхэд гаалийн байгууллагад туслалцаа үзүүлэхийг Засгийн газрууд, хувийн сектор, олон улсын хамтын нийгэмлэгт уриалж байна.</p>	<p>We, the Members of the Customs Co-operation Council, call upon Customs administrations to implement comprehensive and sustainable integrity action plans based on the key principles outlined above and on Governments, the business sector and members of the international community to support Customs in its fight against corruption.</p>



9. Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх тухай багц стандарт (Аюулгүй байдлын багц стандарт)

1.а. Гэрээний нэр англиар:	The WCO Framework of Standards to Secure and Facilitate Global Trade (the SAFE Framework of Standards)
1.б. Гэрээний нэр оросоор:	Система рамочных стандартов по обеспечению безопасности и содействию глобальной торговле
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	2005-06-24. Бельги Улсын Брюссель хот (Brussels, Belgium)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	-
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	-
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	-
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	-
7. 7.Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	-
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	-
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - 2007, 2012, 2015, 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан.	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэхүү Аюулгүй байдлын багц стандарт (SAFE Framework of Standards) анх ДГБ-ын 2005 онд чуулсан 105/106 дугаар чуулганаар батлагдсан.

Аюулгүй байдлын багц стандартын 2007 оны хувилбарт гаалийн байгууллагаас Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (Эдийн засгийн итгэмжлэгдсэн оператор - Authorized Economic Operators)-ийн эрх олгох нөхцөл, шаардлагын тухай дэлгэрэнгүй заалтууд тусгагдсан юм (Аюулгүй байдлын багц стандартын хавсралт IV-ийг үз). Энэ асуудлыг анх тусад нь өөр баримт бичиг байдлаар боловсруулж ирсэн юм. Гэвч Аюулгүй байдлын тухай болон Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тухай бүх заалт нэг бичиг баримтад хамтдаа байвал гаалийн байгууллага болоод түүний бизнесийн хамтрагч (түнш) нарын аль алинд нь ашигтай байна гэж үзсэн учир ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Үүнтэй холбогдуулан дурдахад, хэд хэдэн улсын гаалийн байгууллагууд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөр (AEO Programs) боловсруулан (2017 оны байдлаар 77 улсад тийм хөтөлбөр хэрэгжүүлж байна), ИААН-ийн хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (Mutual Recognition Arrangements/

Agreements - MRAs) байгуулан ажиллаж байна. 2017 оны байдлаар ИААН-ийг хоёр талын хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх 51 хэлэлцээр байгуулагдсан байна. Ойрын хугацаанд тийм 39 хэлэлцээр, мөн дараах бүлэглэлийн хүрээнд хязгаарлагдмал талт 5 хэлэлцээр (a plurilateral arrangements/agreements) байгуулагдах шатандаа явж байна:

1. Номхон далайн холбоо (Pacific Alliance: Mexico, Chile, Colombia and Peru);
2. Төв Европын ЧХХ (CEFTA: Poland, Hungary, Slovakia, Albania, Bosnia and Herzegovina, Bulgaria, Croatia, Czech Republic, Macedonia, Moldova, Montenegro, Romania, Serbia, Slovenia and UN Interim Administration Mission in Kosovo);
3. Андын нурууны орнуудын хамтын нийгэмлэг (Andean Community: Bolivia, Colombia, Ecuador and Peru);
4. Их түмэн санаачилга (GTI: China, Korea, Mongolia and Russia);
5. Агадирын хэлэлцээрийн гишүүн орнууд (Agadir Agreement Member States: Tunisia, Egypt, Morocco and Jordan).

ДГБ нь 2010 оны 6 дугаар сард Аюулгүй байдлын багц стандартыг хэрэгжүүлэхэд тус дэм

болох үүднээс ДГБ-аас боловсруулсан бүх баримт бичиг, зааврыг нэгтгэн Аюулгүй байдлын баримт бичгийн багц (SAFE Package) хэмээх эмхэтгэл гаргасан байна. Энэ багц баримт бичгийн хүрээнд, түүний дотор энэхүү багц стандартын хүрээнд бас гаалийн хяналтыг харилцан хүлээн зөвшөөрөх (mutual recognition of customs controls) асуудал ч яригддаг.

Аюулгүй байдлын багц стандартын 2012 оны 6 дугаар сарын хувилбарт Харилцан зохицсон хилийн менежмент (Coordinated Border Management) болон Худалдааны үйл ажиллагааг үргэлжлүүлэх болон сэргээх арга хэмжээ (Trade Continuity and Resumption)-ний тухай 5, 6 дахь хэсэг нэмэгдсэн билээ. Бас “өндөр эрсдэлтэй ачаа” зэрэг нэр томъёог тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолт бүхий Хавсралт I-ийг оруулж өгсөн байдаг. “Худалдааны үйл ажиллагааг сэргээх заавар” (The WCO Trade Recovery Guidelines)-ыг дээр дурдсан Аюулгүй байдлын баримт бичгийн багц (SAFE Package)-д оруулсан байгаа. Техникийн чанартай нарийвчилсан зааврыг “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн болзол, шаардлага, ашиг тус” гэсэн хавсралтын “ИААН-ийн хямралын менежмент ба онцгой хэрэг явдлын үед учирсан хохирлыг арилгах” (Crisis Management and Incident Recovery of the AEO requirements) гэсэн L хэсгээс үзэж болно. Аюулгүй байдлын багц стандартын 2015 оны хувилбараар 3 дахь тулгуур багана нэмэгдсэн. Энэ хувилбар нь 2018 онд монгол хэлээр хэвлэгдсэн бөгөөд тэр нь дараах зорилго, зарчим, бүтэцтэй болно:

1. Аюулгүй байдлын багц стандартын зорилго болон зарчим

Аюулгүй байдлын багц стандарт нь дараах зорилготой:

- Бараа нийлүүлэх сүлжээг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх асуудлыг дэлхийн түвшинд хангах стандарт тогтоох.
- Бараа нийлүүлэх сүлжээний цогц бөгөөд уялдуулсан удирлагыг тээврийн бүх төрлийн хувьд боломжтой болгох.
- 21 дүгээр зууны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх болон боломжуудыг ашиглахын тулд гаалийн байгууллагуудын үүрэг роль, гүйцэтгэх үүрэг болон чадавхийг өндөржүүлэх.
- Өндөр эрсдэл бүхий ачилтыг илрүүлэх гаалийн байгууллагуудын чадварыг дээшлүүлэх зорилгоор гаалийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- Гаалийн байгууллага болон олон улсын худалдаа, түүний аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцогч төрийн бусад агентлаг хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

- Гааль/Бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- Олон улсын худалдааны бараа нийлүүлэх аюулгүй сүлжээг ашиглан барааны тасралтгүй хөдөлгөөнийг хөхүүлэн дэмжих.

2. Аюулгүй байдлын багц стандартын дөрвөн үндсэн элемент

Аюулгүй байдлын багц стандарт нь дараах 4 үндсэн элементээс бүрдэж байгаа:

- нэгдүгээрт, энэхүү багц стандарт нь гаргах, оруулах, мөн дамжуулан өнгөрүүлэх ачааны мэдээллийг цахимаар урьдчилан гаргаж өгөх шаардлагыг уялдуулж байгаа.
- хоёрдугаарт, энэхүү багц стандартыг хэрэгжүүлэх үйлсэд нэгдэн орсон улс орон бүр аюулгүй байдалд нүүрлэсэн аюул заналтай тэмцэх зорилгоор эрсдэлийн удирдлагын зохих арга ажиллагааг нэвтрүүлэх үүрэг хүлээж байгаа.
- гуравдугаарт, энэхүү багц стандарт нь илгээгч улсын гаалийн байгууллага хүлээн авагч улсаас ирүүлсэн бөгөөд эрсдэлийн онолгооны өөрийнхтэй нь дүйцэхүйц арга зүйг үндэслэн тавьсан ухаалаг хүсэлтийн дагуу өндөр эрсдэлтэй бараа болон/эсхүл тээврийн хэрэгслийг том оврын рентген аппарат болон цацраг илрүүлэгч төхөөрөмж зэрэг барааг (чингэлгийг) задлалгүй шалгах тоног төхөөрөмж ашиглан, өөрийн нутаг дэвсгэрээс гарахаас нь өмнө шалгахыг шаардаж байгаа.
- дөрөвдүгээрт, энэхүү багц стандартад бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын наад захын стандартыг хангасан бөгөөд тэргүүн (шилдэг) туршлага бүхий аж ахуйн нэгжүүдэд гаалийн байгууллагаас үзүүлэх хөнгөлөлтүүд (ашиг тус) тусгагдсан байгаа.

3. Аюулгүй байдлын багц стандартын тулгуур гурван багана

Аюулгүй байдлын багц стандарт нь өмнө тодорхойлсон 4 үндсэн элементэд суурилан, “Гаалийн байгууллага хоорондын холбоо сүлжээ” (Customs-to-Customs network arrangements), “Гааль-Бизнесийн түншлэл” (Customs-to-Business partnerships), “Гаалийн байгууллага болон төрийн бусад байгууллага (агентлаг) хоорондын хамтын ажиллагаа” (Customs-to-other Government Agencies co-operation) гэсэн тулгуур 3 багана дээр тогтоно. Гурван тулгуурт бүтэц (стратегийн) нь олон давуу талтай. Тулгуур баганууд нь ойлгоход хялбар байх бөгөөд олон улсын хэмжээнд цаг алдалгүй мөрдөх баталгаа болгон нэгтгэсэн багц стандарт заалтуудтай байгаа. Түүнээс гадна, энэхүү баримт бичиг нь ДГБ-ын гишүүн байгууллагуудаас

боловсруулан гаргасан бөгөөд өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж буй ДГБ-ын аюулгүй байдлыг хангах болон худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ, хөтөлбөрүүдээс шууд урган гарсан юм.

4. Аюулгүй байдлын багц стандарт (нийт 28 стандарт байна)

ТУЛГУУР БАГАНА 1: “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ХОЛБОО СҮЛЖЭЭ”

(Customs-to-Customs network arrangements) - Нийт 11 стандарттай:

Стандарт 1. Бараа нийлүүлэх сүлжээний цогц менежмент (Integrated Supply Chain Management)

Гаалийн байгууллага Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)-ын Бараа нийлүүлэх сүлжээний цогц менежментийн тухай Гаалийн заавар (ISCM Guidelines)-г заасан гаалийн хяналтын цогц ажиллагааг дагаж мөрдөнө.

Стандарт 2. Ачаа, бараа шалгах эрх (Cargo Inspection Authority)

Гаалийн байгууллага өөрийн улсын нутаг дэвсгэрээс гаралтай, түүнчлэн түүнээс гарах, түүгээр дамжин өнгөрөх, өөрийн улсын нутаг дэвсгэрт шилжүүлэн ачих ачаа, барааг шалгах эрхтэй байна.

Стандарт 3. Хяналт шалгалтын орчин үеийн технологи бүхий төхөөрөмж (Modern Technology in Inspection Equipment)

Барааг задлалгүй шалгах болон цацраг идэвхт бодис илрүүлэгч төхөөрөмжтэй байж, шаардлагатай тохиолдолд, мөн эрсдэлийн тооцоог үндэслэн хяналт шалгалт хийхэд ашиглавал зохино. Ийм төхөөрөмж нь хууль ёсны худалдаанд саад учруулалгүйгээр, өндөр эрсдэлтэй ачаа болон/эсхүл тээврийн хэрэгслийг шуурхай шалгахад шаардлагатай.

Стандарт 4. Эрсдэлийн удирдлагын системүүд (Risk-Management Systems)

Гаалийн байгууллага өндөр эрсдэлтэй ачаа болон/эсхүл тээврийн хэрэгслийг илрүүлэх эрсдэлийн удирдлагын систем нэвтрүүлж, автоматжуулна. Менежментийн уг системд аюул заналын тооцоо болон онилгооны шийдвэрүүдийг баталгаажуулах, мөн тэргүүн (шилдэг) туршлага хэрэгжүүлэх механизм багтсан байна.

Стандарт 5. Сонголт (шигшэлт), тодорхойлолт (түүх), онилолт (Selectivity, profiling and targeting)

Гаалийн байгууллага өндөр эрсдэлтэй байх магадлалтай ачааг ялган таних болон онилох нарийн арга ашиглавал зохино. Үүнд дараах зүйлс багтана, гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй: аль нэг улсад илгээх, эсхүл тэндээс ирэх ачаа тээврийн талаарх мэдээллийг гарахаас нь өмнө, эсхүл ирэхээс нь өмнө цахимаар урьдчилан дамжуулах; стратегийн ач холбогдолтой барааны талаар

мэдээлэл боловсруулах; худалдааны мэдээллийг автоматаар боловсруулах; хэвийн бус үйлдэлд дүн шинжилгээ хийх; мөн худалдаа эрхлэгчийн бараа нийлүүлэх сүлжээг харьцангуй байдлаар аюулгүй байлгах. Жишээлбэл, Гаалийн байгууллага болон бизнесийн байгууллага хоорондын түншлэл гэсэн тулгуур баганад дурдсанаар аюулгүй байдлыг гарал үүслийн цэгээс нь гэрчлэн баталгаажуулснаар холбогдох эрсдэл багасч, улмаар онилгоонд өртөх хувь нь буурна.

Стандарт 6. Мэдээллийг цахим хэлбэрээр урьдчилан шаардах (Advance Electronic Information)

Гаалийн байгууллага зохих ёсны эрсдэлийн тооцоо хийх үүднээс мэдээллийг хугацаанд нь цахим хэлбэрээр урьдчилан гаргаж өгөхийг шаардана.

Стандарт 7. Бараа онилох ба мэдээлэл дамжуулах (Targeting and Communication)

Гаалийн байгууллагууд эрсдэлтэй ачаа, барааг хамтарч онилох болон хамтарч скрининг хийх талаар, онилгооны стандартчилагдсан шалгуур үзүүлэлт ашиглах талаар, мөн мэдээлэл дамжуулах болон/эсхүл солилцоход тохиромжтой механизмын талаар дүрэм журамдаа заасан байна: эдгээр элемент нь ирээдүйд хяналт шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх систем бий болгон, хөгжүүлэхэд тус дөхөм болно.

Стандарт 8. Гүйцэтгэлийн хэмжилт (Performance Measures)

Гаалийн байгууллага гүйцэтгэлийн хэмжилтийг тусгасан статистик бүртгэлтэй байвал зохино. Уг хэмжилт нь дараах зүйлсийг багтаах бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: хянан үзсэн ачилтын тоо, өндөр эрсдэлтэйд тооцсон ачилтын тоо, өндөр эрсдэлтэй ачилтын хэдийг нь шалгасан, өндөр эрсдэлтэй ачилтын хэдийг нь задлалгүй шалгах технологиор шалгасан, өндөр эрсдэлтэй ачилтын хэдийг нь задлалгүй шалгах төхөөрөмжөөр болон биет байдлаар шалгасан, өндөр эрсдэлтэй ачилтын хэдийг нь зөвхөн биет байдлаар шалгасан, гаалийн бүрдүүлэлтэд хэчнээн хугацаа зарцуулсан, мөн ажлын эерэг, сөрөг үр дүн. Ийм бүртгэлийг ДГБ дээр нэгтгэвэл зохино.

Стандарт 9. Аюулгүй байдлыг тооцох (Security Assessments)

Гаалийн байгууллага бараа нийлүүлэх олон улсын сүлжээн дэх барааны хөдөлгөөн зэрэг зүйлийн аюулгүй байдлыг тооцох, ажлын хийдлийг шуурхай арилгах үүрэг амлалт авах үүднээс эрх бүхий бусад албадтай хамтран ажиллавал зохино.

Стандарт 10. Ажилтны ёс зүй (Employee Integrity)

Гаалийн байгууллага болон эрх бүхий бусад албад ажиллагсдынхаа ёс зүйн доголдлыг

арилгах, мөн ёс зүйн зөрчлийг илрүүлж, түүнтэй тэмцэх хөтөлбөрүүдийг боломжийнхоо хэрээр бий болговол зохино.

Стандарт 11. Хилээр гарах урсгалын аюулгүй байдлыг шалгах (Outbound Security Inspections)

Гаалийн байгууллага импортлогч орноос ирүүлсэн, хүлээн авах боломжтой хүсэлтийн дагуу өндөр эрсдэлтэй ачаа болон/эсхүл тээврийн хэрэгслийн хилээр гарах урсгалын аюулгүй байдлыг шалгавал зохино.

ТУЛГУУР БАГАНА 2: “ГААЛЬ-БИЗНЕСИЙН ТҮНШЛЭЛ”

(Customs-to-Business partnerships) - Нийт 6 стандарттай:

Стандарт 1. Түншлэл (Partnership)

Бараа нийлүүлэх олон улсын сүлжээнд оролцогч итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд (эдийн засгийн итгэмжлэгдсэн операторууд) ачаа хүрэх газрын гаалийн хяналтаас чөлөөлөгдөх хүртэл тэдний бараа нийлүүлэх сүлжээ эрсдэлд өртөхөөс хамгаалсан зохих ёсны арга хэмжээг өөрсдийн дотоод бодлого, дүрэм журамдаа тусгах үүднээс аюулгүй байдлын талаар өмнө нь тодорхойлогдсон стандарт болон шилдэг туршлагатай харьцуулалт хийж, өөрөө өөрийгөө үнэлдэг ажиллагаанд шилжин орно.

Стандарт 2. Аюулгүй байдал (Security)

Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд өмнө нь тодорхойлсон аюулгүй байдлын шилдэг туршлагаас өөрсдийн бизнесийн өнөөгийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

Стандарт 3. Итгэмжлэл олгох (Authorization)

Гаалийн байгууллага, худалдаа эрхлэгчдийн төлөөлөлтэй хамтран, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн статус (эрх) олгох замаар бизнес эрхлэгчдэд түлхэц үзүүлэх (урам хайрлах) зорилго бүхий баталгаажуулалтын процесс, эсхүл чанарыг магадлан итгэмжлэх журам боловсруулна. Эдгээр

процесс нь тэднээс аюулгүй байдлын систем болон практик ажиллагаагаа сайжруулахад оруулсан хөрөнгө оруулалтын ашиг тус тэдэнд мэдрэгдэж байхаар байна. Үүнд эрсдэлийн онилгоо тооцох болон хяналт шалгалт хийх хувь багассан байх, мөн тэдний бараанд шуурхай бүрдүүлэлт хийдэг болсон байх явдал хамаарна.

Стандарт 4. Технологи (Technology)

Бүх талууд орчин үеийн технологи ашиглах явдлыг хөнгөвлөх замаар ачаа, чингэлгийн халдашгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авна.

Стандарт 5. Харилцаа, холбоо (Communication)

Гаалийн байгууллага аюулгүй байдлын наад захын стандарт, бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлын шилдэг туршлагыг хөхүүлэн дэмжих үүднээс гааль, бизнесийн түншлэлийн хөтөлбөрүүдийг тогтмол шинэчилж ажиллана.

Стандарт 6. Хөнгөвчлөх (Facilitation)

Гаалийн байгууллага өөрийн гаалийн нутаг дэвсгэрээс гаралтай болон түүгээр дамжин өнгөрч байгаа бараа нийлүүлэх олон улсын сүлжээний аюулгүй, хөнгөн шуурхай байдлыг дээд шатанд хүргэх үүднээс итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

ТУЛГУУР БАГАНА 3: “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГА (АГЕНТЛАГ) ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА”

(Customs-to-other Government Agencies co-operation) гэсэн тулгуур - Нийт 11 стандарттай:

Стандарт 1. Харилцан хамтран ажиллах (Mutual Cooperation)

Засгийн газрууд тэдний гаалийн байгууллага болон эрх бүхий төрийн бусад агентлагууд хоорондоо харилцан хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжвэл зохино.

Стандарт 2. Хамтран ажиллах арга хэмжээ (хэлэлцээр)/дүрэм журам (Cooperative Arrangements/Procedures)

Засгийн газрууд олон улсын худалдаа, түүний аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцдог өөрсдийн агентлагууд дунд мөрдөх хамтын

ажиллагааны арга хэмжээ (хэлэлцээр) буюу дүрэм журам боловсруулж, боловсронгуй болгож байвал зохино.

Стандарт 3. Аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг ижилсүүлэх (Alignment of security programmes)

Засгийн газрууд олон улсын бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлыг хангах янз бүрийн хөтөлбөрүүд/дэглэмүүдийн шаардлагуудыг хэрэв боломжтой бол хооронд нь нийцүүлэн ажиллавал зохино.

Стандарт 4. Үндэсний хяналтын арга хэмжээнүүдийг уялдуулах (Harmonization of national control measures)

Засгийн газрууд бараа нийлүүлэх сүлжээнд төрийн агентлагуудаас үндэсний хэмжээнд хяналт тавих арга хэмжээнүүд, түүний дотор эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг тэдгээрээс хууль ёсны худалдаа болон олон улсын хөдөлгөөнд нөлөөлөх сөрөг үр дагаврыг нь хязгаарлахын тулд уялдуулан ажиллавал зохино.

Стандарт 5. Худалдааны үйл ажиллагааг үргэлжлүүлэх болон сэргээх арга хэмжээ боловсруулах (Development of continuity and resumptions measures)

Гаалийн байгууллага хэрэв худалдааны үйл ажиллагаа тасалдсан бол түүнийг үргэлжлүүлэн явуулах үүднээс худалдааны үйл ажиллагааг үргэлжлүүлэх болон сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус тусын гүйцэтгэх үүрэг роль, хүлээх хариуцлагыг тодорхой болгох зорилгоор төрийн бусад агентлагуудтай, мөн хувийн сектортой хамтран ажиллавал зохино.

Стандарт 6. Харилцан хамтран ажиллах (Mutual Cooperation)

Засгийн газрууд гаалийн байгууллага болон бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хил дамнуулан, эсхүл аливаа нэг Гаалийн холбооны хүрээнд хангахад оролцож буй эрх бүхий төрийн бусад агентлагууд хоорондоо харилцан хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжвэл зохино.

Стандарт 7. Хамтран ажиллах арга хэмжээ (хэлэлцээр) буюу протокол боловсруулах (Development of Cooperative Arrangements or Protocols)

Засгийн газрууд дундын хилийн хоёр талд, эсхүл аливаа нэг Гаалийн холбооны хүрээнд ажиллаж буй өөрсдийн агентлагууд дунд мөрдөх хамтын ажиллагааны арга хэмжээ (хэлэлцээр) буюу протокол боловсруулан ажиллавал зохино.

Стандарт 8. Аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг уялдуулах (Harmonization of security programmes)

Засгийн газрууд бараа нийлүүлэх олон улсын сүлжээний аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлын төрөл бүрийн хөтөлбөрийн шаардлагуудыг хэрэв боломжтой бол уялдуулан ажиллавал зохино.

Стандарт 9. Хил дамнасан хяналтын арга хэмжээнүүдийг уялдуулах (Harmonization of cross-border control measures)

Засгийн газрууд хил дамнасан хяналтын арга хэмжээнүүдийг уялдуулахын төлөө ажиллавал зохино.

Стандарт 10. Харилцан хамтран ажиллах механизм тогтоох (Establishment of Mutual Cooperation)

Засгийн газрууд хамтдаа, бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцож буй олон улсын байгууллагууд хоорондын болон тэдгээрийн дундын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжвэл зохино.

Стандарт 11. Хамтран ажиллах арга хэмжээ (хэлэлцээр) буюу протокол боловсруулах (Development of cooperative arrangements or protocols)

Дэлхийн гаалийн байгууллага нь өөрийн Гишүүдийн нэрийн өмнөөс, бараа нийлүүлэх сүлжээний аюулгүй байдлыг хангах ажиллагаанд оролцож буй олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд (Тухайлбал, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага, Олон улсын далайн тээврийн байгууллага, Дэлхийн шуудангийн холбоо)-тай хамтран ажиллах арга хэмжээ боловсруулж, боловсронгуй болгож байвал зохино. Аюулгүй байдлын багц стандартын 2015 оны хувилбар нь дараах хавсралтуудтай байна:

- **Хавсралт I.** Тодорхойлолтууд;
- **Хавсралт II.** Мэдээллийн элементүүд (Data Elements);
- **Хавсралт III.** Агаарын ачааны ачихаас өмнөх аюулгүй байдлын мэдээлэл (pre-loading air cargo security data);
- **Хавсралт IV.** Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн болзол, шаардлага, ашиг тус (AEO Conditions, Requirements and Benefits);
- **Хавсралт V.** Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх багц стандартын тухай Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн тогтоол (Resolution of the Customs Co-operation Council on the Framework of Standards to Secure and Facilitate Global Trade) (2005 оны 6 дугаар сар).



Дэлхийн худалдааны байгууллага

The World Trade Organization

Всемирная Торговая Организация (ВТО)

(Швейцарь Улсын Женев хот, 1995)

II БҮЛЭГ

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН БАРИМТ БИЧГҮҮД

- Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийн Хавсралт 1А (худалдааны бараанд хамаарах асуудлыг зохицуулсан олон талт Хэлэлцээрийн жагсаалт)-д жагсаасан, 1994 оны Тариф, худалдааны ерөнхий Хэлэлцээртэй зэрэгцэн үйлчлэх, мөн түүний салшгүй хэсэг болох 12 үндсэн Хэлэлцээр байсан. Өнөөдөр Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр нэмэгдсэнээр тэдгээр нь 13 болсон.
- Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай Хэлэлцээр (TRIPS)-ийг IV бүлэгт оруулав.

1.а. Гэрээний нэр англиар:	The Agreement Establishing the World Trade Organization (The WTO Agreement, the Marrakesh Agreement)
1.б. Гэрээний нэр оросоор:	Марракешское Соглашение о создании Всемирной Торговой Организации
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164 (МУ - 131 дэх Гишүүн)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	- Энэ хэлэлцээрийн 1А хавсралтад Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээрийг нэмсэн.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан «Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол» (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол; - Ерөнхий сайдын захирамж -1997, №6.

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

1. Хуучин ГАТТ ба шинэ ГАТТ

Олон хүмүүс ГАТТ-ыг олон улсын байгууллага гэж андуурдаг. Тэр үед Олон улсын худалдааны байгууллага (International Trade Organization) байгуулах гэсэн оролдлого бүтээгүй тул ГАТТ гэгчийг байгуулжээ. Англиар ГАТТ (General Agreement on Tariffs and Trade) буюу монголоор ТХЕХ (Тариф, худалдааны ерөнхий Хэлэлцээр)-ийн зорилго нь худалдаанд учирч буй элдэв саад тотгорыг багасгах, худалдааг зөвхөн тарифаар

хязгаарлах, улмаар тарифаа багасгах, цаашлаад тэглэх үүргийг гишүүн орнууддаа хүлээлгэх замаар худалдааг чөлөөтэй болгох (liberalization of trade) явдал болно.

Хуучин ГАТТ (ГАТТ'47 буюу 1947 оны ТХЕХ)-ыг 1947 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Женев хотноо байгуулсан билээ. Тэр нь 1948 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Хуучин ГАТТ-ын хүрээнд худалдааны олон талт хэлэлцээ (multilateral trade negotiations)-ний дараах 8 раунд (үе шат) явагдсан болно:

Хүснэгт 12. Хуучин ГАТТ-ын хүрээнд явагдсан худалдааны олон талт хэлэлцээ

Худалдааны олон талт хэлэлцээний үе шатууд, он, англи нэр, нэрний тайлал	Хэлэлцсэн асуудал, үр дүн	Оролцсон орны тоо
1. Женевийн раунд 1947 он, Geneva (Швейцарь Улсын хот) Round	Гаваний Дүрмийг батлан, 45000 гаруй тарифын буулт хийсэн. (Havana Charter and Tariff concessions)	23
2. Аннесийн раунд 1949 он, Annecy (Франц Улсын хот) Round	5000 тарифын буулт хийсэн. (Tariff concessions)	13
3. Торквейн раунд 1951 он, Torquay (Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хот) Round	8700 тарифын буулт хийсэн. (Tariff concessions)	38
4. Женевийн раунд 1956 он, Geneva (Швейцарь Улсын хот) Round	Тодорхой тооны тарифын буулт хийсэн. (Tariff concessions)	26
5. Диллоны раунд 1960-61 он, Dillon (тэр үед АНУ-ын Гадаад хэргийн дэд сайд байсан бөгөөд уг раундыг санаачлан эхлүүлсэн - US Under-Secretary of State) Round	44000 тарифын буулт хийсэн. (Tariff concessions)	26
6. Кеннедийн раунд 1964-67 он, Kennedy (АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч) Round	Тодорхой тооны тарифын буулт хийн, демпингийн эсрэг арга хэмжээг хэлэлцсэн. Энэ үеэр шугаман тайралтын формул (Linear Reduction Formula) буюу тарифыг ижил хувиар багасгах формулыг хэрэглэсэн. (Tariff concessions and anti-dumping measures)	62

Худалдааны олон талт хэлэлцээний үе шатууд, он, англи нэр, нэрний тайлал	Хэлэлцсэн асуудал, үр дүн	Оролцсон орны тоо
<p>7. Токиогийн раунд 1973-79 он, Токио (Япон Улсын нийслэл) Round</p>	<p>Тодорхой тооны тарифын буулт хийн, тарифын бус арга хэмжээ, түүнчлэн ерөнхий Хэлэлцээрүүд хэлэлцсэн. Энэ раундын үед уялдуулан тайрах формул буюу Швейцарь формул (Harmonization Reduction Formula or Swiss Formula)-ыг хэрэглэсэн. Томъёо нь: $T_N = AT_0 / (A + T_0)$ (T_N - шинэ тариф, T_0 - хуучин тариф, A - 0.14 гэсэн тогтмол тоо). Энэ формулаар өндөр тарифыг их хувиар, бага тарифыг бага хувиар бууруулах боломж бүрдсэн. Худалдааны хэмжээ (trade volume)-г харгалзан тарифын дундаж (trade-weighted average tariff)-ыг жигнэн гаргасан. Томъёо нь: $T = (m_1 t_1 + m_2 t_2 + \dots + m_0 t_0) / M$ (Т-тарифын жигнэсэн дундаж, М-нийт импорт, m_1-тодорхой секторын импорт, t_1- тодорхой секторын бараанд ногдох тариф).</p> <p>Tariff concessions, non-tariff measures, "framework" agreements</p>	102
<p>8. Уругвайн раунд 1986-94 он, Uruguay (Уругвай Улс) Round</p> <p>Уг раунд 1986 оны 9 дүгээр сард Уругвай Улсын Punta del Este -д эхэлсэн. Дараагийн хэлэлцээнүүд Montreal, Geneva, Brussels, Washington, D.C., Токио хотуудад явагдаж, хамгийн сүүлд 1994 оны 4 дүгээр сард Marrakech - д 20 Хэлэлцээрт гарын үсэг зурагдсан.</p>	<p>Тарифын буулт, тарифын бус саад тотгор, демпингийн эсрэг арга хэмжээ, үйлчилгээний худалдаа, оюуны өмч, оёмол нэхмэл эдлэл, хөдөө аж ахуй, халуун орны бүтээгдэхүүн, байгалийн баялаг, ТХЕХ-ийн зүйл заалт, Токио раундын код, татаас, хөрөнгө оруулалтын арга хэмжээ, маргаан шийдвэрлэх механизм, гарал үүслийн дүрэм, ТХЕХ-ийн систем (ДХБ байгуулах) зэрэг асуудлыг хэлэлцсэн. Энэ үеэр тарифыг харилцан тэглэх арга (zero-for-zero approach)-ыг хэрэглэсэн.</p> <p>Tariff concessions, non-tariff barriers, anti-dumping, services, intellectual property, textiles and clothing, agriculture, tropical products, natural resource products, GATT articles, Tokyo Round codes, subsidies, investment measures, dispute settlement mechanism, rules of origin and the GATT system (creation of WTO), etc.</p>	123

Уругвайн раундын Төгсгөлийн баримт бичигт 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Марокко Улсын Марракеш хотноо гарын үсэг зурснаар хуучин ГАТТ нь уг Төгсгөлийн баримт бичгийн нэг хавсралт болсон. Марракешийн Хэлэлцээр (Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр) 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсноор ГАТТ' 47 дангаараа үйлчлэхээ больж, тухайн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бүх нэмэлт өөрчлөлтийн хамт (1947 оны ТХЕХ-ийг түр хугацаагаар мөрдөх тухай Протоколоос бусад) 1994 оны Тариф, худалдааны ерөнхий Хэлэлцээр (ГАТТ' 94)-ийн бүрдэл хэсэг болон Марракешийн Хэлэлцээрт шингэжээ.

Шинэ ГАТТ (ГАТТ' 94 буюу 1994 оны ТХЕХ) нь өөрөө Марракешийн Хэлэлцээрийн хавсралт юм (энэ талаар "Уругвайн раундын Төгсгөлийн баримт бичиг" гэсэн дараагийн гарчгийн холбогдох хавсралтаас харна уу). Шинэ ГАТТ нь хуучин ГАТТ-ын зорилгыг өвлөн, зөвхөн бараа худалдаалах асуудлаар хязгаарлагдсангүй. Шинэ ГАТТ нь үйлчилгээ, оюуны өмчийн худалдаатай холбогдсон асуудлыг гүнзгийрүүлэн зохицуулах болсон. Ийнхүү бараа, үйлчилгээ, оюуны өмчийн худалдаа нь ГАТТ-ын цөм болж байна. Марракешийн Хэлэлцээр, бараа, үйлчилгээ, оюуны өмч, маргаан шийдвэрлэх, худалдааны бодлого хянах гэсэн 6 гол асуудал хоорондоо хэрхэн зохицсоныг доорх хүснэгтээс харна уу:

Хүснэгт 13. Марракешийн Хэлэлцээр, бараа, үйлчилгээ, оюуны өмч, маргаан шийдвэрлэх, худалдааны бодлого хянах гэсэн 6 гол асуудал хоорондоо зохицсон байдал

Малгай Хэлэлцээр (Umbrella)	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (AGREEMENT ESTABLISHING WTO)		
Хамрах хүрээ	Бараа (Goods)	Үйлчилгээ (Services)	Оюуны өмч (Intellectual Property)
Үндсэн баримт бичгүүд (Basic principles)	GATT	GATS	TRIPS
Нэмэлт баримт бичгүүд (Additional details)	Бараатай холбоотой бусад Хэлэлцээр, хавсралтууд (Other goods agreements and annexes)	Үйлчилгээтэй холбоотой хавсралтууд (Services annexes)	
Зах зээлд нэвтрэх үүрэг амлалтууд (Market access commitments)	Улсуудын амлалтууд (Countries' schedules of commitments)	Улсуудын амлалтууд (Нэн тааламжтай нөхцөлд үл хамрагдах тохиолдлууд) (Countries' schedules of commitments (and MFN exemptions))	
Маргаан шийдвэрлэх баримт бичиг (Dispute settlement)	Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг (хэлэлцээр) (Understanding on Rules and Procedures Governing the Settlement of Disputes)		
Ил тод байдал (Transparency)	Худалдааны бодлого хянах механизм (TRADE POLICY REVIEWS)		


2. Уругвайн раундын Төгсгөлийн баримт бичиг (Uruguay Round Final Act)

Хүснэгт 14. Уругвайн раундын Төгсгөлийн баримт бичигт хавсрагдсан баримт бичгүүд

I.Марракешийн Хэлэлцээр (Marrakesh Agreement):	
Хавсралт 1А: Барааны худалдааны тухай олон талт Хэлэлцээрүүд (Multilateral Agreements on Trade in Goods):	
1. 1994 оны ТХЕХ. Үүнд дараах баримт бичгүүд хамаарна: (a) 1947 оны ТХЕХ-ийн заалтууд (ДХБ-ын Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хүчин төгөлдөр болсон эрх зүйн баримт бичгүүдээр шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан, хувиргасан заалтуудын хамт)	1. GATT'94. It consists of: (a) The provisions of the GATT'47 as rectified, amended or modified by the terms of legal instruments which have entered into force before the date of entry into force of the WTO Agreement
(b) ДХБ-ын Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө 1947 оны ТХЕХ-ийн дагуу хүчин төгөлдөр болсон бөгөөд дор дурдсан эрх зүйн баримт бичгүүдийн заалтууд: (i) тарифын буулттай холбогдсон протоколууд, гэрчилгээнүүд (ii) нэгдэн орох тухай протоколууд (... -ээс бусад) (iii) ДХБ-ын Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр хүчинтэй байсан бөгөөд 1947 оны ТХЕХ-ийн XXV зүйлд заасны дагуу үүргээс чөлөөлсөн шийдвэрүүд (iv) 1947 оны ТХЕХ-ийн ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДААС гаргасан бусад шийдвэрүүд	(b) The provisions of the legal instruments set forth below that have entered into force under the GATT'47 before the date of entry into force of the WTO Agreement: (i) protocols and certifications relating to tariff concessions (ii) protocols of accession (excluding ...) (iii) decisions on waivers granted under Article XXV of GATT'47 and still in force on the date of entry into force of the WTO Agreement (iv) other decisions of the CONTRACTING PARTIES to GATT'47

(c) Дор дурдсан харилцан ойлголцох баримт бичгүүд: (i) 1994 оны ТХЕХ-ийн II:I(b) заалтыг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг (ii) 1994 оны ТХЕХ-ийн XVII зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг (iii) 1994 оны ТХЕХ-ийн төлбөрийн тэнцэлтэй холбогдох заалтын тухай харилцан ойлголцох баримт бичиг (iv) 1994 оны ТХЕХ-ийн XXIV зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг (v) 1994 оны ТХЕХ-ийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөх тухай харилцан ойлголцох баримт бичиг (vi) 1994 оны ТХЕХ-ийн XXVIII зүйлийг тайлбарлах тухай харилцан ойлголцох баримт бичиг	(c) Understandings set forth below: (i) Understanding on the Interpretation of Article II:I(b) of the GATT'94 (ii) Understanding on the Interpretation of Article XVII of the GATT'94 (iii) Understanding on Balance-of-Payment Provisions of the GATT'94 (iv) Understanding on the Interpretation of Article XXIV of the GATT'94 (v) Understanding in Respect of Waivers of Obligations under the GATT'94 (vi) Understanding on the Interpretation of Article XXVIII of the GATT'94
(d) 1994 оны ТХЕХ-ийн тухай Марракешийн протокол	(d) Marrakesh Protocol to the GATT'94
2. Хөдөө аж ахуйн Хэлэлцээр	2. Agreement on Agriculture
3. Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн (Амьтан, ургамлын хорио цээрийн) арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр	3. Agreement on the Application of Sanitary and Phytosanitary Measures (SPS Agreement)
4. Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай Хэлэлцээр	4. Agreement on Textiles and Clothing
5. Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай Хэлэлцээр	5. Agreement on Technical Barriers to Trade (TBT Agreement)
6. Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай Хэлэлцээр	6. Agreement on Trade-Related Investment Measures
7. 1994 оны ТХЕХ-ийн VI зүйл (Демпингийн эсрэг арга хэмжээ)- ийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр	7. Agreement on Implementation of Article VI of the GATT'94 (Anti-Dumping Agreement)
8. 1994 оны ТХЕХ-ийн VII зүйл (Гаалийн үнэлгээ)-ийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр	8. Agreement on Implementation of Article VII of the GATT'94 (The GATT Valuation Code)
9. Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр	9. Agreement on Preshipment Inspection
10. Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр	10. Agreement on Rules of Origin
11. Импортын лицензийн журмын тухай Хэлэлцээр	11. Agreement on Import Licensing Procedures
12. Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр	12. Agreement on Subsidies and Countervailing Measures
13. Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээр	13. Agreement on Safeguards
14. Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр	14. Agreement on Trade Facilitation
Хавсралт 1B: Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий Хэлэлцээр - ГАТС (General Agreement on Trade in Services - GATS)	
Хавсралт 1C: Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай Хэлэлцээр - ТРИПС-ийн Хэлэлцээр (Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights - TRIPs Agreement)	
Хавсралт 2: Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг (Understanding on Rules and Procedures Governing the Settlement of Disputes)	
Хавсралт 3: Худалдааны бодлого хянах механизм (Trade Policy Review Mechanism)	
Хавсралт 4: Хязгаарлагдмал оролцогчидтой худалдааны Хэлэлцээрүүд (Plurilateral Trade Agreements)	
1. Иргэний нисэх онгоцны тухай Хэлэлцээр	1. Agreement on Trade in Civil Aircraft
2. Засгийн газрын худалдан авалтын тухай Хэлэлцээр	2. Agreement on Government Procurement
3. Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын Хэлэлцээр (1997 оны эцсээр дуусгавар болсон)	3. International Dairy Agreement (Terminated at the end of 1997)
4. Үхрийн махны тухай олон улсын Хэлэлцээр (1997 оны эцсээр дуусгавар болсон)	4. International Bovine Meat Agreement (Terminated at the end of 1997)

II. Сайд нарын бага хурлын шийдвэр, тунхаглалууд (Ministerial Decisions and Declarations)	
<p>- Худалдааны хэлэлцээний хорооноос 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан сайд нарын шийдвэр, тунхаглалууд:</p> <ul style="list-style-type: none"> (a) Буурай хөгжилтэй орнуудын эрх ашгийг хамгаалах арга хэмжээний талаарх шийдвэрүүд (b) Глобал эдийн засгийн бодлого боловсруулах илүү зохицолдоо бүрдүүлэхэд ДХБ-ын оруулах хувь нэмрийн тухай тунхаглал (c) Мэдэгдэх журмын тухай шийдвэр (d) ДХБ, ОУВС-гийн харилцаа холбооны тухай тунхаглал (e) Буурай хөгжилтэй болон Хүнсний импорт давамгайлсан хөгжиж буй орнуудад зориулсан Өөрчлөлтийн хөтөлбөрийн болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний тухай шийдвэр (f) Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай Хэлэлцээрийн 2.6 зүйлийн дагуу анхны интеграцийг мэдэгдэх тухай шийдвэр (g) Худалдаан дахь техникийн саад тоггорын тухай Хэлэлцээртэй холбогдсон шийдвэрүүд (2 шийдвэр) (h) 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээрт холбогдох шийдвэрүүд, тунхаглал (2 шийдвэр, 1 тунхаглал) (i) 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээрт холбогдох шийдвэрүүд <ul style="list-style-type: none"> (i) Гаалийн байгууллага мэдүүлсэн үнийн үнэн, зөвд эргэлзэх шалтгаантай байх тохиолдлын тухай шийдвэр (ii) Доод үнийн тухай, мөн онцгой эрхт төлөөлөгч, борлуулагч, концессионерын импортолсон барааны үнийн тухай шийдвэр (j) Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий Хэлэлцээрт холбогдох шийдвэрүүд, тунхаглал (8 шийдвэр) (k) Засгийн газрын худалдан авалтын тухай Хэлэлцээрт нэгдэн орох тухай шийдвэр (l) Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийг мөрдөх, хянан үзэх тухай шийдвэр <p>- Марракеш хотноо Худалдааны хэлэлцээний хорооны хуралдааны үеэр 1994 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр сайд нарын баталсан шийдвэрүүд:</p> <ul style="list-style-type: none"> (a) ДХБ-ын Хэлэлцээрийг батлах, нэгдэн орох тухай шийдвэр (b) Худалдаа, байгаль орчны тухай шийдвэр (c) ДХБ-ын Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарах зохион байгуулалтын болон санхүүгийн үр дагаврын тухай шийдвэр (d) ДХБ байгуулах Бэлтгэл хороо байгуулах тухай шийдвэр 	<p>- Ministerial Decisions and Declarations adopted by the Trade Negotiations Committee on 15 December 1993:</p> <ul style="list-style-type: none"> (a) Decisions on Measures in Favour of Least-Developed Countries (b) Declaration on the Contribution of the WTO to Achieving Greater Coherence in Global Economic Policymaking (c) Decision on Notification Procedures (d) Declaration on the Relationship of the WTO with the IMF (e) Decision on Measures Concerning the Possible Negative Effects of the Reform Programme on Least-Developed and Net Food-Importing Developing Countries (f) Decision on Notification of First Integration under Article 2.6 of the Agreement on Textiles and Clothing (g) Decisions Relating to the Agreement on Technical Barriers to Trade (2 decisions) (h) Decisions and Declaration Relating to the Agreement on Implementation of Article VI of the GATT'94 (2 decisions and 1 Declaration) (i) Decisions Relating to the Agreement on Implementation of Article VII of the GATT'94 <ul style="list-style-type: none"> (i) Decision Regarding Cases where Customs Administrations Have Reasons to Doubt the Truth or Accuracy of the Declared Value (ii) Decision on Texts Relating to Minimum Values and Imports by Sole Agents, Sole Distributors and Sole Concessionaires (j) Decisions and Declaration Relating to the General Agreement on Trade in Services (8 decisions) (k) Decision on Accession to the Agreement on Government Procurement (l) Decision on the Application and Review of the Understanding on Rules and Procedures Governing the Settlement of Disputes <p>- Ministerial Decisions adopted by Ministers at the Meeting of the Trade Negotiations Committee in Marrakesh on 14 April 1994:</p> <ul style="list-style-type: none"> (a) Decision on Acceptance of and Accession to the WTO Agreement (b) Decision on Trade and Environment (c) Decision on Organizational and Financial Consequences flowing from Implementation of the WTO Agreement (d) Decision on the Establishment of the Preparatory Committee for the WTO
<p>III. Санхүүгийн үйлчилгээний талаар хүлээх үүрэг амлалтын тухай харилцан ойлголцох баримт бичгүүд (Understanding on Commitments in Financial Services)</p>	



Зураг 8. ДХБ-ын эрх зүйн баримт бичгүүдийн ерөнхий схем

3. Дэлхийн худалдааны байгууллага

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) байгуулах тухай Хэлэлцээр 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсноор Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) байгуулагджээ.

Ийнхүү ГАТТ нь түүний хэрэгжилтэд хяналт тавих байнгын байгууллагатай болсон. Тэгэхээр ДХБ нь хэдийгээр байгуулагдаад удаагүй боловч түүний худалдааны систем (its trading system) нь хагас зуу гаруй жилийн түүхтэй юм.

ДХБ-ын зорилтууд (objectives) :

- амьдралын түвшинг дээшлүүлэх (raising standards of living);
- ажилгүйдлийг байхгүй болгох (ensuring full employment);
- бодит орлого нэмэгдэж, байнга өсөх нөхцөлийг бүрдүүлэх, бодит орлого болон үр нөлөө бүхий эрэлтийн хэмжээг байнга өсгөн нэмэгдүүлэх (ensuring a large and steadily growing volume of real income and effective demand);
- тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийг өргөжүүлэх (expanding the production of and trade in goods and services with the objective of sustainable development);
- байгаль орчныг хамгаалж, унаган төрхөөр нь хадгалан үлдээхийг эрмэлзэх, үүний тулд эдийн засгийн хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа ДХБ-ын Гишүүдийн хэрэгцээ шаардлага, эрх ашигт нийцсэн аргуудыг эрэлхийлэх (seeking to Protect and Preserve the environment and enhance the means for doing so in a manner consistent with the respective needs and concerns of WTO Members at different levels of economic development).

ДХБ-ын үндсэн чиг үүрэг (main functions):

- ДХБ-ын хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах (administering WTO Agreements);
- худалдааны хэлэлцээ явуулах талбар болох (forum for trade negotiations; it's a negotiating forum): гишүүн засгийн газрууд өөр хоорондын ахрилцаанд учирсан худалдааны асуудлыг шийдвэрлэх зорилгоор цуглардаг;
- худалдааны маргаан шийдвэрлэх (handling trade disputes; it helps to settle disputes): Худалдааны харилцаа нь ашиг сонирхлын байнгын зөрчилтэй байдаг. Бүр нарийн нягт боловсруулсан хэлэлцээрийг ч гэсэн тайлбарлах шаардлага гардаг. Тиймээс ийм маргааныг шийдвэрлэх хамгийн сайн зохистой арга нь харилцан тохиролцсон эрх зүйн баримт бичигт заасан төвийг сахисан журам (neutral procedure)-ыг үндэслэх явдал юм. Тиймээс ч Маргаан шийдвэрлэх дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг (хэлэлцээр) байгуулагдсан байгаа. Уг хэлэлцээрээр хоёр буюу хэд хэдэн улсын хооронд үүссэн худалдааны маргааныг даруй шийдэх боломжтой. Ер нь хоёр буюу хэд хэдэн улс худалдаа хийхэд маргаан гарахгүй байх нь ховор үзэгдэл юм. Зарим маргааныг тухайн улсууд өөрсдөө шийдчихдэг. Харин заримыг нь тэд өөрсдөө шийдэхэд бэрх байдаг. Тиймээс гуравдагч этгээдийн туслалцаа хэрэг болдог. Эсхүл тийм маргаан шийдэгдэлгүйгээр олон жил болдог. ГАТТ нь олон жил олон улсын худалдааны шүүхийн үүрэг гүйцэтгэж ирсэн түүхтэй (acted as the "court of international trade");
- Гишүүдийн худалдааны бодлогыг хянах (monitoring members' trade policies);
- эдийн засгийн глобал бодлого боловсруулах ажлын уялдаа холбоог хангах (coherence in global economic policy making);
- хөгжиж байгаа орнууд болон буурай хөгжилтэй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, тэдний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал болно (technical assistance and capacity building for developing countries and LDCs).

Зураг 9. ДХБ-ын зорилт, чиг үүрэг

ДХБ-ын үндсэн зарчмаас дурдвал:

1. Үл ялгаварлах (Non-Discrimination). Энэ зарчим нь 2 үндсэн бүрдэл хэсэгтэй: “үндэсний нэн тааламжтай нөхцөл” (the most-favoured nation clause/rule) болон “үндэсний нөхцөл” (the national treatment policy). Энэ 2 зарчим хоёулаа барааны худалдааны тухай, үйлчилгээний худалдааны тухай, мөн оюуны өмчийн эрхийг хамгаалах тухай ДХБ-ын дүрэмд (үйлчлэх хүрээ, мөн чанарын хувьд арай ялгаатай байдлаар) заагдсан байгаа. “Үндэсний нэн тааламжтай нөхцөл олгох” дүрмийн дагуу ДХБ-ын аль нэг Гишүүн ДХБ-ын бусад бүх Гишүүдтэй хийх бүх талын худалдаанд тэдгээр Гишүүдийг жижиг, том гэж ялгалгүй, ижил болзол нөхцөл тавихыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, ДХБ-ын аль нэг Гишүүн ДХБ-ын өөр аль нэг Гишүүний тодорхой бараанд үндэсний нэн тааламжтай нөхцөл олгосон бол тэр нь ДХБ-ын бусад бүх Гишүүдтэй хийх худалдаанд нэгэн адил хамаарна. Энэ зарчим нь буурай хөгжилтэй орнуудад болон хөгжиж буй зарим орнуудад зориулсан хөнгөлөлттэй нөхцөлүүд (preferential treatment), бүс нутгийн чөлөөлт худалдааны бүс (regional free trade areas), гаалийн холбоонд хамаарахгүй. “Үндэсний нөхцөл олгох” гэдэг нь импортын бараанд дотоодын үйлдвэрлэлийн барааны адил болзол, шаардлага тавина гэсэн үг юм. Энэ нь одоогоор тухайн импортын барааг оруулсны дараах техникийн стандарт, аюулгүй байдлын стандарт зэрэгт хамаарна. Энэ нь бас үйлчилгээ (үйлчилгээний худалдаа), дотоод, гадаадын иргэдэд хамаарна.
2. Харилцан адил байх (Reciprocity). Үүнд нэг талаас, үндэсний нэн тааламжтай нөхцөлийг зүгээр ашиглах явдлыг хязгаарлах хүсэл (a desire to limit the scope of free-riding that may arise because of the MFN rule), мөн нөгөө талаас, гадаадын зах зээлд илүү чөлөөтэй нэвтрэх боломж олж авах хүсэл (a desire to obtain better access to foreign markets) хамаарна. Худалдааг дангаараа чөлөөтэй болгох (unilateral liberalization)-оос хэлэлцээ хийх нь илүү ашиг тустай гэж үздэг. Харилцан хөнгөлөлт олгох (reciprocal concessions) нь уг ашиг тус бодитой болох (gains will materialise) нөхцөлийг бүрдүүлнэ.
3. Ил тод байх (Transparency). ДХБ-ын Гишүүд худалдааны дүрэм журмаа хэвлэн нийтлэх, худалдааны асуудлыг зохицуулсан захиргааны шийдвэрүүдийг бусад Гишүүд хянан үзэх боломжтой бүтэц бий болгох, бусад Гишүүдээс мэдээлэл хүссэн хүсэлтэд хариу өгөх, худалдааны бодлогодоо өөрчлөлт оруулсан даруй ДХБ-д мэдэгдэх шаардлагатай. Үүний зэрэгцээ Худалдааны бодлого хянах механизмаар дамжуулан ДХБ-д өөрийн орны хүрээнд авч хэрэгжүүлсэн худалдааны бодлогын арга хэмжээний талаар тогтмол хугацаанд тайлан (periodic country-specific reports) гаргаж өгнө.
4. Худалдааны болзол нөхцлүүд нь тогтвортой, урьдчилан харах боломжтой байх (stable and predictable trade conditions). ГАТТ-ын дүрмийг чанд мөрдвөл энэ зарчим хэрэгжих боломжтой. Гишүүн орнууд тарифын дээд хязгаар (тааз тариф - tariff ceiling буюу bound tariff) баримтлах үүргийг ГАТТ-ын гэрээгээр хүлээдэг. Мөн гишүүн орнууд зах зээлд нэвтрэх дүрэм журам, импортын дүрэм журам, техникийн стандарт гэм мэтийг ойр ойрхон өөрчлөхөөс зайлсхийх хэрэгтэй.
5. Аюулгүй байдлыг хамгаалах (safety values). Гишүүн засгийн газрууд тодорхой тохиолдолд худалдааг хязгаарлах боломжтой. Тэд зөвхөн байгаль орчныг хамгаалах төдийгүй бас нийтийн эрүүл мэнд, амьтан, ургамлын эрүүл мэнд, эрүүл ахуйг хамгаалах зорилгоор худалдааг хязгаарлах арга хэмжээ авч болно. Энэ чиглээр дараах 3 төрлийн зүйл заалт байдаг:
 - эдийн засгийн бус шинжтэй зорилт хэрэгжүүлэхийн тулд худалдааны арга хэмжээ ашиглахыг зөвшөөрсөн зүйл заалт (articles allowing for the use of trade measures to attain non-economic objectives);
 - “шударга өрсөлдөөн”-ийг дэмжсэн зүйл заалт (articles aimed at ensuring “fair competition”): байгаль орчныг хамгаалах нэрийн дор протекционист бодлогоо нуун далдалж болохгүй.
 - эдийн засгийн шалтгаанаар худалдаанд оролцохыг зөвшөөрсөн зүйл заалт (provisions permitting intervention in trade for economic reasons).
6. Шударгаар өрсөлдөх (Fair Competition). Дэлхийн экспортлогч орнууд шударга зарчмаар өрсөлдөнө. Хэрэв импортын бараа нь демпингийн шинжтэй (экспортлогч орны дотоодын зах зээлийн үнээс бага үнэтэй) байх, эсхүл түүнийг экспортоор гаргахад нь татаас (дэмжлэг) үзүүлсэн бол худалдааны гажуудлыг арилгах арга хэрэгсэл (trade remedies) ашиглана. ДХБ-ын Гишүүд дотоодын

үйлдвэрлэл, дотоодын зах зээлийг хамгаалах протекционист бодлогоо халхавчлах зорилгоор байгаль хамгаалах арга хэмжээг ашиглаж болохгүй. Чөлөөт худалдаа нь бас ямагт шударга худалдаа биш байдаг.

7. Дотоодын үйлдвэрлэлийг зөвхөн тарифаар хамгаалах (Tariff Protection). Тарифыг хамгийн ил тод, худалдаанд хамгийн бага хохирол учруулах арга хэрэгсэл гэж үздэг. ГАТТ-ын гол зорилго бол дотоодын үйлдвэрлэлийг зөвхөн тарифаар хамгаалдаг болгох явдал юм. Гэвч зарим орнууд зах зээлд нэвтрэх боломж олгох, түүний зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах (to strike a balance between market access and the protection of domestic industry) зорилгоор импортын бараанд тарифын квот (tariff quotas) тогтоох арга хэрэглэдэг. Тарифын квот гэдэг нь тодорхой тоо хэмжээнд хүртэлх импортын бараанд гаалийн бага хувь хэмжээ бүхий татвар (гаалийн үндсэн татвар - primary duties) ногдуулах, эсхүл тийм барааг гаалийн татвараас чөлөөлөх, харин тэрхүү тогтоосон тоо хэмжээнээс хэтэрсэн хэсэгт нь гаалийн өндөр татвар (гаалийн нэмэлт татвар - secondary duties) ногдуулах арга юм. ДХБ нь дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор тоон хязгаарлалт (quantitative restrictions) тогтоохыг зарчмын хувьд хориглодог боловч энэ зорилгоор тарифын зохицуулалт ашиглахыг зөвшөөрдөг. Бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас худалдаанд үүссэн гажуудлыг арилгах зорилгоор (хэрэв демпингийн хэмжээг тогтоосон бол) демпингийн эсрэг татвар, эсхүл (экспортын татаас/дэмжлэг нөлөөлснийг тогтоосон бол) саармагжуулах буюу нөхөн төлөөсийн татвар зэрэг залхаан цээрлүүлэх тариф (punitive tariffs) ашиглаж болно.
8. Худалдааг либеральчилах (чөлөөтэй болгох) (Trade Liberalization) - Хэлэлцээ хийх замаар худалдааг улам бүр чөлөөтэй болгох (Freer trade through negotiations). Засгийн газрууд бизнес эрхлэгчдийн эрх ашгийн төлөө зах зээлийн шинэлэг, илүү ашигтай боломжуудыг нээн, (бараа, тариф, тарифын бус арга хэмжээ, үйлчилгээ, дүрэм журмын талаар) хэлэлцээ хийх тал дээр байнгын хүчин чармайлт тавьж ажиллах нь зүйтэй гэж үздэг. Энэ нь олон талт худалдааны хэлэлцээний раундаар дамжин биеллээ олж байна. Худалдааг чөлөөтэй болгох нэг томоохон алхам нь чөлөөт бүс байгуулах явдал мөн. Өнөөдөр олон арван улс чөлөөт бүсийн хөтөлбөр боловсруулан

ажиллаж байна. Мөн Европт Европын чөлөөт худалдааны бүс, Хойд Америкт Хойд америкийн чөлөөт худалдааны бүсүүд байгуулагдан тодорхой барааны гаалийн татварыг үе шаттайгаар тэглэх асуудлыг хэрэгжүүлж байна. Гааль, эдийн засгийн холбоод нь энэ зорилгыг эрхэмлэдэг. Энэ үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь ГАТТ'47-ийн XXIV зүйл болно. Өнөөдрийн байдлаар ДХБ-д 500 орчим чөлөөт худалдааны хэлэлцээр бүртгэгдсэн байна.

9. Худалдааны маргааныг ухаалгаар шийдвэрлэх (I). Маргаан шийдвэрлэх дүрэм журам Уругвайн раундын үеэр батлагдсан.
10. Хөгжиж буй орнуудад зориулсан тусгай нөхцөл (Special Treatment for Developing Countries). Ялангуяа буурай хөгжилтэй орнуудад хөнгөлөлт үзүүлэх ёстой. Энэ дагуу хөгжингүй орнууд буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад тарифын хөнгөлөлт (преференц) үзүүлдэг. 1965 онд ТХЕХ-т оруулсан нэмэлт өөрчлөлт болох IV Хэсэг (зүйл XXXVI, XXXVII, and XXXVIII)-т "ерөнхийлөн хамааруулах" (generalized), "үл ялгаварлах" (non-discriminatory), гэхдээ "хариу нэхэхгүй байх" (non-reciprocal) гэсэн зарчим тусгагдсан байдаг. Үүнийг үндэслэн, мөн 1968 онд Шинэ Дели-д болсон НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал (UNCTAD)-ын 2 дугаар хуралдаанаар баталсан Хөнгөлөлтийн ерөнхий систем (ХЕС, Generalized System of Preferences - GSP)-ийн хүрээнд ДХБ-ын Гишүүн - өндөр хөгжилтэй улсууд дангаараа (өөрийн санаачилгаар) ДХБ-ын Гишүүн - хөгжиж буй зарим улс (үүнд Монгол Улс хамаарна)-ын, эсхүл буурай хөгжилтэй улсын гарал үүсэлтэй бараанд нэн тааламжтай тариф мөрдөхгүй байх журмыг хэрэгжүүлж иржээ. Гэхдээ энэ нь анхандаа 10 жил хүртэл хугацаатай байжээ. Харин ТХЕХ-ийн хүрээнд явагддаг худалдааны олон талт хэлэлцээний Токиогийн үе шатанд буюу 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ТХЕХ-ийн Хэлэлцэн тохирогч Талуудаас батлан гаргасан шийдвэр (Хөгжиж буй орнуудад ялгавартай бөгөөд илүү тааламжтай нөхцөл олгох, тэдний хувьд харилцан адил байх зарчим мөрдөхгүй байх, тэднийг (дэлхийн худалдаанд) аль болох өргөнөөр хамруулан оролцуулах тухай шийдвэр - Decision on Differential and More Favourable Treatment, Reciprocity and Fuller Participation of Developing Countries)-ээр дээрх хугацааг хязгааргүй болгосон байдаг. Энэхүү шийдвэрийг (ялангуяа түүний 2(a) заалтыг)

“эрх олгосон заалт” (Enabling Clause) гэдэг. Учир нь энэ шийдвэрээр ДХБ-ын Гишүүн - өндөр хөгжилтэй аливаа нэг улс хөгжиж буй зарим улс болон буурай хөгжилтэй улсын гарал үүсэлтэй бараанд ТХЕХ-ийн I зүйл (нэн тааламжтай гаалийн тариф мөрдөх)-ийг үл харгалзан импортын гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх эрх нь ТХЕХ-ийн (ДХБ-ийн) хүрээнд албан ёсоор олгогдсон юм. Энэ шийдвэр нь бас хөгжиж буй орнууд бүс нутгийн хүрээнд тарифын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ (regional arrangements among developing countries) авч хэрэгжүүлэх, түүнчлэн Худалдааны хөнгөлөлтийн глобал систем (the Global System of Trade Preferences - GSTP)-ийг хөгжүүлэх (ДХБ-ын) эрх зүйн үндэс болж байгаа бөгөөд энэ шийдвэрийг ТХЕХ-ийн нэг хэсэг гэж үздэг (applied as part of GATT 1994 under the WTO). 2015 оны байдлаар ХЕС-ийн схем нэвтрүүлсэн өндөр хөгжилтэй буюу хөгжингүй дараах 40 улс байна: Австрали, Беларусь, Канад, Европын холбоо (28 гишүүн улстай), Исланд, Япон, Казахстан, Шинэ Зеланд, Норвеги, ОХУ, Швейцарь, Турк, АНУ. Эдгээр улсын ХЕС-ийн дагуу буурай хөгжилтэй орнууд (2015 оны байдлаар 49 байна)-ын гарал үүсэлтэй бараа, мөн түүнчлэн хөгжиж буй зарим улс (энд Монгол Улс хамаарна)-ын гарал үүсэлтэй нэлээд тооны бараа нэн тааламжтай тарифаас бүрмөсөн чөлөөлөгдөх боломжтой байна (a permanent exemption to the MFN obligation). Гэхдээ ХЕС-ийн схемийн дагуу тарифын хөнгөлөлт эдэлж буй улсуудын эдийн засаг өсөн өндийж ирснээр тэдгээрийн тийнхүү тарифын хөнгөлөлт эдлэх эрх нь цуцлагдаж, тэдгээр нь ТХЕХ-т заасан үүрэг, хариуцлагаа ДХБ-ын бусад Гишүүн орнуудын нэгэн адил бүрэн хэмжээгээр үүрэх болно. Өнөөдрийн байдлаар дээр дурдсан донор орнуудаас 39 улс (Исландаас бусад) нь Монгол Улсын гарал үүсэлтэй зарим бараанд тарифын хөнгөлөлт эдлүүлж байна.

Сайд нарын бага хурал

ДХБ нь Сайд нарын бага хурлаар толгойлуулсан, засгийн газар хоорондын байгууллага юм. Сайд нарын Бага хурал нь хоёр жилд нэгээс доошгүй удаа болдог. ДХБ байгуулагдсанаас хойш Сайд нарын Бага хурал дараах хот, улсуудад 11 удаа болсон байна:

1. Сингапур (Singapore), 1996 оны 12 дугаар сарын 9-13;
2. Женев (Geneva, Switzerland), 1998 оны 5

дугаар сарын 18-20;

3. Сиэтл (Seattle, USA), 1999 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 3;
4. Доха (Doha, Qatar), 2001 оны 11 дүгээр сарын 9-14 (Энэ үеэс худалдааны олон талт хэлэлцээний 9 дүгээр раунд буюу Дохагийн раунд эхэлсэн);
5. Канкун (Cancun, Mexico), 2003 оны 9 дүгээр сарын 10-14;
6. Хонконг (BHAU), 2005 оны 12 дугаар сарын 13-18;
7. Женев (Швейцарь), 2009 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 2;
8. Женев (Швейцарь), 2011 оны 12 дугаар сарын 15-17;
9. Бали (Bali, Indonesia), 2013 оны 12 дугаар сарын 3-6 (Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр байгуулах хэлэлцээг дуусгавар болгосон);
10. Кени (Kenya, Nairobi), 2015 оны 12 дугаар сарын 15-18;
11. Буэнос Айрес (Buenos Aires, Argentina).

Буэнос Айресын Бага хурлаар хэлэлцсэн асуудлууд

Хамгийн сүүлийн буюу Буэнос Айрес Бага хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн байна:

- ✓ Хөдөө аж ахуйн асуудлууд (Agriculture Issues):
 - Улсын хүнсний нөөц бүрдүүлэх хөтөлбөрүүд (PSN - Public Stockholding Programs) - ДХБ-ын дүрмээр ДХБ-ын Гишүүд хөдөө аж ахуйн салбараас хүнс тэжээл худалдан авч, нөөцлөн, тараахыг зөвшөөрдөг боловч зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах явдлыг татаас гэж үздэг байна. Тэгэхээр ийм төрлийн дэмжлэгийг худалдаанд гаж нөлөө бүхий дэмжлэгийн тааз хэмжээ (ceiling on trade-distorting support)-г тооцоход харгалзан үздэг байна. G-33-ын бүлэг ийм хөтөлбөрийг худалдаанд гаж нөлөөгүй гэж үзэн, дэмжлэгийн ногоон хайрцаг (green box)-т оруулахын төлөө ажиллаж байна.
 - Дотоодын дэмжлэг (Domestic support)
- ✓ Загасны аж ахуйд үзүүлэх татаас (Fisheries Subsidies)
- ✓ Үйлчилгээний худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр байгуулах (Trade Facilitation in Services (TFS) Agreement) - энэ төслийг Энэтхэг Улс санаачилсан байдаг. Гол санаа нь

үйлчилгээний худалдаанд учирч буй хил дээрх болон хилийн доторх саад тотгорыг багасгах, улмаар арилгах явдал болно.


✓ Шинэ асуудлууд:

- Цахим худалдаа (E-Commerce) - Цахим худалдаа гэж бараа, үйлчилгээг цахим арга хэрэгсэл ашиглан үйлдвэрлэх, түгээх, сурталчлах, худалдан борлуулах, хүргэхийг хэлнэ. Цахим худалдааны асуудал ДХБ дээр 1998 оноос тавигдсан. Ингээд 1998 оноос эхлэн цахим дамжуулалт (digital transmissions)-д гаалийн татвар ногдуулах явдлыг түр зогсоох (Temporary moratorium on customs duty on electronic transmissions) шийдвэр гаргасан байгаа. Энэ хугацааг 2 жилд 1 удаа болдог дараа дараагийн Сайд нарын Бага хурлаар байнга сунгаж иржээ. Уг мораториумыг хугацаагүй болгох асуудал дэмжигдээгүй хэвээр үлдсэн. Ер нь цахим худалдааны асуудлаар хэлэлцээ эхлүүлэх саналууд бас дэмжигдээгүй байна. Цахим худалдааны асуудлаар хэлэлцээ хийвэл юуны түрүүнд дараах асуудлууд яригдах юм байна:

- гаалийн татвар ногдуулахгүй байх мораториум (WTO Moratorium on Custom duties);
- дижитал гэрчилгээ, цахим гарын үсэг (Digital certificates and electronic signatures);
- дижитал барааг хилээр оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэхэд тавих хилийн хяналтын арга хэмжээ (Border measures for digital goods in import, export and transit);
- төлбөр үйлдэх арга зам (Payment processing);
- онлайн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах (Online Consumer Protection);
- урилгагүй илгээсэн худалдааны цахим мессежүүд (Unsolicited Commercial Electronic Messages);
- завсрын этгээдийн хүлээх хариуцлага (Intermediary liability);
- мэдээллийг хил дамжуулан илгээх (Cross-Border Data Transfers);
- хувийн мэдээллийн нууцыг хамгаалах (Protection of Personal Information);
- Тооцооллын техник хэрэгсэл/серверийг орон нутагт (дотоодод)

суурилуулах явдлыг хориглох (Ban on Local Computing Facilities/Servers);


- интернэтийн төвийг сахисан бодлого (Net Neutrality);
- шифрлэх технологи (Encryption technology);
- эх кодоод нэвтрэх (Access to source code);
- оюуны өмчийн эрх (Intellectual Property);
- домейн нэр хаягийн дүрэм (Domain name rules);
- кибер технологийн аюулгүй байдал (Cybersecurity).
- Хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх (Investment Facilitation).
- Бичил, жижиг, дунд үйлдвэрийн газрууд (MSME - The Micro, Small and Medium Sized Enterprises) - Ихэнх улсад 10 хүртэл ажилтантай компанийг “микро пүүс” (micro firms) гэж үздэг байна. 10-250 ажилтантай компани нь жижиг болон дунд үйлдвэрийн газарт хамаардаг байна. Тэд том компаниудыг бодвол тарифын бус хязгаарлалт, хүнд нүсэр дүрэм журам, түүний дотор хилийн хяналтын тийм журмууд, тэдгээрийн ил тод бус байдал зэрэг худалдаа эрхлэх явцад учирдаг элдэв саад тотгор ихтэй, санхүүжилт олох тал дээр бэрхшээлтэй байдаг байна. Тиймээс тэдний асуудалд ДХБ-аас анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй гэж зарим Гишүүд үзэж байгаагаа илэрхийлсэн байна. Ихэнх улс оронд ажлын байрны жинтэй хувь нь бичил, жижиг, дунд үйлдвэрийн газруудад ногддог байна. Хөгжиж байгаа болон хөгжингүй аль ч улсад нийт ажлын байрны гуравны хоёр хувь нь тэдгээр үйлдвэрийн газарт ногддог байна.
- Жендерийн асуудал (Gender Issues) - Эмэгтэйчүүд дэлхийн хүн амын бараг тал хувийг эзэлдэг боловч дотоодын нийт бүтээгдэхүүний зөвхөн 37 хувийг үйлдвэрлэдэг гэнэ. Жижиг, дунд үйлдвэрийн газарт ажиллагсдын гуравны нэгийг эзэлдэг байна. Худалдаан дахь эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний эдийн засгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх нь энэ Бага хурлаас гаргасан Тунхаглалын гол санаа болно.



Зураг 10. ДХБ-ын бүтцийн схем


ДХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын газар

ДХБ-ын төв байр нь Женев хотноо байрладаг. ДХБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхий нарийн бичгийн дарга удирдана.



Зураг 11. ДХБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын схем

Дохагийн раунд

	<p>Шинэ ГАТТ-ын үед худалдааны олон талт хэлэлцээний 9 дэх раунд буюу Дохагийн раунд (Doha (Катар Улсын нийслэл) Round) 2001 оны 11 дүгээр сараас, өөрөөр хэлбэл, тэр үед хуралдсан Сайд нарын 4 дүгээр Бага хурлаас олгосон мандатын дагуу албан ёсоор эхэлж өнөөг хүртэл үргэлжилж байна. Энэ раундын хэлэлцээнд 159 улс оролцож байна. Энэ үед Хятадын тал тарифыг бууруулах шинэ формул санал болгосон байна. Энэ нь: $T_1 = (A + BP) T_0 / (A + P^2 + T_0)$ (T_1 - шинэ тариф, T_0 - хуучин тариф, A - хуучин тарифын дундаж, B - тохируулагч коэффициент бөгөөд 2010 онд $B=1$ байна, P - оргил фактор буюу $P = T_0 / A$ байна).</p>
---	---

Энэ раундын хэлэлцээ нь худалдааны элдэв саад тотгорыг багасгах, худалдааны дүрэм журмыг шинэчлэн тогтоох замаар олон улсын худалдааны системд өөрчлөлт (reform) хийх зорилготой. Ажлын хөтөлбөр нь худалдааны 20-иод салбарыг хамарч байгаа. Гол маргаан нь Европын холбоо, АНУ, Япон тэргүүтэй хөгжингүй орнууд, Энэтхэг, Бразил, Хятад, Өмнөд Африкийн БНУ тэргүүтэй хөгжиж буй орнуудын хооронд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн барааны тариф, тарифын бус саад тотгорууд, үйлчилгээ, худалдааны арга хэмжээнүүдийн асуудлаар өрнөж байна. Энэ раунд нь Дохагийн хөгжлийн хөтөлбөр (Doha Development Agenda - DDA) гэсэн хагас албан ёсны нэртэй. Энэ раундын үед мультилатерализм (олон талт ажиллагааг хөгжүүлэх бодлого) хөгжингүй зарим улсаас явуулж буй дараах бодлогын асуудлуудтай учирч байна (Multilateralism at cross-roads):

- АНУ дотогшоо чиглэсэн бодлого хэрэгжүүлэх болсон нь даяаршлыг буцах урсгал руу оруулж байгаа (US inward looking policies- reversal of globalization);
- АНУ Номхон далайг дамнасан түншлэлийн хэлэлцээрээс гарсан (Withdrawal from TPP);
- АНУ аюулгүй байдлыг хангах шалтгаар (ган төмөр болон хөнгөн цагаанд) импортын тариф тогтоож байгаа (Unilateral Tariff imposition invoking security reasons);
- Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг дахин хэлэлцэх болсон (Renegotiation of NAFTA);
- Их Британи Улс Европын холбооноос гарсан (Brexit).

Дашрамд дурдахад даяаршлыг хүчтэй шүүмжилж эхэлсэн нь дараах шалтгаантай байна:

- Даяаршлын ач тусыг хэт дэгсдүүлэн сурталчилж байгаа (Highly exaggerated claims of gains from globalization);
- Ил тод байдал дутагдаж байгаа (Lack of transparency);

- Хэн нь давуу эрх ашиг эдлээд байгаа нь тодорхой байгаа (Whose interest prevails?);
- Либерализац (худалдааг чөлөөтэй болгох бодлого)-ыг яарч, гүнзгийрүүлсэн нь олон орны эдийн засгийг гамшиг руу түлхэж байгаа (Premature and deep liberalisation has resulted in economic disasters in many countries);
- Хөгжингүй орнууд үнэн хэрэгтээ хуурамч дүр эсгэдэг (Inherent hypocrisy in the approach of developed countries);
- Шатаа хөлөөрөө түлхэн унгаж байгаатай адил үзэгдлүүд илэрч байгаа (Phenomenon of kicking away the ladder);
- Хөгжингүй орнууд олон улсын байгууллагыг өөрсдийн улс төрийн зорилгоор ашигласаар ирсэн (International institutions may have been used to serve the political ends of the developed countries).

Худалдааны бодлогын тоглоомын дүрэм

ДХБ нь худалдааны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ерөнхий хүрээг тодорхойлж өгдөг. Үр дүн ямар байх нь хамаагүй. Өөрөөр хэлбэл, худалдааны бодлогын тоглоомын дүрэм (the rules of the trade policy games) гэгчийг тогтоож өгдөг. ДХБ-д шинээр элсэн орох аливаа улс эхлээд ДХБ-ын Гишүүн бүх улстай (үндсэндээ дэлхийн худалдаанд нөлөө бүхий улс гүрнүүдтэй) хэлэлцээ хийх замаар өөрийн гэсэн тийм дүрмийг тохирч, ДХБ-ын хүрээнд өөрийн худалдааны уян хатан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх орон зай (flexibility and policy space)-гаа бүрдүүлдэг байна. Ийнхүү тохирсон дүрэм нь түүний ДХБ-ын бусад Гишүүдийн өмнө хүлээсэн үүрэг амлалт болно. Гэвч энэ дүрмийн дагуу зарим Гишүүн улс, жишээлбэл, тарифаа нааш цааш холхиулах бодлогын орон зай ихтэй байдаг бол зарим Гишүүн улс тийм бодлогын орон зай багатай байгаа нь үнэн юм. Гэхдээ энэ нь хэлэлцээ хэр сайн хийсний үр дүн учир яах ч аргагүй билээ.

Хүснэгт 15. ДХБ-ын гишүүн зарим орны тааз тариф 2015 оны байдлаар

Орны нэр	Бүх бараа		ХАА-н бараа		ХАА-н бус бараа	
	Ердийн дундаж тааз тариф	Хамгийн дээд тааз тариф	Ердийн дундаж тааз тариф	Хамгийн дээд тааз тариф	Ердийн дундаж тааз тариф	Хамгийн дээд тааз тариф
Хятад	10.0	65	15.7	65	9.2	50
Европын холбоо	4.8	152	10.9	152	3.9	26
Энэтхэг	48.5	300	113.5	300	34.5	150
Япон	4.4	595	16.6	595	2.5	371
Солонгос	16.8	887	57.9	887	10.2	253
Монгол	17.5	75	18.8	75	17.3	30
ОХУ	7.6	235	11.0	235	7.1	99
АНУ	3.5	350	4.8	350	3.3	55

Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах дараах 3 арга хэрэгсэл байна:

- ✓ Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ;
- ✓ Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ;
- ✓ Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ.

Хүснэгт 16. Худалдааны гажилт үүссэн тохиолдолд зохицуулах 3 арга хэмжээний харьцуулалт




	Демпингийн эсрэг арга хэмжээ (ADD - Anti-Dumping Duty)	Саармагжуулах арга хэмжээ (CVD - Countervailing Duty)	Хамгаалалтын арга хэмжээ (SGD - Safeguard Duty)
Арга хэмжээ авах үндэслэл	Холбогдох барааны демпингийг тогтоосон байна. (Dumping)	Холбогдох бараанд татаас олгосон нь тогтоогдсон байна. (Subsidization)	Холбогдох барааны импорт огцом өссөн байна. (Import surge)
Өрсөлдөөн	Шударга бус өрсөлдөөн (unfair)	Шударга бус өрсөлдөөн (unfair)	Шударга өрсөлдөөн (not unfair)
Хохирол	Материаллаг хохирол учирсан, эсхүл тийм аюул нүүрлэсэн байна. (Material injury or threat thereof)	Материаллаг хохирол учирсан, эсхүл тийм аюул нүүрлэсэн байна. (Material injury or threat thereof)	Ноцтой хохирол учирсан, эсхүл тийм аюул нүүрлэсэн байна. (Serious injury or threat thereof)
Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн	Адил бүтээгдэхүүн (Like products)	Адил бүтээгдэхүүн (Like products)	Адил, эсхүл шууд өрсөлдөх бүтээгдэхүүн (Like or directly competitive products)
Арга хэмжээнд хамрагдах улс	Тодорхой нэг улсаас ирэх импортын бараа (Country Specific)	Тодорхой нэг улсаас ирэх импортын бараа (Country Specific)	Аливаа улсаас ирэх импортын бараа (Irrespective of Source)
Нөхөн төлбөр	Олгохгүй (No compensation)	Олгохгүй (No compensation)	Олгох шаардлага гарч болно. (Compensation may be required)




ДХБ-ын мэргэжлийн хэллэгээр татаасыг ерөнхийд нь замын гэрлэн дохионы өнгө бүхий хайрцгаар ялгана: ногоон хайрцаг (green box) - зөвшөөрөгдсөн татаас; хув шар (шар, шаргал) хайрцаг (amber box) - хурдаа сааруулах буюу тоо хэмжээг нь багасгаж, хязгаарлалал зохих татаас; улаан хайрцаг (red box) - олгохыг хориглосон татаас. Хөдөө аж ахуйн хувьд энэ нь нэлээд ярвигтай. Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн дагуу хөдөө аж ахуйд үзүүлэх дотоодын дэмжлэгийн хувьд улаан хайрцаг гэж байхгүй. Гэхдээ хув шар (шар, шаргал) хайрцагны хүрээнд дотоодын дэмжлэгийг багасгахаар

амласан хэмжээнээсээ хэтрүүлэн үзүүлэх явдлыг хориглосон байдаг. Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийг хязгаарласан хөтөлбөрүүдтэй холбоотой татаасын хувьд хөх хайрцаг (blue box) гэж байна. Түүнээс гадна бас Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 2 дах хэсэгт зөвхөн хөгжиж буй орнуудад зориулсан тусгай болон хөнгөлөлттэй нөхцөл (special and differential treatment)-ийн талаар заасан байдаг. Тэдгээрийг заримдаа S&D хайрцаг буюу "хөгжлийн хайрцаг" ("S&D box" буюу "development box") гэнэ. Эдгээр хайрцгийг хүснэгтээр харьцуулан үзүүлбэл:

Хүснэгт 17. ДХБ-ын ХАА-н хэлэлцээртэй холбоотой хөгжлийн хайрцгийн харьцуулалт

Агуулга	Худалдаанд үзүүлэх нөлөө (Impact on Trade)	Болзол нөхцөл (Condition: limited or Unlimited)
 <p>Ногоон хайрцаг (Green Box): Бууруулах үүрэг амлалтаас чөлөөлөгдөх дотоодын дэмжлэг (Exempt Domestic Support)</p>		
<p>Энгийн үгээр хэлэхэд худалдаанд ямар нэгэн гаж нөлөө үзүүлэхгүй татаас буюу дэмжлэг энэ хайрцагт багтана.</p> <p>Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 2 дугаар хавсралт: Татаас буюу дэмжлэг үзүүлэх арга хэмжээ нь ерөнхий шалгуур үзүүлэлт (general criteria) болон тодорхой арга хэмжээний шалгуур үзүүлэлт (measure-specific criteria)-д тэнцэж байвал энэ хайрцагт багтана. Эдгээр нь татаас буюу дэмжлэгийг багасгах үүрэг амлалтаас чөлөөлөгдөх (exempt from reduction commitments), зөвшөөрөгдсөн арга хэмжээ болно. Хөгжингүй болон хөгжиж буй аль ч улсад хамаарна. Хөгжиж буй орнуудад зориулсан тусгай нөхцөлийн дагуу хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор улсын нөөц бүрдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, мөн хот, хөдөөгийн ядуу иргэдэд үнийн татаас бүхий хоол хүнс олгож болно. Энэ төрлийн арга хэмжээг төрийн санхүүжилттэй хөтөлбөрөөр (түүний дотор татваргүй) хэрэгжүүлэх бөгөөд хэрэглэгч нарт илүү үнээр шахаагүй, үйлдвэрлэгч нарт үнийн дэмжлэг (price support) үзүүлээгүй байна.</p> <p>Ногоон хайрцагт төрийн янз бүрийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, дархлах (environmental protection and conservation programs) болон бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөр, судалгааны ажлын санхүүжилт (research funding), хяналт шинжилгээний хөтөлбөр (inspection programs), дотоодын хүнсний тусламж, түүний дотор хүнсний хөнгөлөлттэй талон (food stamps), гамшигийг зайлуулах хөтөлбөр (disaster relief), малчид, тариаланчдад зориулсан сургалтын хөтөлбөр, шавьжны өвчинд хяналт тавих хөтөлбөр (pest-disease control program) хамаарна. Зарим тохиолдолд малчид, тариаланчдад шууд хэлбэрээр орлогын дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хамаарна. Гэхдээ энэ нь тодорхой бүтээгдэхүүний тухайн үеийн үйлдвэрлэл болон үнэд нөлөөлсөн байж болохгүй.</p>	<p>Худалдаанд гаж нөлөөгүй, эсхүл үл мэдэг гаж нөлөөтэй байх (No or Minimal trade distorting support)</p>	<p>Энэ хайрцагт багтах татаасыг хязгааргүй хэмжээгээр нэмэгдүүлж болно.</p>
  <p>Хув шар (шар, шаргал) хайрцаг (Amber Box): Бууруулах үүрэг амлалтаас үл чөлөөлөгдөх дотоодын дэмжлэг (Non-Exempt Domestic Support)</p>		
<p>Тодорхой нэг улсын бараа бүтээгдэхүүнийг өөр улсын нэг төрлийн, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад хямд өртөгтэй болгож, олон улсын худалдаанд гаж нөлөө үзүүлж байгаа татаас буюу дэмжлэг энэ хайрцагт багтана. Эдгээр нь худалдааны тэнцлийг гажуудуулдаг. Учир татаас буюу дэмжлэгийн улмаас тодорхой барааны үйлдвэрлэл хэт ихсэж, үнэ өртөг нь хямдардаг.</p>	<p>Худалдаанд хамгийн их гаж нөлөөтэй (Trade distorting)</p>	<p>Хатуу хязгаартай: Үе шаттайгаар (жил бүр) бууруулна.</p>

Агуулга	Худалдаанд үзүүлэх нөлөө (Impact on Trade)	Болзол нөхцөл (Condition: limited or Unlimited)
<p>Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 6 дугаар зүйл: Үе шаттайгаар бууруулах татаас. Эхлэл үе (the base period)-ийн хугацаанд татаас буюу дэмжлэгийг багасгах үүрэг амлалтаас чөлөөлөгдөхгүй дотоодын дэмжлэг (non-exempt domestic support) үзүүлж байсан 55 Гишүүн улс байсан. Тэд татаасаа бууруулах үүрэг амлалт авсан байгаа. Татаас буюу дэмжлэгээ бууруулах үүрэг амлалтыг дэмжлэгийн нийт нийлбэр дүн (Total Aggregate Measurement of Support - AMS)-гээр тооцно. Дэмжлэгийн нийлбэр дүн (AMS) гэдэгт тодорхой бараанд чиглэсэн татаас (product-specific support) болон тодорхой бараанд чиглээгүй татаас (non-product-specific support) хамтдаа тооцогдоно. Хөгжингүй орнууд эхлэл үе (the base period)-ийн хугацаанд үзүүлж байсан дэмжлэгийн хэмжээг 6 жилийн хугацаанд 20 хувиар, хөгжиж буй орнууд 10 жилийн хугацаанд 13 хувиар бууруулах ёстой. Ийнхүү бууруулахаар амласан хэмжээнээс хэтрүүлэн татаас олгохыг хориглоно.</p> <p>Шар хайрцагт зах зээлийн үнийг дэмжих арга хэмжээ (market price support measures), үйлдвэрлэлийн шууд татаас (direct production subsidies), эсхүл үйлдвэрлэлийн орцын шууд татаас (direct input subsidies), тухайлбал, цахилгаан эрчим хүч, ургамлын үр, бордоо, усжуулалт зэрэгтэй холбогдсон татаас хамаарна.</p>		
<p>Үл тооцох хувь (De Minimis Limit): Бууруулах үүрэг амлалтаас чөлөөлөгдөх дотоодын дэмжлэг (Exempt Domestic Support)</p>		
<p>Үл тооцох хувь нь хув шар (шар, шаргал) хайрцагт багтаагүй буюу тийм үүрэг амлалт аваагүй Гишүүн улсуудад хамааралтай. Үүнд үйлдвэрлэлийн өртгийн маш бага хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэгүүд хамаарна. Үл тооцох хувийг татаас буюу дэмжлэгийг багасгах үүрэг амлалтаас чөлөөлдөг (exempt from reduction commitments).</p>	Худалдаанд гаж нөлөөтэй (Trade distorting)	Хязгаартай: хөгжиж буй орнуудын хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өртгийн 10%, хөгжингүй орнуудын хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өртгийн 5%-иас хэтрэхгүй байна.
<div data-bbox="177 1279 403 1384" data-label="Image"> </div> <p>Хөх хайрцаг (Blue Box): Болзол нөхцөл хангасан бол бууруулах үүрэг амлалтаас чөлөөлөгдөх дотоодын дэмжлэг (Exempt Domestic Support)</p>		
<p>Энэ нь үндсэндээ хув шар (шар, шаргал) хайрцагт багтах татаас буюу дэмжлэгүүд юм. Гэхдээ эдгээр нь үйлдвэрлэлийг хязгаарлах зорилготой байна. Эдгээр нь зах зээлд гаж нөлөөтэй гэж үздэг боловч, үйлдвэрлэлийг хязгаарлаж өгдөг.</p>	Худалдаанд гаж нөлөөтэй татаас (Trade distorting)	ДХБ-ын бүх Гишүүдийн хувьд хязгааргүй, гэхдээ болзол нөхцөлтэй
<p>Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 6.5 дахь хэсэг: Ердийн тохиолдолд шар хайрцагт багтах боловч малчид, тариаланчдыг үйлдвэрлэлээ багасгахыг шаардсан аливаа татаас хөх хайрцагт хамаарна. Эдгээр татаас буюу дэмжлэг нь татаас буюу дэмжлэгийг бууруулах үүрэг амлалт авахаас чөлөөлөгдөнө.</p> <p>Эхлэл үе (base period)-ийн үйлдвэрлэлийн 85 буюу түүнээс доош хувьтай тэнцэх төлбөр энэ хайрцагт хамаарна.</p> <p>Хөх хайрцагт тариалангийн газрыг тодорхой хэмжээний га газраар хязгаарласан, эсхүл ургацын хэмжээг тодорхой тоо хэмжээгээр хязгаарласан, мөн мал амьтныг тоо толгойгоор хязгаарласан хөтөлбөрүүд хамаарна. Малчид, тариаланчдыг үйлдвэрлэл нь холдуулах зорилготой төлбөрүүд (decoupled payments) ногоон хайрцагт хамаарах боловч хөх хайрцагны хувьд тийм төлбөр авахын тулд тэд үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн явуулж байх ёстой байдаг. Гэхдээ бодит төлбөр нь тухайн үеийн үйлдвэрлэлийн тоо хэмжээнд хамааралгүй байна. Ийм төрлийн татаасыг Норвег, Исланд, Словени зэрэг цөөн тооны улс өгдөг.</p>		

Агуулга	Худалдаанд үзүүлэх нөлөө (Impact on Trade)	Болзол нөхцөл (Condition: limited or Unlimited)
S&D хайрцаг буюу "хөгжлийн хайрцаг" (S&D Box, Development Box): Бууруулах үүрэг амлалтаас чөлөөлөгдөх дотоодын дэмжлэг (Exempt Domestic Support)		
Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 6.2 дах хэсэг: зөвхөн хөгжиж буй орнуудад зориулсан тусгай болон хөнгөлөлттэй нөхцөл (special and differential treatment)	Худалдаанд гаж нөлөөтэй (Trade distorting)	Хөгжиж буй орнууд бага орлоготой, эсхүл санхүүжилт байхгүй малчин, тариаланчдад үйлдвэрлэлийн орц (input)-ын болон хөрөнгө оруулалтын хязгааргүй хэмжээний татаас үзүүлж болно.
Улаан хайрцаг (Red Box) 		
Хориглосон татаас. Үүнд ДХБ-ын хориглосон жагсаалтад тусгайлан оруулсан, эсхүл ДХБ-ын эрх зүйн баримт бичгүүдэд заасан зарим төрлийн экспорт, импортын татаас (дэмжлэг) болон тарифын бус саад тотгорууд хамаарна.		

Бүх татаас (дэмжлэг)-ыг дараах 3 төрөлд хуваана:

1. хориглосон татаас (дэмжлэг) (Prohibited Subsidies);
2. хариу арга хэмжээ авах татаас (дэмжлэг) (Actionable subsidies);
3. хариу арга хэмжээ авах шаардлагагүй татаас (дэмжлэг) (Non-actionable subsidies).

Зарим төрлийн хориглосон татаасын талаар:

- экспортын татаас (export subsidies) - шууд урамшуулал олгох (direct payments), хөнгөлөлттэй зээл олгох (low-cost loans), экспортлогч нарын татварыг хөнгөлөх (tax relief for exporters), эсхүл төрийн санхүүжилтээр олон улсын хэмжээнд сурталчилгаа явуулах (government-financed international advertising) зэргээр барааг дотоодод борлуулах сонирхлыг бууруулж, экспортлохыг дэмжсэн төрийн бодлого. Энэ нь гадаадын импортлогч нарт ашигтай болж, дотоодын хэрэглэгч нар гадаадын хэрэглэгч нараас илүү ихийг төлөх болдог байна. Бас инфляц үүсгэх талтай;
- дотоодын орцыг нэмэгдүүлэх татаас (local content subsidies): импортын бараанаас илүүтэйгээр дотоодын бараа ашиглахыг дэмжсэн татаас.

Хэрэв татаас (дэмжлэг) нь тусгай зорилготой (specific) бөгөөд сөрөг нөлөөтэй (adverse effects) бол хариу арга хэмжээ авах татаас (дэмжлэг) болно. "Сөрөг нөлөө" гэдэгт жишээлбэл дараах зүйлс хамаарна:

- ноцтой хохирол учруулах (Serious prejudice);
- дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулах (Injury to domestic industry);
- (Nullification and impairment).
- "Ноцтой хохирол учруулах" (Serious prejudice) гэдэгт дараах зүйлс хамаарна:
- татаас (дэмжлэг) олгосон улсын дотоодын зах зээл дэх импортын адил бараа өөр бараагаар солигдсон, эсхүл хашигдсан (displaced or impeded);
- гуравдагч улсын зах зээл дэх экспортын бараа өөр бараагаар солигдсон, эсхүл хашигдсан (displaced or impeded);
- барааны үнээ хэт багаар тогтоосон, үнээ буулгах шаардлага гарсан, үнийн хямрал үүссэн, эсхүл бусад Гишүүд худалдааны хохирол амссан (Significant price undercutting, price suppression, price depression or lost sales of another member);

- татаас (дэмжлэг) олгосон улсын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд эзлэх хувь хэмжээ ихэссэн.
- Хариу арга хэмжээ авах татаас (дэмжлэг) (Actionable subsidies)-ын хувьд дараах арга хэрэгсэл (remedies)-ийг ашиглана:
- тухайн татаас (дэмжлэг)-ын сөрөг нөлөөг арилгах, эсхүл эсхүл уг татаас (дэмжлэг)-ыг 6 сарын хугацаанд зогсоох (олон улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ - multilateral track);
- импортын бараанд саармагжуулах татвар ногдуулах (үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ - national track).

Дараах арга хэмжээ нь өнөөдрийн байдлаар хариу арга хэмжээ авах шаардлагагүй татаас (дэмжлэг) (Non-actionable subsidies)-ын жишээ болно:

- судалгаа шинжилгээний ажилд үзүүлэх тусламж;
- хөгжил дорой бүс нутагт үзүүлэх тусламж;
- одоогийн орчин нөхцөлийг шинэ шаардлагад нийцүүлэх зорилготой тусламж.

Хориглосон татаас (дэмжлэг) (Prohibited Subsidies)-т дараах арга хэмжээ хамаарна:

ДХБ-ын талаарх эерэг, сөрөг дүгнэлтүүд

ДХБ-ын талаар дараах 10 сөрөг дүгнэлт хийгдсэн байдаг боловч тэр бүгдийг ДХБ няцааж байна:

1. ДХБ нь бодлого тулгадаг (The WTO dictates policy). Гэвч тийм биш юм байна. Түүний үйл ажиллагааны чиглэлийг гишүүд нь өөрсдөө тогтоодог гэнэ. ДХБ нь түүний гишүүд Хэлэлцээр байгуулах, дүрэм батлах, консенсус (нэг ч эсрэг санал байхгүй бол тухайн шийдвэр батлагддаг)-ын аргаар шийдвэр гаргах журамтай ардчилсан байгууллага юм байна.
2. ДХБ нь чөлөөт худалдааг ямар ч үнээр хамааргүй олж авахыг эрмэлздэг (The WTO is for free trade at any cost). Бас тийм биш гэнэ. Юу өгөх, авалцах, ямар хүсэлт тавих, хариуд нь юу санал болгох зэрэг нэг улс нөгөөтэй юу тохиролцох нь тэдний хэрэг юм байна. Гэхдээ худалдаанд учирч буй элдэв саадыг багасгаж, худалдааг чөлөөтэй болгосноор бүх улс хожих юм байна.
3. ДХБ худалдааны ашиг сонирхлыг хөгжлөөс дээгүүр тавьдаг (Commercial interests take prior-

ity over development). ДХБ-ын Хэлэлцээрүүдэд хөгжлийг чухалчилсан заалтууд их байдаг тул энэ дүгнэлт нь худлаа гэнэ.

4. ДХБ худалдааны ашиг сонирхлыг байгаль орчныг хамгаалах асуудлаас дээгүүр тавьдаг (Commercial interests take priority over the environment). Гэтэл ДХБ-ын Хэлэлцээрүүдэд байгаль орчныг хамгаалах асуудлыг чухалчилсан заалтууд их бий гэнэ.
5. ДХБ худалдааны ашиг сонирхлыг эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах асуудлаас дээгүүр тавьдаг (Commercial interests take priority over health and safety). Гэвч ДХБ-ын Хэлэлцээрүүдийг ДХБ-ын гишүүд өөрсдөө баталдаг болохоор бас тийм биш гэнэ.
6. ДХБ ажлын байр хомсдуулж, ядуурлыг лавшруулдаг (The WTO destroys jobs, worsens poverty). Гэтэл харин ч эсрэгээр, худалдаа бол ажлын байр бий болгож, ядуурлыг бууруулах хүчтэй хэрэгсэл юм байна.
7. ДХБ-д жижиг орнууд хүчин мөхөс байдаг (Small countries are powerless in the WTO). ДХБ байхгүй бол жижиг орнууд бүр сул дорой байх болно гэнэ.
8. ДХБ бол хүчтэй лобби хийх зэвсэг (The WTO is the tool of powerful lobbies). Эсрэгээр, ДХБ нь явуургүй мөчид ашиг сонирхлыг хумих арга замыг гишүүн орнууддаа санал болгодог гэнэ.
9. Хөгжил дорой орнуудад сонголт байхгүй, тэднийг ДХБ-д элсэхийг тулгадаг (Weaker countries are forced to join the WTO). Гэвч ихэнх орнууд ДХБ-ын гадна байхыг хүсдэггүй гэнэ.
10. ДХБ-д ардчилал байхгүй (The WTO is undemocratic). ДХБ-д асуудлыг ихэвчлэн олонхийн санал (majority rule)-аар биш, консенсус (consensus)-аар шийддэг гэнэ. Ингэснээр бүгд зөвшөөрөхгүй бол ямар ч шийдвэр гарах ёсгүй гэнэ.

ДХБ нь амьдрал дээр (in practice)

- ✓ худалдааны “олон талт” систем (“multilateral” trading system) юм - Ихэнх улсууд, түүний дотор (дэлхийн) худалдаа эрхлэгч гол гол улсууд (the main trading nations) энэхүү системийн Гишүүн (олон талт хэлэлцээрүүдийн Талууд) болсон байгаа. Гэвч зарим улс орон түүнд хамрагдаагүй байгаа тул энэ системийг “глобал” (global), эсхүл “дэлхий нийтийн” (world) систем гэж нэрлэж болохгүй байгаа юм.

Зөвхөн ДХБ-ын Гишүүд л заавал тэдгээрийн Хэлэлцэн тохирогч Тал байж, тодорхой үүрэг хүлээдэг;

- ✓ хязгаарлагдмал талт хэлэлцээрүүд (plurilateral agreements)-тэй - тэдгээрт ДХБ-ын Гишүүд сайн дурын үндсэн нэгдэн орж, шинэ дүрмээр ажиллаж, шинэ үүрэг хүлээх сонголттой. Марракешийн хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтад дурдсан Иргэний нисэх онгоцны тухай Хэлэлцээр, Засгийн газрын худалдан авалтын тухай Хэлэлцээр, мөн ДХБ-ын дүрмээр явдаг (ДХБ-ын дүрэм үйлчилдэг) Санхүүгийн үйлчилгээний хэлэлцээр (Financial Service Agreement, 1997), Харилцаа холбооны үндсэн үйлчилгээний тухай хэлэлцээр (Agreement on Basic Telecommunications Services, 1997), Мэдээллийн технологийн хэлэлцээр (ITA - Information Technology Agreement, 1996), Хуурамч (дууриамал, хууль бус) бүтээгдэхүүний эсрэг тэмцэх худалдааны хэлэлцээр (ACTA - Anti-counterfeiting Trade Agreement, 2011) зэрэг нь тодорхой асуудалд суурилсан хязгаарлагдмал талт хэлэлцээрүүд (issue-based plurilateral agreements) юм. Цаашид үйлчилгээ, цахим худалдаа, стандарт ба нийцэл (TBT), гарал үүсэл зэрэг тодорхой асуудлаар ДХБ-ын дүрмийн дагуу явах хязгаарлагдмал талт хэлэлцээрүүд байгуулагдаж магадгүй юм. Бас өрсөлдөөн, хөрөнгө оруулалт зэрэг асуудлаар ДХБ-ын дүрмийн гадуур явах (ДХБ-ын дүрэм үл үйлчлэх) хязгаарлагдмал талт хэлэлцээрүүд байгуулагдаж магадгүй байна. Гэхдээ Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Trade-Related Investment Measures - TRIMs) 1994 онд байгуулагдсан байгаа;
- ✓ ГАТТ-ын XXIV зүйл болон ГАТС-ын V зүйлийг үндэслэн хөнгөлөлттэй (чөлөөт) худалдааны хэлэлцээр/бус нутгийн худалдааны хэлэлцээр (PTAs/RTAs) зэрэг тодорхой тооны улс оронд түшиглэсэн хязгаарлагдмал талт хэлэлцээрүүд (country-based plurilateral agreement) байгуулах хувилбартай;
- ✓ Гишүүдийн шийдсэнээр явна (Member-driven) - түүний үйл ажиллагааг гишүүн засгийн газрууд залж удирддаг;
- ✓ Нэгдсэн үүрэг амлалт (Single Undertaking) авхуулдаг - Энэ нь хэлэлцээний нэг арга техник (a negotiation technique), бас онолын зүйрлэл (a constitutive metaphor) юм. Бүгдийг нэг мөр тохиролцохгүй бол ямар ч тохиролцоо байхгүй гэсэн үг (Nothing is agreed until everything is agreed). ДХБ-ын хүрээнд хэлэлцээнүүд нь ээлж

дараалалтай бус (not sequentially), нэгэн зэрэг (simultaneously) явагддаг. Хэлэлцээний бүх үр дүнг бүх Гишүүн хүлээн зөвшөөрөх ёстой. Үндсэндээ хэлэлцээний асуудал бүрийг нэг бүхэл зүйлийн болон үл салж хуваагдах багц зүйлийн нэг хэсэг (part of a whole and indivisible package) гэж үздэг бөгөөд тэдгээрийг саланги байдлаар, тус тусад нь тохиролцдоггүй;

- ✓ харилцан зөвшилцил (консенсус)-ийн замаар шийдвэр гаргадаг (decision-making by consensus). Консенсус гэдэг нь аливаа нэг шийдвэр гаргах болсон шалтгааныг бүгд ойлгож, эсрэг санал байхгүй бол түүнийг бүгд хүлээн зөвшөөрч, дэмжиж байна гэж үздэг зарчим юм;
- ✓ заавал дагаж мөрдөх эрх зүйн үр дагавар бүхий баримт бичгүүд батлан гаргадаг (legally binding set of rules): ДХБ-ын цөм нь дэлхийн худалдаа эрхлэгч улс орнууд (the world's trading nations) хоорондоо хэлэлцэж, гарын үсэг зурсан уртаас урт, нарийн төвөгтэй хэлэлцээр (жагсаалтууд - schedules) байдаг. Эдгээр баримт бичиг нь олон улсын худалдаа эрхлэх эрх зүйн үндэс - дүрэм болдог (the legal ground-rules for international commerce). Эдгээр нь үндсэндээ засгийн газрууд худалдааны бодлогоо тохиролцсон хязгаарын хүрээнд хайрцаглан барих үүрэг амлалт бүхий заавал мөрдөх ёстой гэрээ юм.

4. Монгол Улсын үүрэг амлалтууд (Binding and Enforceable Commitments)

Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр ДХБ-ын 131 дэх Гишүүн болсон байна. Ингэхдээ Монгол Улс ДХБ-ын хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны Хэлэлцээрүүд (Plurilateral Trade Agreements)-ээс бусад бүх Хэлэлцээрт нэгдэн оржээ.

ДХБ-ын бусад Гишүүдийн нэгэн адил ДХБ-д элсэн орохдоо, мөн худалдааны олон талт хэлэлцээний үеэр тарифын болон тарифын бус хязгаарлалтын талаар Монгол Улсын авсан үүрэг амлалтууд хөнгөлөлтийн жагсаалт (a schedule (list) of concessions) болон бусад жагсаалтад орсон байдаг. Эдгээр жагсаалтад тарифын хувьд мөрдөж болох хамгийн дээд хязгаар буюу тааз амлалт (ceiling bindings), мөн дотоодын татаасын тааз хэмжээ зэргийг заасан байна. Аль нэг улс энэ үүрэг амлалтаа өөрчилж болно. Гэвч юуны өмнө өөрийн худалдааны түншүүдтэйгээ хэлэлцэн тохиролцох ёстой. Харин тийнхүү дахин хэлэлцээ хийхэд түншүүд нь өөрсдийн худалдааны

алдагдлаа нөхөх үүднээс илүү хатуу болзол нөхцөл тулгах болно.

Нэн тааламжтай тариф. Монгол Улс ДХБ-ын гишүүн болсноор бусад гишүүн орнуудын гарал үүсэлтэй бараанд гаалийн нэн тааламжтай тариф мөрдөх ёстой. 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулинд импортын гаалийн тарифыг ердийн (basic or general rate), нэн тааламжтай (the most favoured or the most favoured nation (MFN) rate), хөнгөлөлттэй (preferential rate) хувь хэмжээнээс бүрдсэн гурван баганатай байхаар заасан байгаа (2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар “хөнгөлөлттэй хувь хэмжээ” бүхий баганыг нэмсэн - ийм хувь хэмжээг Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу Японы гарал үүсэлтэй бараанд мөрдөж байгаа - энэ хэлэлцээрийн талаар энэ номын VIII бүлгээс үзнэ үү). Өнөөдрийн УИХ-аас баталсан 5%, 15%, 20%, 25%, 35%, 40%-ийн импортын гаалийн татварууд нь нэн тааламжтай тариф болно. Ердийн тариф нь нэн тааламжтай тарифаас 2 дахин их байна. ДХБ-ын гишүүн орнуудын туршлагаас үзвэл, ердийн тарифаа өндрөөр тогтоогоод ТХЕХ (ДХБ)-ийн хүрээнд хэлэлцээ хийж, буулт хийх замаар тодорхой нэг бараан дээр хэд хэдэн улстай өөр өөр тариф тохиролцдог байна. Түүний хамгийн бага тарифыг Парламент нь тухайн барааны хувьд нэн тааламжтай тариф болгон баталдаг байна.

Импортын гаалийн тарифын талаар авсан үүрэг амлалт. ДХБ-ын гишүүн болсноор Монгол Улс ихэнх барааныхаа импортын гаалийн тарифыг 20%-иас илүүгүй байлгах үүрэг авсан билээ. Мал, амьтан, үржлийн адуу, үхэр, гахай, хонь, ямаа, мэдээлэл түгээх төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл, мэдээлэл боловсруулах бусад машин, диод, транзистор, эмнэлгийн төрөл бүрийн тоног төхөөрөмж зэрэг 49 нэрийн барааг 0 (тэг) хувийн гаалийн татвартай байлгах амлалт авсан байна.

Экспортын гаалийн тарифын талаар авсан үүрэг амлалт. Экспортын барааны хувьд, ноолуурын экспортын гаалийн татварыг 10 жилийн дотор үнийн дүнгийн 30%-иас доош байлгах амлалт авсан. Өнөөдөр 19%-иас дээш ноолуурын агууламжтай сэв хялгасын 100 кг тутамд 4000 төгрөгийн татвар ногдуулж байгаа нь үнийн дүнгийн 30%-д хүрэхгүй байна. Нэгжид ногдуулсан тариф (specific rate)-ыг үнийн дүнд ногдуулах тариф (*ad valorem* rate)-т шилжүүлэх томъёо: $T_a = (T_s / V_{Unit}) 100\%$ (T_a - эцсийн *ad valorem* татвар, T_s - анхны specific татвар, V_{Unit} - импортын барааны нэгж үнэ).

Татаас. Бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортод гаргадаг гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд төрөөс татаас өгөх талаар Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулинд заасан механизмыг 2002 оны 12 дугаар сарын 31 гэхэд устгах үүрэг амлалт авсан байдаг.